

*НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН ЯАМНЫ 2007 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ САЙДЫН МЭДЭГДЭЛ*

Засгийн газраас 2007 оныг “Их бүтээн байгуулалт-Шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил” болгон зарлаж, уг ажлын хүрээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэд хөдөлмөрчдийн идэвхи санаачилгаар 84,6 мянган ажлын байр шинээр бий болж, ажилгүйдлийн түвшин 0.3 пунктээр буурлаа.

Түүнчлэн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх чиглэлээр дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн жил байлаа. Төрийн албан хаагчдын дундаж цалинг 300 мянга, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 108 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлсэн нь төрийн болон хувийн секторт ажиллагчдын цалин хөлсний ялгааг арилгах, цалин хөлсний ерөнхий түвшинг дээшлүүлэхэд чиглэсэн чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо. Үүний зэрэгцээ төрийн албан хаагчдын ажлын ачаалал, мэдлэг боловсрол, мэргэшлийн түвшинд суурилсан, өндөр ур чадварыг илүү үнэлэх зорилго бүхий цалингийн шинэчлэлийг хийснээр төрийн албыг мэргэшсэн, чадварлаг байлгах чиглэлд тодорхой хувь нэмэр оруулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд ч зарчмын зарим өөрчлөлт гарлаа. Иргэдийн хувийн аж ахуй эрхэлж, амьдрал ахуйгаа хараат бусаар авч явах хүсэл сонирхол мэдэгдэхүйц нэмэгдэж, өмнөх жилүүдтэй харьцуулахад хамгийн олон буюу 13,0 мянга гаруй хүн жижиг зээл авсан байна.

Айл өрхөд тус дэм хүргэж, ахмад настнуудад анхаарал халамж тавьсан жил боллоо. Хүүхэд бүрт сар бүр 3,0 мянган төгрөг, улирал тутам 25.0 мянган төгрөг, шинээр төрсөн хүүхэд бүрт 100,0 төгрөг, шинэ гэр бүлд нэг удаа 500,0 мянган төгрөг, алдарт эхийн одонтой эхчүүдэд жилд нэг удаа 50,0-100,0 мянган төгрөг гэх мэтээр гэр бүл, эх хүүхдэд чиглэсэн тэтгэмж тусламжид нийтдээ 155,0 тэрбум төгрөг зарцуулсан нь манай төрийн бодлогын үр дүн юм. Ахмадуудын тэтгэврийг удаа дараа нэмэгдүүлж, олон жил ярьсан тэтгэврийн зөрүү арилгах асуудлыг шийдлээ.

Салбарын гадаад хамтын ажиллагаа өргөжин тэлж, түүний үр шим жирийн иргэдэд бодитой хүрсэн жил байлаа. Үүний нэг илэрхийлэл нь БНСУ-тай нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах гэрээ юм. Энэ гэрээний дагуу иргэдийнхээ БНСУ-д төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг эргүүлэн авч, өөрийн орны нийгмийн даатгалд хамрагдах боломжийг нээж байгаа нь улсдаа ч, иргэндээ ч давхар ач холбогдолтой чухал арга хэмжээ болов. ОХУ, Унгар, Чех, Турк, Япон улстай уламжлалт хамтын ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлж Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын Хүн амын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг гадаад түншүүдтэй үр дүнтэй хамтран ажиллав.

Ийнхүү 2007 он манай салбарын хамт олны хувьд ихээхэн хүчин чармайлт гаргаж, үр дүнд хүрсэн жил болж өнгөрлөө. Дээр дурдсан ололт, нааштай үйл ажиллагааг үндэслэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд дэвшүүлсэн 2007 оны үндсэн зорилт биелсэн гэж үзэж байна.

Ирж буй 2008 онд манай яам шийдвэрлэвэл зохих олон асуудлыг зорилт болгон тавьж байна. Тухайлбал, хөрөнгө оруулалт, жижиг зээл, ажилчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах үйл ажиллагаагаар дэмжин тусалж 80,0 мянган ажлын байр шинээр бий болгох ажлыг бусад салбаруудтай хамтран зохион байгуулна.

Мэргэжлийн сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, үндэсний ажиллах хүчний чадамжийг дээшлүүлэхэд онцгой анхаарна.

Нийгмийн даатгалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох замаар малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах талаар бодитой алхам хийнэ.

Төрийн албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын болон халамжийн сангаас олгох тэтгэвэр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 хувиар нэмэгдүүлэх болно.

Нийгмийн даатгалын санд ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээ буурсантай холбоотойгоор сангийн орлогыг бүрдүүлэх, хамралтын хүрээг өргөжүүлэх шинэ арга барил, хандлагыг төлөвшүүлэх юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих болон нийгмийн халамжийн үйлчилгээний чанар хүртээмж, арга хэлбэрийг сайжруулах, ялангуяа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээ авахыг зорьж байна.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэх нь манай яам, салбарын хамт олон, нийгмийн болон гадаад түншүүд, үйлчлүүлэгчдийн нөр их хөдөлмөрийн үр шим, хамтын ажиллагааны үр дүн байх болно.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН
САЙД Д.ДЭМБЭРЭЛ

НЭГ. БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхэлсэн асуудлын хүрээнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд 2007 он шийдвэрлэх жил байсан хийгээд “Монгол Улсын хууль тогтоомжийг 2008 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-д нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор тусгагдсан хуулийн төслүүдийг боловсруулж, шийдвэрлүүлэхэд ихээхэн хүчин чармайлт гарган ажиллалаа.

1.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын үр дүн:

Зах зээлийн эдийн засгийн харилцаа төлөвшин хөгжиж байгаа өнөөгийн нөхцөлд өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, хувиараа болон албан бусаар хөдөлмөр эрхлэгчид олширч, шинэ машин техник, тоног төхөөрөмж, технологи нэвтэрч, төрөл бүрийн үйлдвэрлэл, үйлчилгээ өргөжиж байна. Ийнхүү үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хэлбэр нэмэгдсээр байгаа боловч ажилтан, хувиараа, албан бусаар хөдөлмөр эрхлэгчдийн эрүүл мэнд, амь насыг осол эндэгдлээс хамгаалах, ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн эрх зүйн хамгаалалт хангалтгүй, энэ талаарх ажилтан, ажил олгогчийн үүрэг хариуцлага сул, ажиллах орчны физик, хими, биологийн сөрөг хүчин зүйлээс шалтгаалан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчинд олон хүн өртөж, эрүүл мэнд амь насаараа хохирох явдал гарсаар байна. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн стандарт” гэсэн 6 дугаар бүлэг болон Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль нь ажлын байрны нөхцөл, ажилтны осол авааргүй ажиллах нөхцөлийг хангах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг бүрэн зохицуулж чадахгүй байгаагаас тусгайлан хууль гарган зохицуулах шаардлагатай байгаа юм.

Энэхүү шаардлагыг харгалзан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, яамдын санал авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна. Хуулийн төсөлд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төрийн бодлого, үндсэн зарчмыг тодорхойлж, ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах, аюулгүй эрүүл орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, тэдгээрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, хяналтын бүтэц, энэ асуудлаарх төр, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хариуцлага, аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бий болгоход чиглэсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежменийн систем нэвтрүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн эрх зүйн зохицуулалтыг тусгаад байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгох, төлбөр өгөх асуудлыг зохицуулж байгаа боловч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тахир дутуу болсон хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудал өдий хүртэл зохицуулалтгүй явж ирсэн байна. Энэ нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин буурахгүй байх нэг нөхцөлийг бүрдүүлж байгаагийн

зэрэгцээ нөгөө талаар хөдөлмөрийн чадвар нь тэр бүр нөхөн сэргээгдэхгүй байгаагаас амьжиргаанд нь нөлөөлж, ядуурлыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулиар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтан, эдгээр тохиолдлоор нас барсан ажилтны ар гэрт учирсан хохирлыг багасгах зорилгоор ажил олгогч нөхөн төлбөр олгож байхаар 1999 онд хуульчилсан юм. Гэвч энэхүү зохицуулалт нь бүрэн хэмжээгээр хэрэгжиж чадахгүй, ажилтны эрх ашиг хохирсоор байна.

Иймд Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тахир дутуу болсон ажилтанд олгох нөхөн төлбөрийн талаар болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зардал гаргах шинэ зохицуулалтын талаар нэмэлт оруулахаар хуулийн төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барив. Хуулийн төсөлтэй холбогдуулан Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, мөн УИХ-д өргөн барьсан болно.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, байдалд судалгаа дүгнэлт хийж, илэрсэн зөрчил, дутагдлын учир шалтгааныг тодруулан арилгуулах, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ажлын байрны хэвийн нөхцөлийг хангуулах зорилгоор “Ажлын байрны аттестатчилал явуулах” асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Засгийн газрын 2007 оны 290 дүгээр тогтоолоор ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн аттестатчилал явуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий төв комиссын бүрэлдэхүүнийг баталж, аттестатчилалыг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан явуулахаар тогтсоны дагуу холбогдох журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлээд байна.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх эхний шатны төлөвлөгөө /2005-2007 он/-ний биелэлт, үр дүнгийн талаарх тайланг нэгтгэж, дүнг Засгийн газрын Засгийн газрын хуралдаанд танилцуулав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэгдүгээр шатны төлөвлөгөөнд тусгагдсан 38 асуудлаас 20 нь биелэгдэж, 18 асуудал нь хэрэгжих шатандаа байна.

“Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хууль 2001 онд батлагдан хэрэгжсэнээс хойш хуульд нэг ч удаа нэмэлт, өөрчлөлт ороогүй. Үүнтэйгээр холбоотойгоор хөдөлмөрийн гадаад шилжих хөдөлгөөний бүртгэл, мэдээллийг сайжруулах, зуучлагч байгууллагуудын үүрэг, хариуцлага, тэдгээрт тавигдах шаардлагыг өндөржүүлэх, хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох, нөгөөтэйгүүр төрөөс зуучлагчдад үзүүлэх үйлчилгээ, дэмжлэгийг өргөжүүлэхтэй холбоотойгоор төрийн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, хамтын ажиллагааг боловсронгуй болгох, зуучлах үйлчилгээнд төрийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх шаардлага гарч, сүүлийн 3 жил хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал яригдаж, боловсруулалтын явц удаашралтай байсан билээ. Уг асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, яамдын санал авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барив. Хуулийн төсөл боловсруулах явцад санал, зөвлөмж авах зорилгоор ОУХБ-ын Ази, Номхон далайн Бүсийн Товчооны зөвлөхүүдтэй хамтран ажиллав. Хуулийн төсөл батлагдснаар зуучлагч байгууллагуудын чадавхи, үүрэг, хариуцлага, тэдгээрт тавих шаардлага өндөржиж, гадаадад ажиллах иргэний

хөдөлмөрлөх эрхийн болон нийгмийн бусад баталгаа хангагдах нөхцөл бүрдэх юм.

БНСУ-д ажиллах хүч гаргах асуудлыг цэгцлэх зорилгоор ажиллах хүч гадаадад зуучлан гаргах үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэв. Засгийн газрын 2007 оны 36 дугаар тогтоолоор төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийг одоо энэ ажлыг эрхэлж байгаа компанитай хамтран зохих журмын дагуу байгуулан ажиллуулахаар шийдвэрлэсэн болно.

Түүнчлэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны дагуу Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам, БНСУ-ын Хөдөлмөрийн Яам хооронд байгуулсан 2006 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн БНСУ-д ажилчид илгээх тухай Харилцан ойлголцлын санамж бичгийг үндэслэн ажиллах хүч гадаадад зуучлах үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий "Ажиллах хүч гадаадад илгээх төв" төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газраар шийдвэрлүүлэв. Засгийн газрын 2007 оны 36 дугаар тогтоол гарсанаар БНСУ-д ажиллах хүч илгээх асуудлыг "Гадаадад ажиллах хүч илгээх төв" ХХК хариуцан гүйцэтгэж байна.

БНАСАУ-ын Ардын Дээд Хурлын даргын 2007 оны 7 дугаар сарын 20-23-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр "Ажиллах хүч харилцан солилцох тухай" Монгол Улсын Засгийн газар, БНАСАУ-ын Засгийн газрын хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан юм. Энэхүү хэлэлцээр нь хэлэлцэн тохирогч талуудын хуулийн этгээдүүдийн хооронд байгуулсан эсхүл байгуулах, Ажиллах хүч харилцан солилцох гэрээний дагуу Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх, ажиллах хүч харилцан солилцох асуудлыг зохицуулж байна. Хэлэлцээрийн хүрээнд 40 мянган айлын орон сууц, Мянганы зам зэрэг томоохон бүтээн байгуулалтын ажлуудад нарийн мэргэжлийн ажилчин, мэргэжилтэн дутагдалтай байгааг харгалзан талууд харилцан тохиролцсон эдийн засгийн тодорхой салбаруудад ажиллах хүч авах юм. Ингэхдээ талууд харилцан солилцох ажиллах хүчний тоо хэмжээг салбар бүрээр жил бүрийн эхэнд харилцан тохиролцож тогтоох бөгөөд энэ хэлэлцээрийн дагуу хөдөлмөр эрхлэх иргэдийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр хэлэлцээрт тусгасан болно.

"Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай" хуулийн 4.1.4-т заасны дагуу эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож байхыг үндэслэн "2007 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, холбогдох яамдын саналыг авч тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2007 оны 58 дугаар тогтоолоор батлуулав.

"2007 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 58 дугаар тогтоолоор "Гадаадын зээл, тусламж болон дотоодын хөрөнгө оруулалт, санхүүжилтээр улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, зам, барилга байгууламж барихад энэ тогтоолд заасан хувийг баримтлах боломжгүй бол Засгийн газарт танилцуулан шийдвэрлүүлж байхаар заасны дагуу тухай бүр Засгийн газарт асуудлыг танилцуулж, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон ажилтнуудаас шаардлагатай тооны ажилтны ажлын байрны төлбөрийг чөлөөлүүлэх асуудлыг 2007 оны 59, 111, 211 дүгээр тогтоолуудаар шийдвэрлүүлсэн байна.

Монгол-Оросын Засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээр дуусгавар болсонтой холбогдуулан Орос-Монголын хамтарсан “Монросцветмет” нэгдлийн гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрийн асуудлыг шинээр хэлэлцээр байгуулах хүртэлх хугацаанд өмнөх гэрээний дагуу зохицуулж байх асуудлыг Засгийн газрын 2007 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын харилцаанд 2006 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан хэдий ч эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогын арга хэмжээг өнөөгийн цаг үеийн шаардлагад нийцүүлэн оновчтой, шуурхай зохицуулалт хийх хэрэгцээ гарсаар байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн одоогийн баримталж байгаа үзэл баримтлалыг үндсээр нь өөрчилж, хамрах хүрээг өргөтгөн зөвхөн ажилгүй иргэдэд бус хүн амын бүлгүүдийн /залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, эмэгтэйчүүд/ хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглүүлэн тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, арга хэмжээг авч хэрэгжүүлэх зорилгоор хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулад байна.

Монгол Улсын Засгийн газраас 2007 оныг “Их бүтээн байгуулалт- Шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан 2007 онд шинээр бий болгох ажлын байрны тооцоо, судалгааг, аймаг, салбарын яамдаас гаргуулж нэгтгэн Засгийн газрын 2007 оны 71 дүгээр тогтоолоор батлууллаа. 2007 онд нийтдээ 80053 ажлын байр, тэдгээрийн 22500 нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний үр дүнгээр бий болохоор тооцоолсон юм. 2007 оны жилийн эцсийн байдлаар 92114 ажлын байр шинээр бий болсон бөгөөд барилга, бөөний болон жижиглэнгийн худалдаа, боловсруулах аж үйлдвэрийн салбарт дийлэнх нь бий болжээ.

“Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил”-ийн ажлын хүрээнд “Хөдөлмөрийн төв бирж”-ийг Улаанбаатар хотод байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2007 оны 194 дүгээр тогтоолоор батлуулав. Бирж байгуулагдснаар хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээг улсын хэмжээнд нийтэд нээлттэй, ил тод өргөн сонголттой, хүртээмжтэй болгох, иргэд болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний чанарыг сайжруулах, ажилхайгч болон ажил олгогчдод хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг шуурхай хүргэх боломж бүрдэх юм.

УИХ-аас 2007 оны төсвийн тодотголоор 1.5 тэрбум төгрөг, ХЭДС-гийн 2006 оны зарцуулагдаагүй үлдэгдэл болох 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгийг 2007 онд зарцуулах шийдвэр гаргасан. Нийт 3.5 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг хөдөө орон нутгийн алслагдсан сумдын иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох зориулалтаар олгохоор шийдвэрлэсэн болно. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2007 оны төсвийн тодотгол болон зээлийн хөрөнгийн хуваарилалтыг аймгуудаар гаргаж, батлуулж, мөрдүүлэв.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2007-2008 оны улсын хэлэлцээрт тусгуулахаар МҮЭХ, МАОЭНХ-ноос ирүүлсэн саналууд болон уг саналд үндэслэн боловсруулсан “Улсын хэлэлцээрт Засгийн газраас баримтлах чиглэл”-ийн төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 23 дугаар тэмдэглэлээр батлуулав. Түүнчлэн Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2007-2008 оны улсын хэлэлцээрт Засгийн газрыг

төлөөлөн оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар батлуулав.

“Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул уг бүрэлдэхүүнийг шинэчлэх санал боловсруулж, Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 35 дугаар захирамжаар батлуулав. ХНЗ-ийн гурван талт Үндэсний хорооны Засгийн газрын төлөөлөлд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын газрын гишүүн, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үйлдвэр худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга нарын бүрэлдэхүүнтэй байхаар тусгав.

1.2. Төрийн албан хаагчдын цалин хөлс, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх бодлогын үр дүн:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн албан хаагчдын болон төсөвт байгууллагад ажиллагчдын үндсэн цалингийн хэмжээг эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, төсөвт байгууллагын зардлын хэмнэлттэй уялдуулан нэмэгдүүлэхээр заасны дагуу төрийн албан хаагчийн цалинг 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 20 хувиар нэмэгдүүлэх асуудлыг судалж, холбогдох тооцоо судалгаа хийж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2007 оны 13 дугаар тогтоолоор батлуулав. Энэ арга хэмжээнд төрийн болон төсөвт байгууллагын нийт 124.6 мянган ажиллагчид хамрагдаж, сарын дундаж цалин нь 156.0 мянган төгрөгт хүрсэн байна.

Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад төрийн албан хаагчдын дундаж цалинг 2007 оны 10 дугаар сарын 1-нээс 250 мянган төгрөг болгохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2007 оны 237 дугаар тогтоолоор батлуулав. Энэ удаа нийт албан хаагчдын цалинг ижил хувь хэмжээгээр нэмэгдүүлдэг аргаас татгалзаж, цалингийн урамшуулах үүргийг өндөржүүлэх, албан тушаалын үүрэг, хариуцлага ачааллыг харгалзан цалин хөлсийг ялгаатай нэмэгдүүлэх зарчим баримталсан болно. Тухайлбал,

Уг тогтоолоор төрийн удирдах болон гүйцэтгэх албан тушаалын зэрэглэл хоорондын цалингийн зөрүүг нэмэгдүүлж зохистой харьцаанд оруулах, улс төрийн болон удирдах албан тушаалтны албан үүргээ нэр төртэй хэрэгжүүлэх боломж нөхцөлийг сайжруулах зорилгоор төрийн өндөр албан тушаалтан болон түүнтэй адилтгах албан тушаалтны цалинг 75 хувиар, улс төрийн албан тушаалтан, шүүх, прокурорын ажилтнуудын албан тушаалын цалинг 2,0 дахин нэмэгдүүлэв. Төрийн албан хаагчдын нэмэгдэл хөлсний системийг үе шаттайгаар боловсронгуй болгох алхам хийж төрийн захиргааны албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг хасч үндсэн цалинд нь шингээх, улс төрийн албан тушаалын ажил үүргийн онцлогийг харгалзан албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг нь 30 хувь болгон нэмэгдүүлэхээр шийдвэрлэв. Харин төрд туршлагатай, мэргэжлийн өндөр ур чадвартай албан хаагчийн хэрэгцээ өнөө ч байгааг харгалзан төрийн захиргааны албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдэл, ажил

үүргийн онцлогийг нь харгалзан төрийн тусгай албан хаагчдын бүх төрлийн нэмэгдлийг хэвээр үлдээв.

Түүнчлэн төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээний доод жишгийг шинжлэх ухаан, мэргэжлийн боловсрол, бага, дунд боловсрол, эрүүл мэнд, соёл урлаг болон нийтлэг үйлчилгээний гэсэн 6 дэд сүлжээ, доод жишиг болгон өөрчлөлөө. Ингэхдээ боловсролын салбарын багш, ажилчдад 3 сайдын хамтарсан тушаалаар тогтоон олгож байсан нэмэгдэл хөлс, 2004 онд эрүүл мэндийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу бий болсон эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалингийн өсөлтийг салбарын сүлжээний доод жишигт шингээн тооцов. Ингэснээр боловсрол, эрүүл мэндийн салбарт бий болсон цалингийн гажуудлыг арилгаж, гол мэргэжлийн албан хаагчдын цалин хөлсний түвшин ойролцоо тогтоож өглөө.

Дээрх арга хэмжээг авснаар төрийн албан хаагчдын дундаж цалин 55,0 хувиар, хамгийн бага тушаалын албан хаагчдын цалин 40,0-50.0 хувиар нэмэгдсэн бөгөөд 2007 оны сүүлийн улиралд **46,1** тэрбум төгрөг зарцуулав.

Түүнчлэн 2008 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 28.5 хувиар нэмэгдүүлж төрийн албан хаагчдын дундаж цалинг 300.0 мянган төгрөгт хүргэх асуудлыг судалж, Засгийн газрын 2007 оны 351 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлэв. Төрийн албаны тухай хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй уялдуулан төрийн тусгай албан тушаалын цалингийн сүлжээнээс бусад цалингийн сүлжээ, доод жишигт төрийн албан хаагчийн цалин хөлснөөс төлбөл зохих бүх төрлийн шимтгэлийн болон эрүүл мэндийн даатгалын хураамжийн төрийн байгууллагын төсвөөс нөхөн төлж байсан 80-аас доошгүй хувийг үндсэн цалинд нь шингээн тооцож оруулсан болно.

Цалин нэмэгдүүлэх арга хэмжээнд 129773 төрийн албан хаагч болон 18712 гэрээт ажилчин хамрагдаж байгаа бөгөөд 2008 оны суурь цалингийн сан 109.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 556.9 тэрбум төгрөг болж төрийн албан хаагчдын дундаж цалин 300.0 мянган төгрөгт хүрсэн болно.

Төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд улс төрийн албан тушаал эрхэлдэг баг, хороо, сум, дүүргийн Засаг даргын албан тушаалын цалингийг жишгийг тухай бүр шинэчлэн тогтоож, Засгийн газрын 2007 оны 14, 238, 352 дугаар тогтоолуудаар нэмэгдүүлэх арга хэмжээ авлаа.

Түүнчлэн “Төрийн өндөр албан тушаалын болон түүнтэй адилтгах албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай”, “Шүүгчийн болон прокурорын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” асуудлыг судалж, тухай бүр Засгийн газар, Улсын Их Хурлаар шийдвэрлүүлж ажиллав.

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлийг Засгийн газрын 1995 оны 94 дүгээр тогтоолоор баталж, мөрдүүлснээс хойш зарчмын шинжтэй өөрчлөлт хийгдээгүй явж ирсэн. Гэтэл энэ хугацаанд төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль шинээр, Төрийн албаны тухай хууль шинэчлэгдэн гарсны зэрэгцээ эрүүл, мэнд боловсрол зэрэг төрийн үйлчилгээний үндсэн салбаруудад эрх зүйн шинэчлэл эрчимтэй хийгдсэн байна. Иймээс эдгээр хууль тогтоомжийн агуулгад нийцүүлэн “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” асуудлыг судлан Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, холбогдох газруудын саналыг тусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2007 оны 236 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв. Тогтоолоор төрийн захиргааны албан тушаалын

ангилал, зэрэглэл бүрт хамаарах албан тушаалын товч тодорхойлолтыг шинэчилж, яамны Төрийн нарийн бичгийн даргын албан тушаалыг хуучнаас нь нэг шатлал ахиулж, төрийн захиргааны албан тушаалыг 14 шатлалтай болгов.

Төрийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр нутгийн захиргааны байгууллагын удирдлагын шат шатанд төсвийн ерөнхий менежерүүд бий болсон, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь бодлого боловсруулах, бодлогын удирдамжаар хангахаасаа илүү бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулах, төрийн үйлчилгээг иргэдэд гардан хүргэхэд чиглэж байгаагаараа онцлог байна. Энэ онцлогоос хамааран төрийн захиргааны байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэлийн тодорхойлолт нь нутгийн захиргааны байгууллагад тохирохгүй байгаа учраас төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалуудыг чиг үүрэг, хариуцлага, онцлогоор нь дүйцүүлэн жишиж зэрэглэв. Ингэхдээ орон нутгаас удаа дараа тавьж буй санал хүсэлт, нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын ажлын ачаалал зэргийг харгалзан сум, дүүргийн түвшний албан хаагчдын албан тушаалын зэрэглэлийг нэгээс хоёр шатаар ахиулав.

Төрийн үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын нэгдсэн ангилал зэрэглэлийг арав гаруй жил мөрдөж ирсэн хугацаанд эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээний томоохон салбаруудын албан тушаалын чиг үүрэг, нэр өөрчлөгдөж шинэ байгууллага, албан тушаалууд бий болсон учир албан тушаалын нэр, ангилал, зэрэглэлийг эдгээр хууль тогтоомжид нийцүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна. Түүнчлэн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал зэрэглэл нь салбарын болон ажил мэргэжлийн онцлогийг харгалзсан цалингийн тогтолцоог төгөлдөршүүлэхэд саад болж байдаг. Тийм учраас төрийн үйлчилгээний албан тушаалын нэр, чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчилж, ангилал, хоорондын ялгаа заагийг тодотгох зорилгоор салбар тус бүрийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг нарийвчлан хянаж, тогтоолд тусгалаа.

Аж ахуйн нэгж, компани, байгууллагуудад ажиллагчдын цалин хөлсийг төрөөс хянаж байх үндсэн механизм нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ байдаг билээ Эдийн засгийн өсөлт, инфляцын түвшин, хүн амын амьжиргааны өртөг, тэдгээрийн бодит орлогын өөрчлөлт, төрийн албан хаагчийн цалин нэмэгдэж байгаатай холбогдуулан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох зайлшгүй шаардлагатай байдаг.

Түүнчлэн Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-т: "...хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг жилд нэгээс доошгүй удаа Засгийн газар шинэчлэн тогтооно" гэж заасны дагуу 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс 69.0 мянган төгрөгөөр, 10 дугаар сарын 1-нээс 90.0 мянган төгрөгөөр, 2008 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэг цагт 642 төгрөг 85 мөнгө буюу сард 108000 /нэг зуун найман мянган/ төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо.

Засгийн газраас нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг 2007 онд нэмэгдүүлсэнтэй холбогдуулан нөхөн олговрын доод хэмжээг 2007 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн 11750 төгрөг буюу 29.3 хувиар нэмэгдүүлэн 51750 төгрөгөөр, 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 15750 төгрөг буюу 30.4 хувиар нэмэгдүүлэн 67500 төгрөг болгох асуудлыг судлан УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газар, УИХ-аар шийдвэрлүүлэв.

1.3. Нийгмийн хамгааллын талаарх бодлого, үр дүн:

Монгол Улсын нийгмийн хамгааллын тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нийгмийн даатгалаар дамжин хэрэгжиж байна. Нийгмийн даатгалын үйлчилгээний цар хүрээ жилээс жилд өргөжин тэлж байна. Өнгөрсөн онд нийгмийн даатгалын байгууллага **18.5** мянган ажил олгогч, **771.3** мянган даатгуулагчаас **157.7** тэрбум төгрөгийн шимтгэл цуглуулж, орлогын төлөвлөгөөгөө **101.6** хувиар биелүүллээ. Сангийн нийт орлогын хэмжээ 2000 оныхоос **2.8** дахин, 2005 оныхоос **1.3** дахин өсч, ДНБ-ний **7.1** хувьтай тэнцэж байна.

Монгол Улсын Их хурлаас Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд баталж мөрдүүлсэнээс хойш улс орны эдийн засаг, нийгмийн амьдралд нэлээд өөрчлөлт гарч байгаагаас нийгмийн даатгалын өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байгаа юм. Иймд Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулиудын төслийг боловсруулан холбогдох газруудын санал авч, Засгийн газрын 2007 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна. Хуулийн төсөлд нийгмийн даатгалын тогтолцоог боловсронгуй болгох, даатгалын хамрах хүрээг өргөтгөх, ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн хувь хэмжээг бууруулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох, Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлыг тусгалаа.

Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг УИХ-ын байнгын хороогоор хэлэлцэж эхэлсэнтэй холбогдуулан хуулийн өөрчлөлтийн дагуу үүсэх санхүүгийн тооцоо, судалгааг хийв. Хуулийн төслийг хэлэлцэх хугацаанд ажил олгогч аж ахуйн нэгжээс төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг бууруулж 10 пункт болгох, нийт хувь хэмжээг 20 хувиар тогтоохоор УИХ-д суудалтай эрх баригч намууд төлөвлөн, *2007 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр шимтгэлийн хувь хэмжээг 20 хувиар тогтоохоор хуулийг баталлаа.*

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, олон жил яригдсан **“тэтгэврийн зөрүү”-г** арилгах талаар нөөц бололцоогоо бүрэн дүүрэн дайчлан ажиллалаа. Тухайлбал, 2007 оны эхний хагас жилд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг Засгийн газрын 2007 оны 15, 109, 110, 241 дүгээр тогтоолуудын дагуу 4 удаа нэмэгдүүлэх арга хэмжээ авлаа. Үүнд:

Засгийн газрын 2007 оны 15 дугаар тогтоолоор тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээнд 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө нийгмийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэвэр тогтоолгон авч байсан 287,4 мянган тэтгэвэр авагч хамрагдлаа. Бүрэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр тогтоолгон авч байсан 114058 хүний тэтгэврийг 51750 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр тэтгэвэр тогтоолгон авч байсан 12833 хүний тэтгэврийг 34500 төгрөгөөр, бусад тэтгэвэр авагчдын тэтгэврийг 15 хувиар тус бүр нэмэгдүүлж нийт 9.9 тэрбум төгрөгийг энэхүү арга хэмжээнд зарцууллаа.

“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн итгэлцүүрийг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, холбогдох яамдын санал авч, Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 109 дүгээр тогтоолоор батлуулж, 2007 оны 7 дугаар сарын

1-ний өдрөөс мөрдүүлэв. Уг арга хэмжээний дүнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр бодох цалингийн шинэ итгэлцүүрийг хэрэглэж тэтгэвэр авагчдын тэтгэврийг дахин тооцоолсон бөгөөд нийт 60.2 мянган хүний тэтгэвэр дунджаар 16.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ арга хэмжээ тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээний үргэлжлэл болсон бөгөөд үүнд 1995 оноос өмнөх цалин хөлсөөрөө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр тооцох цалингийн итгэлцүүрийг нэг ангилалд оруулан, өнөөгийн үнэ ханштай харьцангуй ойртуулах арга хэмжээг авсан болно.

Үндэсний статистикийн газрын даргын 2007 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Хүн амын амжиргааны доод түвшинг батлах тухай” 01/41 дугаар тушаалаар амжиргааны баталгаажих түвшинг Улаанбаатар хотод 60.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосонтой холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох асуудлыг судалж, холбогдох тооцоо, судалгааг хийж, Засгийн газрын газрын 110 дугаар тогтоолоор шийдвэрлүүлэв. Уг тогтоолоор бүрэн тэтгэврийн доод хэмжээг 56250 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 37500 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс олгов. Бүрэн тэтгэврийн доод хэмжээ 51750 төгрөг байсныг 56250 төгрөг болгоход 133.0 хүн хамрагдаж 3.3 тэрбум төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 34500 төгрөг байсныг 37500 төгрөг болгоход 38.9 мянган хүн хамрагдаж 0.7 тэрбум төгрөг тус тус зарцуулсан байна.

Тэтгэврийн зөрүүг арилгах арга хэмжээнд 2007 оны сүүлийн хагас жилд 6.0 тэрбум төгрөг, доод хэмжээг нэмэгдүүлэхэд 4.0 тэрбум төгрөг, нийт 10.1 тэрбум төгрөг зарцуулсан болно.

2007 оны төсвийн тодотголыг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэх үед Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2007 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн 90.0 мянган төгрөгт хүргэж, шинэчлэн тогтоохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” Засгийн газрын тогтоолын төслийг холбогдох тооцооллын хамт боловсруулж, Засгийн 2007 оны 241 дүгээр тогтоолоор батлуулав. Уг тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 67500 төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 45000 төгрөгөөр тогтоож 2007 оны 10 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдүүлэхээр шийдвэрлэв. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд нийт **171.2** мянган хүн хамрагдаж **5.4** тэрбум төгрөгийн нэмэлт эх үүсвэр шаардагдсан бөгөөд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээ 20 хувь буюу бүрэн тэтгэврийн доод хэмжээ 11250 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 7500 төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн болно.

Мөн нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоохтой холбогдон хөдөлмөрийн үнэлэмжийг бууруулахгүй байх, тэтгэврийн зөрүүг арилгасан арга хэмжээний үр дүнг хэвээр хадгалах улмаар тэтгэврийн зохистой харьцааг хангах үүднээс бусад тэтгэвэр авагчдын тэтгэврийг нэмэгдүүлэх шаардлагатай байсан бөгөөд энэ арга хэмжээнд нийт 124.6 мянган хүн хамрагдаж, **3.4** тэрбум төгрөг нэмж зарцуулсан.

Тэтгэврийн доод хэмжээнээс бусад тэтгэвэр авагчдын тэтгэврийн хэмжээг дээрх зорилгоор нэмэгдүүлэхдээ 56251-67500 хүртэлх тэтгэврийг 11250 төгрөг, 67501-100.000 хүртэлх тэтгэврийг 10.000 төгрөг, 100.000-аас дээш хэмжээний бүрэн тэтгэвэр болон 37501- аас дээш хувь тэнцүүлсэн тэтгэврийг 7500 төгрөгөөр тус бүр нэмэгдүүлэхээр төлөвлөж холбогдох тооцоог боловсруулсан болно. Дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт **8.8** тэрбум төгрөгийн 5 тэрбумыг 2007

улсын нэгдсэн төсвөөр нийгмийн даатгалын санд батлагдсан хөрөнгийн эх үүсвэрээс, үлдэх 3.8 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн нэмэгдэл орлогоос бүрдүүлсэн болно. Энэ арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2007 оны эцэст нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн дундаж хэмжээ 80.2 мянган төгрөгт хүрч оны эхнээс **51.8** хувиар нэмэгдсэн байна.


Тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний дүнд 2007 оны эхний хагас жилд бүрэн тэтгэвэр авч байсан иргэдийн дундаж тэтгэвэр 58,3 мянган төгрөг байсан бол 69,2 мянган төгрөг болж дунджаар 18,7 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байсан иргэдийн дундаж тэтгэвэр 28,9 мянган төгрөг байсан бол 36,5 мянган төгрөгт хүрч 26,3 хувиар, дундаж тэтгэвэр 53,9 мянган төгрөг байсан бол 64,3 мянган төгрөг хүрч дунджаар 19,3 хувиар нэмэгдлээ.

Цэргийн албан хаагчийн бүрэн тэтгэвэр тогтоолгосон иргэдэд нэг удаагийн тэтгэмж олгох асуудлыг судалж, УИХ-ын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газар, УИХ-ын чуулганаар шийдвэрлүүлэв. УИХ-ын 2007 оны 88 дугаар тогтоолоор 1995 оноос өмнө цэргийн албан хаагчийн бүрэн тэтгэвэр тогтоолгосон иргэн бүрт нэг сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгохоор шийдвэрлэв.


2007 онд Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр авагчдын тоо, зарцуулсан хөрөнгө

№	Тогтоолын шийдвэр	Төрөл	Доод тэтгэвэр		Бусад тэтгэвэр		Зарцуулсан хөрөнгийн хэмжээ /тэрбум төг/
			Хүний тоо	Тэтгэврийн хэмжээ	Хүний тоо	Тэтгэврийн хэмжээ / дундаж/	
1	Засгийн газрын 2007 оны 15 дугаар тогтоол (2007.01.01-2007.07.01)	Бүрэн тэтгэвэр	114,000	51,750	160,500	58,300	9.9
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	12,900	34,500		28,900	
		Нийт	126,900	-		53,900	
2	Засгийн газрын 2007 оны 109 дугаар тогтоол (2007.07.01-2007.10.01)	Бүрэн тэтгэвэр	-	-	60,200	69,200	6.1
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	-	-		36,500	
		Нийт	-	-		64,300	
3	Засгийн газрын 2007 оны 110 дугаар тогтоол (2007.07.01-2007.10.01)	Бүрэн тэтгэвэр	133,000	56,250	-	-	3.3
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	38,900	37,500	-	-	0.7
		Нийт	171,900	-	-	-	4.0
4	Засгийн газрын 2007 оны 241 дугаар тогтоол (2007.10.01-2007.12.31)	Бүрэн тэтгэвэр	134,200	67,500	117,700	104,400	4.6
		Хувь тэнцүүлсэн тэтгэвэр	39,100	45,000		62,400	0.9
		Нийт	173,300	-		80,200	3.4

2007 онд Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн доод хэмжээ



2007 онд Нийгмийн даатгалын сангаас олгосон бусад тэтгэврийн хэмжээ



Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 4.2-т “Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, түүнчлэн төрийн өндөр албан тушаал эрхэлж байсан ахмад настанд улсын тусгай тэтгэвэр тогтоох нөхцөл, журмыг хуулиар тогтоож болно” гэж заасны дагуу “Алдар цолтой ахмад настанд тусгай тэтгэвэр тогтоох тухай хууль”-ийн төслийг боловсруулан Ерөнхийлөгчийн тамгын газарт хүргүүлсэн бөгөөд Ерөнхийлөгчийн захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс эцэслэн боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Хуулийн төсөлд алдар цолтой ахмад настанд цолыг харгалзан тусгай тэтгэвэр олгохоор заасан бөгөөд тусгай тэтгэврийн хэмжээг сард 150.0, 120.0 мянган төгрөгөөр тогтоохоор Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан хуулийн төсөлтэй хамт 2007 оны 10 дугаар сард УИХ-аар хэлэлцүүлэв. УИХ-аас төслийг хууль санаачлагчдад дахин боловсруулах үүрэг өгч буцаасан болно.

Монгол Улсад тэтгэврийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх 40608-01 MON-4910 төсөл хэрэгжихээр боллоо. Тус яамнаас Азийн хөгжлийн банкинд хандаж Монгол улсад Нийгмийн даатгалын сангийн бие даасан тогтолцоог бий болгох, тэтгэврийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хүссэний дагуу Люксембургийн Засгийн газрын дэмжлэгээр Монгол Улсад тэтгэврийн даатгалын тогтолцоог бэхжүүлэх 40608-01 MON-4910 төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна. Төслийн санхүүжилтийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгээр 500.000 US.\$, техник туслалцааны сангийн дэмжлэгээр нэмэлт 150.000US.\$ -аар нийт 650.000 US.\$-аар баталлаа. Төслийн хүрээнд одоогийн тэтгэврийн даатгалын тогтолцооны

давуу болон сул талыг тодорхойлох; өнөөгийн мөрдөж байгаа тогтолцоог өөрчлөх бодлогыг гаргах; даатгалын хамралтыг тооцоолох; хөрөнгийн зах зээлд тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудад дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтыг хийх стратеги, зааварчилгааг гаргах; тогтолцоог шинэчлэхэд шаардлагатай хуулийн өөрчлөлттэй холбоотой зөвлөмж гаргах асуудлуудыг шийдвэрлэхийг АХБ-наас тодорхойлж, баталсан байна. Төслийн багийнхантай санаачлага гаргаж, хамтран ажиллах шаардлагатай байна.

“Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах эмнэлгийн байгууллагуудыг сонгох журам батлах тухай” Засгийн газрын төсөл боловсруулж, холбогдох газраас санал авч, Засгийн газарт өргөн барив. Энэхүү журам батлагдсанаар тухайн орон нутгийн хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд төрийн болон хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагыг (анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг өрх, сум, сум дундын эмнэлгээс бусад) сонгон шалгаруулж, тусламж үйлчилгээний багцын санхүүжилтийг давхардуулахгүйгээр олгон, гүйцэтгүүлэх харилцааг зохицуулах боломжтой болох юм.

Эрүүл мэндийн даатгалыг хөгжүүлэх стратегийн бичиг баримтын төсөлд Олон улсын болон үндэсний зөвлөлдөх уулзалтын үед гарсан саналууд, бусад яамдын саналыг тусган боловсруулав. Эрүүл мэндийн яам стратегийн бичгийг зарчмын хувьд дэмжсэн боловч шинэчлэлийн үндсэн чиглэлийг дэмжээгүй. Иймд Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Германы техник туслалцааны байгууллагын санхүүжилтээр “Эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талуудын нийгмийн зөвшилцөл бий болгох, эрүүл мэндийн даатгалын стратегийн баримт бичиг боловсруулах” төсөл хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Даатгалын тогтолцоонд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

“Эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талуудын хамтын үйл ажилгааг сайжруулах, эрүүл мэндийн даатгалын стратеги боловсруулах” төслийн баримт бичиг боловсруулж Олон улсын хөдөлмөрийн байгууллагад хүргүүлэв. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Германы техник туслалцааны байгууллагын санхүүжилтээр уг төслийн эхний шатны үйл ажиллагаа болох даатгалын тогтолцоонд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлэв.

Нийгмийн халамжийн багц хуулийг шинэчлэн баталж мөрдүүлснээс хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд нийгмийн халамжаас үзүүлж байсан зарим төрлийн дэмжлэг туслалцаа өмнөх хүрсэн түвшингээсээ буурсан, тэдгээрийг нөхөх болон орлох үйлчилгээ хангалттай бус, шинэчлэлийг хэрэгжүүлэх боломж нөхцөл хот болон хөдөөд харилцан адилгүй, шинэчлэлийг хүлээн авах сэтгэл зүйн бэлтгэл дутмаг зэрэг олон шалтгааны улмаас уг үйлчилгээг хүртэгчдийн зүгээс УИХ-ын болон Засгийн газрын гишүүдэд удаа дараа хандаж санал хүсэлт тавьж байсан. Эдгээр санал хүсэлтийг судлан үзэж нийгмийн халамжийн тэтгэвэр болон үйлчилгээнд хамруулах шалгуур үзүүлэлт, нөхцөлт мөнгөн тэтгэмж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэр төрлийг оновчтой болгох зорилгоор “Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг санаачлан боловсруулж, Засгийн газрын 2007 оны 8 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн барьж шийдвэрлүүлэв.

Нийгмийн халамжийн багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төслүүдтэй холбоотойгоор нийгмийн халамжийн санд нэмж шаардагдах хөрөнгийн тооцоо судалгааг хийж, шаардагдах хөрөнгийг 2008 оны Төсвийн тухай хуульд тусгуулав.

Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаан болон УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлэв. Энэхүү хууль батлагдсанаар Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу олгодог байсан жирэмсэн эхийн тэтгэмжийг нь **амьжиргааны түвшин шаардахгүйгээр**, “Алдарт эх” 1, 2 дугаар зэргийн одонтой эхчүүдэд олгодог мөнгөн тусламжийг нь **нас харгалзахгүйгээр** олгохоор боллоо. Мөн энэхүү хуулиар хуулийн нэрийг өөрчлөн **“Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль”** гэж өөрчиллөө. Хууль 2007 оны 1 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн бөгөөд нэмж зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг 2007 оны төсөвт тусгуулав.

“Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль”-ийн 8.1 дэх хэсгийг үндэслэн жирэмсэн эхийн тэтгэмжийн хэмжээг сард 20.0 мянган төгрөгөөр тогтоох асуудлыг судалж, УИХ-ын 2007 оны 1 дүгээр сарын 4-ний өдрийн 2 дугаар тогтоолоор батлуулав. Мөн УИХ-ын 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одонтой эхэд 100.0 мянга, хоёрдугаар зэргийн одонтой эхэд 50.0 мянган төгрөгийг жилд нэг удаа давхардуулахгүйгээр олгож байхаар тогтоолоо.

Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан 2007 оны 2 дугаар сарын 6-ны өдөр УИХ-аар батлуулсан бөгөөд хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр анх удаа, шинээр гэр бүл болж байгаа хосуудад олгож байгаа 500.0 мянган төгрөгийн мөнгөн тусламжийг залуу гэр бүлд олгохоор өөрчилсөн юм. “Залуу гэр бүл” гэдгийг 35 хүртэлх насны гэж хуульчилсан болно. 2006 онд гэрлэлтээ бүртгүүлж бичиг баримтаа зохих ёсоор бүрдүүлсэн боловч **500,0** мянган төгрөгийн тусламжаа авч чадаагүй **24.5** мянган шинэ гэр бүлд **13.1** тэрбум төгрөг, 2007 онд гэрлэлтээ шинээр бүртгүүлсэн **21500** шинэ гэр бүлд олгох **10.7** тэрбум төгрөгийн нэмэгдэл эх үүсвэрийг 2007 оны төсвийн тодотголд тусгуулж, шийдвэрлүүлэв.

Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуулийн 6.1.3-д “эх, хүүхдийг дэмжих чиглэлээр хөрөнгө зарах”, 8.2-д “0-18 хүртэлх насны хүүхэд бүрт олгох мөнгөн хэмжээг зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлогоос хамааруулж Улсын Их Хурал жил бүр тогтоох бөгөөд түүнийг улирал тутам олгоно” гэж тус тус хуульчилсан юм. Түүнчлэн 2007 оны төсвийн тухай хуульд 0-18 хүртэлх насны хүүхэд бүрт жилд 100.0 мянган төгрөг олгоход зарцуулах зардлын хэмжээг 104.6 тэрбум төгрөгөөр тогтоов. Дээрх хуулиудыг үндэслэн “Хүүхэд бүрт мөнгө олгох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан Засгийн газрын 2 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, 2007 оны 43 дугаар тогтоолоор батлуулав. Уг тогтоолоор хүүхэд бүрт олгох 100.0 мянган төгрөгийг хүүхдийн нэр дээр нээсэн дэвтэр, банкин дахь мөнгөн хадгаламжийн дансаар дамжуулан улирал бүр хуваарилан олгохоор шийдвэрлэсэн байна.

“Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг өөрчлөн тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төсөл боловсруулан холбогдох яамдын санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн УИХ-ын 2007 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 75 дугаар тогтоолоор батлуулав. Уг тогтоолоор Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 26500 төгрөг байсныг 2007 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 34500 төгрөгөөр тогтоож 30

хувиар нэмэгдүүлээ. Энэхүү арга хэмжээнд нийт 45449 хүн хамрагдаж 2007 онд нэмж шаардагдах 2.2 тэрбум төгрөгийг төсвийн тодотголоор шийдвэрлүүлэв.

1.4. Хүн ам, нийгмийн бүлгүүдийн хөгжлийн бодлого, үр дүн:

“Хүн амын шилжих хөдөлгөөний асуудлаарх үндэсний дээд хэмжээний уулзалт”-ын зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх мэдээлэл бэлтгэн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэв. УИХ-аас хүн амын бүртгэл мэдээллийг сайжруулах, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, бүсийн төвүүд дэх эмчилгээ, оношлогооны төв, сургалтын цогцолборыг бэхжүүлэх, нийгмийн суурь үйлчилгээг цаг хугацаанд хүргэх, хүртээмжийг нь нэмэгдүүлэх талаар багагүй арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна гэж дүгнээд цаашдаа хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Монгол иргэд олноор амьдарч буй улс оронд хөдөлмөрийн атташе ажиллуулах, харьяаллаа сэргээлгэхээр хүсэлт гаргасан казак иргэдийн асуудлыг яаралтай шийдвэрлэх, мэдээлэл судалгаа, ялангуяа, иргэний бүртгэлийг асуудлыг цэгцлэх зэрэг асуудлаар зөвлөмж өгөв.

Гэр бүлийн хөгжлийг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, чиглэлийг тодорхойлон боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу Үйл ажиллагааны чиглэлд гэр бүлийн асуудлаарх үндэсний тогтолцоог боловсронгуй болгох, гэр бүлийн хөгжилд чиглэсэн Нийгмийн ажлыг хөгжүүлэх, гэр бүлд нийгэм, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг тодорхой төлөвлөгөө, үе шаттайгаар хөгжүүлэх, гэр бүлийн талаарх мэдээллийн сан бий болгох, шаардлагатай хөрөнгө, удирдлага зохион байгуулалт, хяналт үнэлгээ хийх зэрэг асуудлыг тусган эцэслэн боловсруулж, Засгийн газарт өргөн барив.

Засгийн газраас өгсөн үүргийн дагуу “Өрх, хүн амын амьжиргааны түвшинг тогтоох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж буй ажлын явцын талаар мэдээлэл бэлтгэж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн гишүүдийн саналыг тусган Засгийн газарт хүргүүлээд байна. Энэхүү ажлын хүрээнд уг аргачлалын үзүүлэлтийн нөлөөллийг судлан, хэрэглэхэд хялбар болгох, гарч байсан гажуудал, сургамжид үндэслэн зарим үзүүлэлтийг аргачлалаас хасах, зарим үзүүлэлтийн задаргааг нарийвчлах зэргээр боловсронгуй болгох санал боловсруулав.

Мянганы хөгжлийн зорилтын хоёрдугаар тайланд салбарын хариуцсан асуудлаарх мэдээллийг боловсруулж тусгуулав. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам Мянганы хөгжлийн зорилго 1-ийн 1, 3, 4 дүгээр зорилтыг хариуцан хэрэгжүүлж байгаа билээ. Амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах зорилтын хэрэгжилтийн тайланд цаашид шийдвэрлэх асуудлыг богино, дунд, урт хугацааны байдлаар тодорхойлов. Мөн 3 дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, тулгарч буй бэрхшээл, ололт амжилт, дутагдал, цаашдын зорилтын талаарх мэдээллийг тусган МХЗ-д тулгуурласан Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлогыг жендэрийн мэдрэмжтэй болгох, түүнд жендэрийн тэгш байдлыг хангах, гэр бүлийг хөгжүүлэхэд анхаарах зорилт, хэрэгжүүлэх арга зам, үр дүнгийн талаар санал боловсруулж хүргүүлэв. Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтуудын хэрэгжилтийн явцын тухай үндэсний хоёр дахь илтгэлийг УИХ-ын 2007 оны 8 дугаар сарын 16-ны нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, сайшаан зөвшөөрөв.

ХОЕР.БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

2.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилт, үр дүн:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалтын тогтолцоог сайжруулах, ажлын байраар хангах талаар:

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2007 оны төсвийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 13 дугаар тушаалаар батлуулж, төв, орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдэд хүргүүлж, хэрэгжилтийг зохион байгуулав. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хуулийн дагуу ажилд зучлах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах, жижиг зээл олгох, мэргэжлийн сургалт, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх зэрэг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд 2007 онд нийтдээ 151875 хүн хамрагдаж 7500.0 сая төгрөг зарцуулсан байна.

Монгол Улсын Засгийн газраас 2007 оныг “Их бүтээн байгуулалт- Шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил” болгон зарласан билээ. Энэхүү жилийн нээлтийн ажиллагааг 2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа. Жилийн ажлын нээлт нь их бүтээн байгуулалт, шинэ ажлын байр нэмэгдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, орон нутгийн хувийн хэвшил, аймаг, сум, хорооны идэвхитэй оролцоог хангах, үйл ажиллагаагаа уялдуулан ажиллахад чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

“Их бүтээн байгуулалт- шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд шинэ ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр дараахь ажлуудыг гүйцэтгэлээ.Үүнд:

- **“Шинэ ажлын байр - 2007” Үзэсгэлэн яармаг зохион байгуулав.**

Нийгмийн түншлэгч талуудтай хамтран “Шинэ ажлын байр – 2007” үзэсгэлэн яармагийг улирал бүр уламжлал болгон зохион байгууллаа. Үзэсгэлэн яармаг зохион байгуулсанаар ажил олгогчдын зүгээс хөдөлмөрийн зах зээлд шинээр бий болж буй ажлын байрыг нээлттэй зарлаж, ажлын байрны шаардлага хангасан ажил хайгчийг сонгон шалгаруулж, ажилд авах, ажил хайгч иргэдэд ажлын байрны нэг цэгийн үйлчилгээг үзүүлэх, жижиг, дунд болон шинээр бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад бизнесийн орчны талаарх мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг өгч ажил олгогч байгууллагын шинээр бий болгож буй ажлын байрыг олон нийтэд сурталчлан таниулах үр дүнтэй ажил боллоо.

- **Банкны удирдлагуудтай уулзалт зохион байгуулав.**

Жилийн ажлын хүрээнд жижиг зээл олгох замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа томоохон банкны удирдлагуудтай уулзалт зохион байгууллаа. Уулзалтын үр дүнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас банкуудаар дамжуулан олгогддог зээлийн талаар болон тус зээлийг олгоход яам болон банкуудын зүгээс харилцан анхаарах асуудлыг хэлэлцэж, зөвшилцсөнөөс гадна банк тус бүр өөрсдийн хөрөнгөөр болон төсөл хөтөлбөрүүдийн банкуудаар дамжуулан олгож байгаа зээлийн үр дүнд бий болж байгаа шинэ ажлын байрны талаарх мэдээллийг гаргаж ирүүлдэг боллоо.

- **“Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэе” Онол практикийн бага хурал зохион байгуулав.**

“Өрхийн үйлдвэрлэл” сэтгүүлийн 10 жилийн ой. Их бүтээн байгуулалт – шинэ Төрийн захиргааны удирдлагын газраас бэлтгэв.

ажлын байр нэмэгдүүлэх жилийн ажлын хүрээнд “Өрхийн үйлдвэрлэлийг хөгжүүлэе” Онол практикийн бага хурлыг Өрхийн үйлдвэрлэл сэтгүүлийн газартай хамтран зохион байгуулав.

- www.ejob.mn вэб сайт нээв.

Шинэ ажлын байрыг улсын хэмжээнд бүртгэх www.ejob.mn веб сайтыг ажиллуулж байна. Энэхүү веб сайтаар ажлын байрны мэдээ, мэдээлэл цуглуулж, шинэ ажлын байрны байршил, хаяг, хэдэн ажлын байр хаана, аль салбарт бий болж байгаа зэрэг мэдээллийг дэлгэрэнгүй авах нөхцлийг бүрдүүлсэн.

Мөн хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийг онлайн хэлбэрт шилжүүлэх зорилгоор ажил олгогчдоос ирүүлсэн ажлын байрны зарыг нэгтгэн вэб сайтад байршуулж эхлээд байна. Энэ ажлыг www.lavlav.mn сайттай хамтран хэрэгжүүлж байна. Эхний ээлжинд нийслэлийн 6 дүүргийн ажлын байрны зарыг байршуулав. Цаашид хөдөө орон нутгийн ХХҮХ-үүдэд ирүүлсэн ажлын байрны зарыг байрлуулж хэлтэс бүрт мэдээллийн электрон самбар байрлуулах ажлыг хийж байна. Мэдээллийн нэгдсэн сан байгуулснаар ажлын байрны захиалгыг нэг дороос харах боломжтой болсон юм.

- Сурталчилгааны самбарууд ажиллуулав.

www.ejob.mn вэб хуудсыг олон нийтэд мэдээлэх, зохистой ажлын байрыг дэмжих, улирал бүрийн “Шинэ ажлын байр” үзэсгэлэн яармагийн талаар болон жилийн ажлын үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэн сурталчлах зорилгоор зорилгоор баннер, сурталчилгааны самбаруудыг хэвлүүлж, замын хажуугийн гэрэлт самбарууд болон гудамжны самбаруудад мэдээлэл, сурталчилгаа байршуулав.

Ажилд зуучлал, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үйлчилгээ явуулж байгаа төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин, мэдээлэл солилцоог сайжруулах, тэднийг хамруулсан мэдээллийн сүлжээ, вэб хуудастай болох асуудлыг шийдвэрлэх зорилгоор “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөр зуучлалын албанаас ажилд зуучилсан үйлчилгээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг үзүүлэх төлбөрийн хэмжээ”-г НХХ-ийн сайдын 2007 оны 97 дугаар тушаалаар баталж, мөрдүүлэв.

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний чуулга уулзалтыг 2007 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ТГ, УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хороо, НҮБХХ, ОУХБ-тай хамтран зохион байгууллаа. Уулзалтаас зохистой хөдөлмөр болон албан бус салбарын талаарх төрийн бодлогын хэрэгжилтийг үндэсний болон орон нутгийн түвшинд эрчимжүүлэх, “Залуучуудад зохистой, бүтээмжтэй хөдөлмөр эрхлэх бодит боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн стратеги боловсруулж хэрэгжүүлэх” талаар улс орнуудын тэргүүнүүдийн хамтран шийдвэрлэсэн Мянганы тунхаглалд тусгагдсан асуудлыг хэрэгжүүлэх хүрээнд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний төлөвлөгөөний төслийг хэлэлцэж зөвлөмж гаргалаа.

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг БСШУ, НХХ-ын сайдын 2007 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 196/64 дүгээр хамтарсан тушаалаар байгуулав. Ажлын хэсгийн тус яамны төлөөлөл “Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн үзэл баримтлал”, “Мэргэжлийн боловсрол, сургалтыг хөгжүүлэх нийгмийн зөвшилцлийн санамж бичиг”-т зарчмын зөрүүтэй асуудлаар санал солилцож, зөвшилцсөний үндсэн дээр Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд

нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулав. Хуулийн төсөлд мэргэжилтэй ажилтан бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох, эрэлтэд тулгуурласан сургалтыг оновчтой зохион байгуулах, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн удирдлагаар хангах зэрэг зохицуулалтын эрх зүйн хэм хэмжээг тусгаж өгсөн нь иргэдийн хөдөлмөр эрхлэх чадвар дээшилж, эрх нь баталгаажих, үүний үр дүнд хүн амын ядуурлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангахад нөлөөлөх ач холбогдолтой баримт бичиг болох юм.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 96 дугаар тушаалаар Эрчим хүч, уул уурхай, барилга болон техникийн үйлчилгээний гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай томоохон компаниудтай гэрээ байгуулж ажилгүй иргэдийг ажлын байран дээр буюу үйлдвэрлэл дээр нь 4 сараас доошгүй сургалтанд хамруулж, тогтвортой ажлын байраар хангаж, сургалтын зардлыг нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлж байх шинэ журамд шилжлээ. Ингэснээр дотоодын ажиллах хүчнийг эрэлт, хэрэгцээтэй салбарт бэлтгэж, гадаадаас авах ажиллах хүчний тоог бууруулах боломж бүрдэх бөгөөд сургалтын материаллаг бааз, хүчин чадал дутагдалтай байгаа энэ үед мэргэжлийн ажилчдыг бэлтгэх зохимжтой арга хэлбэр боллоо.

Эрхийн бичгээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Барилгын ажилтаны мэргэжил дээшлүүлэх институттэй гэрээ хийж барилгын салбарын засал чимэглэл, өрөг угсрагч, гагнуур, цахилгаан, сантехник, бетон арматурчин, мужаан зэрэг чиглэлүүдээр эрхийн бичгийн дийлэнх хувийг, "Жижиг дунд үйлдвэрийн хөгжил" нэгдсэн холбоотой гэрээ хийж үсчин-гоо сайхан, худалдагч-нярав, тогооч-нарийн боов, зөөгч-бармен, гар урлал эсгүүр хатгамал, авто гэр ахуйн засвар зэрэг мэргэжлүүдээр аж ахуй эрхлэлтийн эрхийн бичгийн зохих хувийг Улаанбаатар, Дархан хотод түгээсэн байдалд үнэлгээ хийж, Барилгын салбарын эрхийн бичгийг Барилгын инженерүүдийн холбоо ТББ-тай гэрээ хийж түгээхээр гэрээг шинэчлэв. Эрхийн бичгийн гарын үсгийн баталгаажуулалтыг хийж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсэний дагуу эрхийн бичгийн сургалтыг зохион байгууллаа.

БСШУЯ, НХХЯ, Улаанбаатар хотын Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд, түншлэгч байгууллагууд хамтран "Хөгжлийн орц" мэдээлэл сурталчилгааны аяныг МҮЭ-ын Соёлын төв ордонд зохион байгуулж мэргэжлийн боловсролын байгууллага ажил олгогчийн хэрэгцээг сурталчилж өдөрлөг зохион байгуулав.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг дээшлүүлэх талаар:

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар болон нийгмийн түншүүд улсын гурван талт хэлэлцээрийг 2000 оноос эхлэн хоёр жилийн хугацаатай байгуулан хэрэгжүүлэх болсон. Түүнээс хойш хоёр жилийн хугацаагаар байгуулагдсан гурав дахь хэлэлцээр болох Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2005-2006 оны улсын хэлэлцээрийн биелэлтийг хэлэлцээрт оролцогч талуудын төлөөлөгчид 2007 оны 3 дугаар сарын 26-ны өдөр хамтран хэлэлцэж, 87,5 хувийн биелэлттэй гэж дүгнэснийг хэвлэл мэдээллээр нийтэд мэдээлж Зууны мэдээ, Өдрийн сонинд нийтлэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны 35 дугаар захирамжаар байгуулагдсан Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны хуралдааныг зохион байгуулав. Үндэсний хорооны дэд даргаар МАОЭНХ-ны ерөнхийлөгч Л.Нямсамбууг

зөвшилцөн сонгож, Монгол Улсын 2008 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2009-2010 оны төсвийн төсөөллийн талаарх Сангийн яамны мэдээллийг сонсож, энэ талаар талууд санал бодлоо илэрхийлэв. Нийгмийн түншлэгч талуудын зөвшилцлийн гол хэрэгсэл болох Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2007-2008 оны улсын хэлэлцээрт талуудын оруулж буй санал, бодлогын асуудлуудыг хорооны хуралдаанаар хэлэлцэж зөвшилцөн хорооны 2007 оны төлөвлөгөө, төсвийг батлуулж ажиллав.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2007-2008 оны "Улсын хэлэлцээрийг Засгийн газраас томилогдсон төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэйгээр 2007 оны 5 дугаар сарын 18-нд, үргэлжлэлийг 6 дугаар сарын 4-нд 10 дугаар сарын 3-ны өдрүүдэд хийж, зөвшилцөлд хүрч тохиролцон байгуулав. Улсын хэлэлцээрт Хөдөлмөрийн харилцааны бодлого, Хөдөлмөр эрхлэлт аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудлууд, Цалин хөлс нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн удирдлага нийгмийн түншлэл зэрэг 5 бүлэг 39 асуудал тусгагдсан болно. Улсын хэлэлцээрийг хэрэгжүүлэх хамтарсан төлөвлөгөөг Засгийн газрын яам агентлаг, МҮЭХ, МАОЭНХ-нд болон Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Мөн хэлэлцээрийн тухай хэвлэл мэдээлэлээр болон болон талуудын холбогдох бүтцээр орон нутагт хүргэн уг төлөвлөгөөний дагуу хэлэлцээний эхний жилийн ажил хийгдэж эхлээд байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2007 оны төлөвлөгөөний дагуу Зүүн бүсийн Дорнод, Хэнтий аймагт томилолтоор ажиллаж, гурван талт хэлэлцээрийн биелэлт, аймгийн гурван талт дэд хорооны ажил байдалтай танилцаж, "Орон нутгийн гурван талт нийгмийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх" асуудлаар сургалт уулзалт зохион байгуулав.

"Хамтын хэлэлцээр хийхэд байгууллага байгуулах ба эрхийн зарчмуудыг хэрэглэх тухай" ОУХБ-ын 1949 оны 98 дугаар конвенцийн 2005-2007 оны тайланг удирдамжийн дагуу гаргахын хамт ОУХБ-ын Конвенцийн хорооноос өмнөх тайлантай холбогдуулан явуулсан 2 асуулгын хариуг боловсруулж хүргүүлэв.

ОУХБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр нийгмийн гурван талт Үндэсний зөвлөлдөх уулзалтыг 2007 оны 11 дүгээр сарын 6-ны өдөр зохион байгуулж, "Хөгжлийн төлөө нийгмийн түншлэл 2005-2018 хөтөлбөр"-ийн төслийг танилцуулж, санал бодлоо солилцов. Түүнчлэн уулзалтын үеэр

- Нийгмийн зөвшилцөлд оролцогч талуудын мэдээлэл солилцох, зөвлөлдөх, яриа хэлэлцээр хийх, чадавхийг сайжруулах замаар гурван талт улсын хэлэлцээрийн механизмын үүргийг өндөржүүлэх;
- Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо дэд хороодын үйл ажиллагаа, үүрэг хариуцлагыг тодорхой болгож хөгжлийн бодлого боловсруулахад гурван талт бүтцийн үүргийг нэмэгдүүлэх;
- Аймаг, нийслэлийн түвшинд зөвшлийн гурван талт бүтцийг бэхжүүлэх, тэдгээрийн зөвлөлдөх болон хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт тавих, талуудын чадавхийг нэмэгдүүлэх замаар орон нутагт нийгмийн түншлэлийн үүрэг ач холбогдлыг нэмэгдүүлэх;
- Нийгмийн түншлэлийн үр нөлөөг аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцийн менежментийг хөгжүүлэх, ажилчдын мэргэжлийн ур чадвар бүтээмжийг дээшлүүлэх хөдөлмөрийн харилцааг төлөвшүүлэхэд чиглүүлэх үндсэн дээр хувийн хэвшлийг дэмжих зэрэг асуудлыг хэлэлцэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны захиалгаар ШУТехнологийн сангийн шугамаар МАОЭНХ-нд суурилсан нийгмийн түншлэгч талуудын багийн гүйцэтгэсэн

“Хөдөлмөрийн үнэлэмж, нөхцөл, хөдөлмөрийн харилцааны төлөвшилт, ажиллах хүчний чанарт хийх судалгаа”-ны дүнг гарган хэвлүүлж, олон нийт болон талуудад хүргүүлэв. Нийгмийн түншлэлийн хөгжлийн асуудлаар сонирхолтой шийдэл, туршилтын үр дүн, ажил хэрэгч санал, зөвлөмж агуулсан судалгааны дүгнэлтийг яамны вэб сайтад байрлуулав.

ОУХБ-ын дэмжлэгтэйгээр “Нийгмийн зөвшилцөл ба цалингийн тогтолцоо” сэдэвт гурван талт чадавхи бэхжүүлэх сургалтыг 2007 оны 11 дүгээр сарын 8, 9-ний өдрүүдэд зохион байгуулав. Сургалтад ОУХБ-ын Хөдөлмөрийн харилцааны ахлах мэргэжилтэн Чанг Хи Ли, Цалин хөлс хөдөлмөрийн институтын захирал Су Хайнан нар оролцож, төрийн болон хувийн хэвшлийн цалин хөлсний асуудлаар мэдээлэл өгч харилцан хамтран ажиллахаар тохиролцов.

Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаар:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тахир дутуу болсон, харьяалах байгууллагагүй иргэдэд нөхөн төлбөр олгох хөрөнгийн хуваарийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 17 дугаар тушаалаар батлуулав. Уг тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр тахир дутуу болсон, харьяалах байгууллагагүй иргэдэд нөхөн төлбөр олгох” аргачилсан зөвлөмж боловсруулан Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон аймаг, нийслэлийн дүүргүүдэд хүргүүлэв. Түүнчлэн Налайх дүүргийн Засаг дарга, нийгмийн даатгалын болон хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн дарга нарын уулзалтыг зохион байгуулж, сайдын тушаалыг хэрхэн хэрэгжүүлэх талаар арга зүйн зөвлөмж өгч ажиллалаа. Налайх, Булган, Хэнтий, Дорнод, Улаанбаатар хотын 1352 хүнд 197 сая 155 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг аймаг, орон нутаг, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсүүдээр дамжуулан олгов.

“Ажлын байрны аттестатчилал явуулах тухай” Засгийн газрын 2007 оны 290 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн аттестатчилал явуулах журмыг НХХ-ийн сайдын 2007 оны 134 дүгээр тушаалаар батлуулж, бүх аймаг, нийслэлийн дүүргийн Засаг дарга нарт хүргүүлэв. Ажлын байрны аттестатчилал явуулснаар хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, байдалд судалгаа дүгнэлт хийж, илэрсэн зөрчил, дутагдлын учир шалтгааныг тодруулан арилгуулах, цаашид хууль тогтоомжийг боловсронгуй болгох, ажлын байрны хэвийн нөхцөлийг хангуулах боломжтой болох юм.

Мэргэжлийн өвчин судлал, хөдөлмөр магадлалын төвийг “Мэргэжлийн өвчин судлалын үндэсний төв болгон өөрчлөн байгуулах тухай” асуудлыг НХХ-ийн болон Эрүүл мэндийн сайдын 2007 оны 121/282 тоот тушаалаар шийдвэрлүүлсэн нь мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэн оношлох, хөдөлмөрийн чадвар алдалтыг нөхөн сэргээх, төвийг техник тоног төхөөрөмжөөр хангах, нарийн мэргэжлийн эмч, ажилтныг бэлтгэхэд зохих ач холбогдолтой болж байна.

Даатгуулагч иргэдээс удаа дараа ирүүлж буй өргөдөл гомдлыг шийдвэрлэх үүднээс НХХ-ийн сайдын 2005 оны 77 дугаар тушаалд дараахь өөрчлөлтийг оруулав. Даатгуулагчийн ажиллаж байсан ажил, албан тушаал нь 1995 оноос өмнө “Тэтгэврийг хөнгөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-д хамаарагдах мэргэжлээр ажилласан хугацаа нь тэтгэврийг хөнгөлттэй нөхцөлөөр тогтоох болзол хангагдаж буй тохиолдолд тэтгэврийг хөнгөлттэй нөхцөлөөр тогтоож байхаар болов.

Улсын мэргэжлийн хяналтын газартай хамтран зүүн бүсийн хөдөлмөрийн болон хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагчдын 2 өдрийн сургалт семинарыг Дорноговь аймагт зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн явц, ажлын байрны аттестатчилал, хөдөлмөрийн харилцааны хууль тогтоомжийн хяналт шалгалтын ажлын арга барилын талаар мэдээлэл хийв.

БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн агентлагтай 2007 онд хамтран ажиллах санал боловсруулж, гадаад хамтын ажиллагааны хэлтсээр дамжуулан KOSHA-д хүргүүлж, харилцан тохиролцсоны дагуу БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн агентлагийн 2 зөвлөх мэргэжилтний 2007 оны 5 дугаар сарын 21-нээс 6 дугаар сарын 1-ны хооронд НХХЯ-д ажиллаж, ЭМЯ, УМХГ, МАОЭНХ, Дархан-Уул аймаг, Багануур ХК, Төмөр зам, Дулааны 4 дүгээр цахилгаан станц, Мэргэжлийн өвчин судлал, хөдөлмөр магадлалын төв зэрэг 10 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны эрүүл ахуйн болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн ажилтай танилцаж, зөвлөлгөө өглөө.

Нийгмийн түншлэлийн гурван талтай хамтран “Үйлдвэрлэлийн ослын улмаас амь үрэгдсэн ажилтны дурсгалыг хүндэтгэх өдөр” болох 4 дүгээр сарын 28-ны өдрийг угтсан ажлын төлөвлөгөөг баталж, сарын ажил угтсан ажлуудыг зохион байгуулав. Уг ажлын хүрээнд “Үйлдвэрлэлийн ослын өнөөгийн байдал, цаашдын зорилт” гэсэн сэдвээр Бизнесийн мэдээ сонинд бүтэн нүүр материал нийтлүүлж, осол гарч байгаа шалтгаан нөхцөл, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөрийн биелэлтийн явц, үр дүнгийн талаар олон нийтэд мэдээлэв. Уул уурхай, алтны үйлдвэрийн ажил олгогч, инженер техникийн ажилтан 50 гаруй хүн оролцсон 3 өдрийн сургалтыг ҮХЯ-тай хамтран Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийг түшиглэн зохион байгуулж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомжийн талаар болон үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга зүйн асуудлаар ярилцав.

”Арьс ширний үйлдвэрийн ажилтан, оршин суугчдын эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ хийсэн судалгааны ажлын дүн болон цаашид арьс ширний үйлдвэрт хэрэглэж байгаа химийн бодисын хор нөлөөг бууруулах талаар төсөл хэрэгжүүлэх уулзалтыг ҮХЯ, НМХГ, НЭМС-тай хамтран зохион байгуулж, “Ажлын байран дах хар тугалагын хэмжээнд тавигдах шаардлага”-ын стандарт боловсруулж, Стандарт хэмжил зүйн үндэсний төвөөр батлуулаад байна.

ОУХБ-ын Аж үйлдвэр, худалдаан дахь хөдөлмөрийн байцаан шалгах газрын тухай 81, Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай 161, Хөдөө аж ауйн үйлдвэрлэл дэх хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны 184 дүгээр конвенцид Монгол Улс нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлал, нэгдэн орох тухай хуулиудын төсөл боловсруулан, бүх яамд, холбогдох газруудаас санал авч, Засгийн газарт оруулахаар бэлтгэлээ.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудлаар ҮХЯ, БХБЯ, ЭМЯ-тай хамтран уул уурхай, алтны үйлдвэр, барилга, барилгын материал, хүнсний үйлдвэрийн ажил олгогч, инженер техникийн ажилтан 200 гаруй хүн оролцсон 2-3 өдрийн сургалт, мэргэжлийн өвчний талаар УМХГ-ын хяналтын байцаагчид, мэргэжлийн өвчний эмч нар оролцсон нэг өдрийн сургалт зохион байгуулав.

Хүн амын бүлгүүд, албан бус салбарын хөдөлмөр эрхлэлтийн талаар:

Монгол Улсын Их Хурлын 2005 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 25 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд”-ын 3 дугаарт тусгагдсан “Залуучуудад зориулсан аятай, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратеги боловсруулж хэрэгжүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний төлөвлөгөөний төслийг боловсруулав. Уг төлөвлөгөөний төслийг 2007 оны 11 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний чуулга уулзалтын үеэр хэлэлцүүлсэн болно. Түүнчлэн оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийн хөтөлбөрийг ХАС банктai хамтран хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн зорилго нь их дээд сургуулиудад төгсөх жилдээ суралцаж буй эсхүлзээл авах хүсэлт гаргахаас 1-ээс дээш жилийн өмнө их дээд сургууль төгссөн оюутнуудад бие даан бизнес эрхэлж, ажлын байр нэмэгдүүлэхэд зориулан нийтдээ 35 жижиг зээлийн төсөлд 72.3 сая төгрөг олгосон байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2007 онд 200,0 сая төгрөгийг их дээд сургууль төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жижиг зээлийн зориулалтаар 10 гаруй төсөл шалгаруулж 70 гаруй оюутан, төгсөгчдөд хөдөлмөр эрхлэх боломж олголоо.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 159 дүгээр тогтоолыг үндэслэн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансыг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын төслийг боловсруулж, НХХ-ийн сайдын 2006 оны 06 дугаар тушаалаар батлуулж, мөрдүүлэв. Тусгай дансны зорилго нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт нийцүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хөдөлмөрийн зах зээлд оролцох боломжийг дээшлүүлэхэд чиглэгдэх юм.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шинэ үйлчилгээ, арга хэмжээг туршин нэвтрүүлэх ажлыг бодлого, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 23 дугаар тушаалаар байгуулан ажиллав. Малчин өрхийн аж ахуй эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд малчин өрхийн аж ахуйгаа эрхлэх идэвх санаачилга, боломжийг нэмэгдүүлэх, залуу малчдад мал маллагааны тэргүүний арга барилыг өвлүүлэх, малчдын аж ахуйгаа үр ашигтай хэлбэрээр эрхлэн хөтлөхөд туслалцаа үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээг малчдад оновчтой хэлбэрээр хүргэхэд чиглэсэн “Малчдын аж ахуй эрхлэлтийг дэмжих” хөтөлбөрийг боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 111 дүгээр тушаалаар батлуулж ажиллав. Туршилтын хөтөлбөрт 4 аймгийн 19 сумын иргэд хамрагдлаа. Туршилтын хөтөлбөр хэрэгжүүлснээр малчдыг аж ахуйгаа хөтлөх шинэ арга барил, хандлага, эдийн засгийн тооцоотой ажиллах аргад сургах, тэдний амьжиргааг дээшлүүлэх, тэдэнд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний шинэ арга хэлбэрүүдийг бий болгох арга хэмжээ авч байна

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг бодлого, зохицуулалтаар хангах үүрэг бүхий гурван талт салбар зөвлөлийг Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн бүтцэд байгуулж, бүрэлдэхүүн, дүрмийг НХХ-ийн сайдын 2007 оны 02 сарын 13-ний өдрийн 21 дүгээр тушаалаар батлуулав. Салбар зөвлөлийн хуралдааныг 3 удаа зохион байгуулж, 2007 онд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай дансанд төвлөрүүлэх хөрөнгийн төлөвлөгөөний төсөл, хуваарилалт, ОУХБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

хөдөлмөр эрхлэлтийг эрх зүйн хүрээнд дэмжих нь” төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, ХБИ-ийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн дүн зэрэг 10 гаруй асуудлуудыг хэлэлцүүлж, салбар зөвлөлийн гишүүдийн саналыг тусган шийдвэрлүүлэв.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 238 дугаар тогтоолоор батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 3 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжигч ажил олгогчийг урамшуулах болзол, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих гурвалсан гэрээний загвар, ажил хайгч хөгжлийн бэрхшээлтэй иргэний бүртгэлийн маягтыг НХХ-ийн сайдын 2007 оны 2 дугаар сарын 13-ний өдрийн 20 дугаар тушаалаар батлуулан, холбогдох байгууллагуудад удирдамж, чиглэл өгч, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллав.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх ажлын хэсэг 2007 оны 5 дугаар сарын 22-ноос 6 дугаар сарын 6-ны хугацаанд Хөвсгөл, Орхон аймгууд, нийслэлийн Хан-уул, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргүүдэд ажиллав. Ажлын явцад 30 гаруй ААНБ дээр ажиллаж, 22 иргэн, төр, ТББ-ын 50 гаруй төлөөлөлтэй биечлэн уулзаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай данснаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрхийг хангах, тэдгээрийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үзүүлж буй үйлчилгээний үр дүнгийн талаар мэдээлэл цуглуулж, дүгнэлт гаргав. Хяналт шинжилгээний дүнг үндэслэн Хөдөлмөрийн болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиудад квотын тогтолцоог хэрэгжүүлэх механизмыг боловсронгуй болгох, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээ, арга хэмжээг өргөжүүлэх чиглэлээр 18 зүйл, 32 заалт бүхий нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн бариад байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тусгай данснаас Хараагүйчүүдийн сургалт, үйлдвэрлэлийн төвд олгосон 5.0 сая төгрөгийг цаасан уутны үйлдвэрлэл эхлэхэд зориулж, цаас, цавуу болон бусад эргэлтийн хөрөнгө худалдан авахад зарцуулсан ба одоогоор төслийн үйл ажиллагааг эхлэх бэлтгэлийг хангаж байна. Аж ахуйн нэгж, байгууллагаас цаасан уутны захиалга авч байгаа бөгөөд 2008 оны 1 сард үйл ажиллагаа эхэлснээр 10 хараагүй иргэн шинээр ажлын байртай боллоо.

ОУХБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг эрх зүйн хүрээнд дэмжих нь” төслийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажилласны үр дүнд НХХЯ, МАОЭНХ, МҮЭХ, ҮСГ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Үндэсний холбоо, Нөхөн сэргээлтийн үндэсний төв болон бусад ТББ-уудын шугамаар ХБИ-ийн хөдөлмөрийн статистик аргачлал, олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх стратеги, мэргэжлийн боловсрол олгох арга зүй болон сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах чиглэлээрх төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэж, ОУХБ-д хүргүүлээд байна.

ОУХБ-тай хамтран 3 сарын 6-7-ны өдрүүдэд Төрийн ордонд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчин” сэдэвт Үндэсний семинарыг зохион байгуулав. Семинарын явцад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт, тэгш хөдөлмөрлөх боломжийг хангах чиглэлээр эрх зүйн хүрээнд хийгдсэн шинэчлэл, түүнийг төв, орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй үйл

ажиллагаа, үр дүн, анхаарах асуудлын талаар холбогдох төр, төрийн бус байгууллагын ажилтнуудын илтгэлүүдийг хэлэлцэн, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, санал солилцов. Семинарын үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр 2007 онд ОУХБ-аас үзүүлэх техник, арга зүйн дэмжлэгийн хүрээ, санхүүжилтийн хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлэгч байгууллагуудтай зөвшилцөлд хүрсэн болно.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр 2006-2007 онуудад гарсан хууль тогтоомж, эрх зүйн актуудын эмхтгэлийг бэлтгэн, хэвлүүлж, мэдээлэл өгөх зорилгоор холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар 2007 онд хэрэгжүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн, удирдлага, зохицуулалтаар хангаж ажилласны дүнд ХЗДХЯ, ХХААЯ, БСШУЯ зэрэг яамд, ХТҮГ, УМХГ, ХЭҮК болон төрийн бус байгууллагуудын оролцоо сайжирч, хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлон ажиллаж байна.

Хүүхдийн хөдөлмөрийн асуудлаарх Үндэсний зохицуулах хорооны хуралдааныг 4 удаа зохион байгуулж, БСШУЯ, ХЗДХЯ, ХҮЭК болон бусад байгууллагуудаас хүүхдийн хөдөлмөрийн хууль эрх зүйн орчны олон улсын холбогдох конвенцид нийцэж буй байдал, хөдөлмөр эрхэлж буй болон алслагдмал нутагт амьдарч байгаа хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх стратегийг боловсронгуй болгох чадавхи бэхжүүлэх төслүүдийн гадна хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр 798.7 мян. ам долларын өртөг бүхий 16 төсөл, 10 гаруй гэрээгээр гүйцэтгэх ажлын саналыг хэлэлцүүлж, гишүүдийн саналыг тусган ОУХБ-ын Женевийн товчоонд хүргүүлж, хэрэгжүүлэх шийдвэрийг гаргуулав.

Хүүхдийн хөдөлмөрийн бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг Баянхонгор, Дорноговь, Өвөрхангай, Дорнод, аймгуудад ҮЗХ-ны болон ажлын албаны гишүүд ажиллаж, мониторингийн дүнг ҮЗХ-оор хэлэлцүүлж, анхаарах асуудлын зөвлөмж гаргаж, хэрэгжүүлэгч байгууллагуудад хүргүүлэв.

Төв, орон нутгийн түвшинд Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг дэлхийн өдрийг тэмдэглэх талаар Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 8 заалт бүхий Албан даалгаврыг гаргуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлэв. Уг өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг АЙПЕК хөтөлбөртэй хамтран боловсруулж, түүний дагуу 2007 оныг “Хөдөө аж ахуй дахь хүүхдийн хөдөлмөрт анхаарлаа хандуулья” уриан дор ХХААЯ болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүллээ.

Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын Конвенцийн хэрэгжилтийг хангах Шинжээчдийн хорооноос ирүүлсэн асуулгыг тусган “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай” ОУХБ-ын 182 дугаар, “Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай” ОУХБ-ын 138 дугаар Конвенциудын тайлан илтгэлийг монгол, англи хэл дээр бэлтгэн, ажилчдын болон ажил олгогчдын төлөөллийн байгууллагуудын саналыг тусган ОУХБ-д хүргүүлэв.

“Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого”, түүнийг 2006-2008 онуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу албан бус хөдөлмөр эрхлэгчдийн улсын үзлэгийг зохион байгуулав. Хөдөлмөрийн халамжийн үйлчилгээний газраас 12 дугаар сарын 15-ны байдлаар ирүүлсэн дүнгээр

үзлэгт 12 аймгийн 261 сум, 118 хороо, 812 багийн 81454 албан бус хөдөлмөр эрхлэгчдийн 41104 ажлын байр хамрагдсан байна. Тэдгээрийн 47468-д нь улсын нэгдсэн дугаар бүхий үнэмлэх олгогдсон. Үзлэгийн явцад 1054 удаагийн сурталчилгаагаар 78.5 мян хүнд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгсөн ба 19314 хүн нийгмийн даатгалд сайн дураар хамрагдсаны дотор 65.8 хувь нь эрүүл мэндийн, 19.6 хувь нь тэтгэврийн, 11.7 хувь нь тэтгэмжийн, 2.9 хувь нь ҮОМШӨ-ий даатгалд хамрагдсан байна. Үзлэгийн явцыг эрчимжүүлэх талаар орон нутгийн хэмжээнд 231 удаа мониторинг хийсэн ба үзлэгийг зохион байгуулахтай холбогдуулан 32.9 сая төгрөгийг зарцуулсан байна. ОУХБ-ын АЙПЕК хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын Да хүрээ, Нарантуул, Хүчит шонхор, Барс, Хар хорин, Өгөөмөр худалдааны захууд, Улаанчулуутын хогийн цэг, Налайх дүүргийн нүүрсний уурхайд албан бусаар хөдөлмөр эрхэлж буй 600 гаруй хүүхдийг бүртгэн, хүүхдийн хөдөлмөрийн талаарх сануулга болон холбогдох хууль тогтоомжуудыг 2500 гаруй эцэг эх, гэр бүлийн гишүүд, оролцогч талуудад сурталчлан таниуллаа.

Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд зорилусан мэдээлэл, сурталчилгааны ажлыг Монголын хувийн хэвшлийн ҮЭХолбоогоор гүйцэтгүүлэх асуудлыг НХХ-ийн сайдын 2007 оны 27 дугаар тушаалаар шийдвэрлүүлж, 3.5 сая төгрөг олгож, гэрээ байгуулан ажиллав. Гэрээний дагуу 741 албан бус хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, зохистой түншлэл, бизнесийн талаарх мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулж, 17 аймаг, Хархорин, Барс, Нарантуул захуудад ажиллаж буй бизнес эрхлэгчдэд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай болон нийгмийн даатгалын талаарх хууль тогтоомжуудын талаар 6 төрлийн гарын авлага, санамж бичгийг хэвлүүлэн, 60.0 мянга гаруй хүнд хүргэж, 3.0 мянга гаруй албан бус хөдөлмөр эрхлэгчдээс нийгмийн үйлчилгээний хэрэгцээг судалсан байна. Монголын хувийн хэвшлийн ҮЭХ-оос албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар хэрэгжүүлсэн дээрхи үйл ажиллагааны үр дүнд Улаанбаатар хотын Нарантуул, Хархорин, Булган, Хөвсгөл, Ховд, Орхон аймгуудын худалдааны төвлөрсөн захуудын албан бус хөдөлмөр эрхлэгчид шинээр 9 салбар холбоо байгуулан, 3984 хүн тэдгээрт нэгдсэн дүнтэй байна.

ОУХБ-аас албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд үзүүлэх дэмжлэгийн чиглэлийг тодорхойлж, холбогдох байгууллагуудад хүсэлт тавьсны үндсэн дээр Женев, Бээжингийн товчооноос зөвлөх үйлчилгээ авч, цаашид орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгцээг Орхон, Булган аймгуудад тодорхойлоод байна. ОУХБ-ын зөвлөх мэргэжилтнүүдтэй хамтран төслийн хамрах хүрээ, бүс нутгийг тодорхойлох шалгуур, бүтцийн ерөнхий загварыг боловсруулаад байна.

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаар:

Засгийн газрын 2007 оны 36 дугаар тогтоол, Төрийн өмчийн Хорооны 2007 оны 88 дугаар тогтоолын дагуу үүсгэн байгуулагдсан “Гадаадад ажиллах хүч илгээх төв” ХХК-ийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллав.

БНСУ-ын ажиллах хүч илгээх тухай харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Санам бичиг”-ийн хэрэгжилтийн талаарх улирлын мэдээний маягт, БНСУ-д ажиллах хүч илгээх ажлын зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээний загварыг боловсруулж, НХХ-ийн сайдын 2007 оны 120 дугаар тушаалаар

батлуулж, мөрдүүлэв.

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн хүрээнд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах зайлшгүй шаардлага, үндэслэл, хэрэгцээ, мэргэжлийн шалгуур тогтоох чиглэлээр ажиллах хүчин их шаардагдаж буй барилгын салбарт Барилга, хот байгуулалтын сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар журам боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Уг журмаар барилгын салбарт гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх асуудалтай холбогдон барилгын компани, Барилга, хот байгуулалтын яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны хооронд үүсэх харилцааг зохицуулж байна.

Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан тогтоолоор баталсан “Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан шалгах” удирдамжийн дагуу “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн хэрэгжилтийн байдлыг шалгаж, дүн болон цаашид авах арга хэмжээний саналын хамт Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороонд танилцуулав.

Монгол Улсын БНСУ-д суугаа ЭСЯ-нд Хөдөлмөрийн атташе ажиллах болсонтой холбоотойгоор Хөдөлмөрийн атташегийн ажиллах журмыг Гадаад хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 136/57 тоот хамтарсан тушаалаар батлууллаа. Ингэснээр Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Хөдөлмөрийн атташегийн БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа Монгол иргэдийн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудлыг хоёр орны холбогдох хууль тогтоомж, байгуулсан гэрээ, хэлэлцээр, санамж бичгийн дагуу зохицуулах, ажиллах хүч хүлээн авах, илгээх байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, иргэдийн хөдөлмөрлөх, нийгмийн хамгаалал авах эрхийг баталгаажуулах талаар үүргийг нь тодорхойлж өглөө.

“Аж ахуйн нэгж, байгууллагад гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох асуудлаар сайдад мэргэжлийн зөвлөгөө өгөх, санал боловсруулах ажлын хэсэг”-ийн ээлжит хуралдаануудыг зохион байгуулж, гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлөө сунгуулах, шинээр олгох хүсэлт тавьсан аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг судалж, санал боловсруулж ажиллав. Уг ажлын хүрээнд 2007 онд 16 байгууллагын Япон Улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар сунгах, 24 байгууллагад Япон Улсад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаагаар олгох асуудлыг шийдвэрлүүлэв.

Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, БНСУ-ын Хөдөлмөрийн яам хооронд байгуулсан “Санамж бичиг”-ийн дагуу БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах иргэдийн бүртгэлийн ажлыг зохион байгуулахад оролцов. Уг бүртгэлийг Солонгосын тал гардан зохион байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 15, 000 иргэнийг бүртгэв. Бэлтгэл ажлын явцад Солонгосын талтай зөвшилцөх, Монголын талын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах уялдаа холбоог хангаж ажиллав. Тухайлбал, шалгалтанд оролцох иргэд гадаад паспорттой байх ёстой гэсэн шаардлага, гэмт хэрэгт холбогдож байгаагүй гэсэн цагдаагийн газрын лавлагааг тус яамны тавьсан хүсэлтээр БНСУ-ын тал цуцалж гадаад паспортын оронд Иргэний бүртгэл мэдээллийн төвөөс авсан албан ёсны батламжийг ашиглахаар шийдвэрлэсэн байна.

Японы Үйлдвэрлэлийн дадлагын олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖИТКО-той хамтран ажиллах хүрээнд Япон Улсад үйлдвэрлэлийн дадлага эзэмшээд ирсэн иргэдийн үйл ажиллагааг сурталчлах уулзалтыг 2007 оны 6 дугаар сарын 7-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулах ажлыг гүйцэтгэв. Уг арга хэмжээнд ЖИТКО-гийн ерөнхийлөгч ноён Такано тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Уулзалтын үр дүнд 2008 онд илгээгч, хүлээн авагч талуудын үйл ажиллагааг уялуулах, харилцан мэдээлэл солилцох зорилгоор Япон Улсад хамтарсан семинар зохион байгуулахаар тохиролцов.

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, статистик мэдээллийн талаар:

2007 оныг Их бүтээн байгуулалт-Шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил болгон зарлаж 80000 шинэ ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд улсын хэмжээгээр шинээр бий болсон ажлын байрны мэдээг сар бүр авч албан ёсны захиргааны мэдээлэлд оруулах зорилгоор “Шинэ ажлын байрны бүртгэлийн 200... оны ...-р сарын мэдээ” /Маягт ШАБ-1-6/, “Шинэ ажлын байрны мэдээллийн маягт бөглөх заавар”-ыг 2 дугаар хавсралтаар, “Шинэ ажлын байрны бүртгэлийн сарын мэдээг бөглөхөд хэрэглэгдэх ойлголт, тодорхойлолт”-ыг ҮСГ-ын даргын 01/139 дугаар тушаалаар зөвшөөрүүлж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006 оны 116 дугаар тушаалаар батлууллаа. Энэхүү захиргааны статистик мэдээллийг бий болгосноор шинээр бий болж байгаа ажлын байрны мэдээг аймаг, нийслэл, сум, дүүрэг, нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэх, боловсролын түвшин, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал, сарын цалин хөлсний хэмжээ, ажлын үргэлжлэх хугацаа, хөдөлмөр эрхлэлтийн байдал, ажлын байр бий болсон хөрөнгийн эх үүсвэр, ХХҮХ-ээр ажлын байранд зуучлагдан орсон зэрэг үзүүлэлтүүдээр бүртгэж, үр дүнг хянаж, улсын хэмжээнд сар бүр мэдээлэх боломж бүрдэж байгаа юм.

Хөдөлмөрийн статистикийн тухай 160 дугаар Конвенц, 170 дугаар Зөвлөмжийн албан орчуулгыг хийж, Хөдөлмөрийн статистикийн тухай 160 дугаар Конвенцийг судлах асуудлаар НХХ-ийн сайдын тушаалаар нийгмийн түншлэгч талууд, ҮСГ-ын төлөөлөлтэйгээр ажлын хэсэг байгуулагдан ажиллав. ҮСГ гаргадаг захиргааны статистикаар далд ажилгүйдэл, ажлын цаг, ажиллах хүчний зардал, хөдөлмөрийн маргааны талаар тоо, мэдээ одоогоор улсын хэмжээнд гаргадаггүй тул уг Конвенцид нэгдэх боломжгүй байна. Нөгөөтэйгүүр уг Конвенцид хэсэгчилсэн байдлаар элсэх /зөвхөн гаргах боломжтой статистикийг ОУХБ-д гаргаж өгөх үүрэг хүлээх/ боломж байхгүй тул 160 дугаар Конвенцид нэгдэн орох боломжгүй гэсэн дүгнэлтийг ажлын хэсгээс гаргалаа.

Монгол Улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, БНСУ-ын Хөдөлмөрийн яам хоорондын БНСУ-ын хөдөлмөр эрхлэлтийг зөвшөөрөх тогтолцооны дагуу БНСУ-д ажилчин илгээх тухай харилцан ойлголцлын “Санамж бичиг”-ийн хэрэгжилтийн талаарх улирлын мэдээний маягт болон БНСУ-д ажиллах хүч илгээх ажлын зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээг НХХ-ийн сайдын 120 дугаар тушаалаар батлуулав. Шийдвэрийн дагуу “Гадаадад ажиллах хүч илгээх төв” нь БНСУ-д хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн мэдээллийг улирал бүр нас, хүйс, боловсролын түвшин зэрэг үзүүлэлтээр гаргаж, НХХЯ-нд ирүүлж байх журам тогтоов.

Төрийн бус байгууллагын нийгэмд эзэлж байгаа байр суурийг статистикийн аргачлал, арга зүйд нийцүүлэн албан ёсны статистик мэдээлэлд тусгах, энэхүү мэдээллийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх зорилгоор “Төрийн бус байгууллагын үйл ажиллагааны жилийн мэдээ” захиргааны мэдээллийн ТББ-2 маягтыг боловсруулж

Үндэсний статистикийн газрын даргын 01/10 тоот тушаалаар зөвшөөрүүлэн Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 22 дугаар тушаалаар батлуулж, мөрдүүлэв.

2.2. Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилт, үр дүн:

“Нийгмийн даатгалын тухай хуулиудыг хэрэгжүүлэх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай” 2007 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн Монгол Улсын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүдийн хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авав. Уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд урьдчилсан байдлаар нийт 4614 тэтгэвэр авагч хамрагдаж, 1.3 тэрбум төгрөгийн нэмэлт хөрөнгийг шийдвэрлүүлэв. 2006 оны сүүлийн хагас жилд хөдөө аж ахуй нэгдлийн гишүүний хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээгээр 27000 төгрөг, 2007 онд 34500 төгрөгийн тэтгэвэр авч байсан тэтгэвэр авагчдын тэтгэврийг бүрэн тэтгэврийн доод хэмжээ 51750 төгрөгт хүргэснээр нэг хүнд сард 13000-17250 төгрөгийн орлого нэмэгдэж байна. Уг арга хэмжээг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2007 оны 16 дугаар тушаалын дагуу зохион байгуулж, тэтгэврийг бүрэн хэмжээгээр нөхөн олголоо.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт, Солонгосын Нийгмийн хамгааллын тухай хууль, Монгол улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байсан Монгол иргэдийн тус улсын Үндэсний тэтгэврийн албанд шимтгэл төлж байсан хугацааг Монгол улсын тэтгэврийн даатгалд шимтгэл төлсөн хугацаанд шилжүүлэн тооцох тухай Нийгмийн даатгалын үндсэний Зөвлөлийн тогтоолын төслийг боловсруулж, батлуулав.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээний маягт, нийгмийн даатгалын сангийн авлага, өглөгийн мэдээний маягт, нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээний маягт нөхөх зааврыг боловсруулж, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 23/11 тоот хамтарсан тушаалаар батлуулж, мөрдүүлэв.

Шинэчлэн батлагдсан “Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль”, “Эрүүл мэндийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллав. Уг ажлын хүрээнд

- “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх журам”-ын төслийг УНДЕГ-тай хамтран боловсруулж Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулав.
- “Эрүүл мэндийн даатгалын сангийн эрсдэлийн нөөцийг зарцуулах журам”-ын төслийг боловсруулж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулав.
- “Эрүүл мэндийн тухай” хуульд 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хууль, “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай” хуульд 2006 оны 7 дугаар сард орсон нэмэлт өөрчлөлтөөр Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээний зардлыг оношийн бүлгээр санхүүжүүлэх шинэ төлбөрийн аргыг хэрэглэх болсон. Өртөг ойролцоо оношийн бүлгээр санхүүжүүлэх төлбөрийн аргыг хэрэглэх явцад оношийн бүлгийн тарифаар эрүүл мэндийн байгууллагууд санхүүжилтээ бүрэн авч чадахгүйгээс эмнэлгийн үйл ажиллагаа доголдоход хүрсэн. Иймд түүвэрлэсэн зарим эмнэлгүүдэд нэг даатгуулагчийн өвчний оношийн бүлгээр хэвтүүлэн эмчлэх болон амбулаторийн тусламж үйлчилгээний суурь тариф, оношийн бүлгүүдийн өртөгийн харьцуулалтаар коэффициент тооцох өртөгийн судалгаа хийв. Өртгийн

судалгаанд үндэслэсэн Эрүүл мэндийн даатгалын сангаас олгох даатгуулагчид үзүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлын хэмжээг тогтоох төсөл боловсруулав.

- Шинэ төлбөрийн арга хэрэглэх болсонтой холбогдуулан Эрүүл мэндийн байгууллага, Нийгмийн даатгалын хэлтсүүдийн мэдээллийг нэг орчинд хөрвүүлэх тусгай программ хангамжтай ажиллах, мэдээллээ боловсруулах аргачлалын талаар бүх аймаг, дүүрэг, клиникийн нэгдсэн эмнэлгүүдийн статистикийн эмч нарт сургалтыг Эрүүл мэндийн яам, УНДЕГ-тай хамтран зохион байгуулав.

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7.8 заалтын дагуу “Гурван жилийн хугацаанд эрүүл мэндийн даатгалын тусламж үйлчилгээ аваагүй даатгуулагчийг эрүүл мэндийн бүрэн үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ын төслийг боловсруулаад байна.

Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор “Даатгалын хамралтыг нэмэгдүүлсэн ажилтаныг урамшуулах журам”-ын төслийг УНДЕГ-тай хамтран боловсруулж, Эрүүл мэндийн даатгалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулав.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Германы техник туслалцааны байгууллагын санхүүжилтээр “Эрүүл мэндийн даатгалын харилцаанд оролцогч талуудын нийгмийн зөвшилцөл бий болгох, эрүүл мэндийн даатгалын стратегийн баримт бичиг боловсруулах” төсөл хэрэгжиж байгаа бөгөөд төслийн эхний шатны үйл ажиллагаанд буюу Даатгалын тогтолцоонд дүн шинжилгээ хийх ажлыг эхлүүлээд байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох асуудлыг судлан боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж, олон улсын хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоодог ангилалын дагуу жагсаалтыг шинэчилж, төслийг боловсруулав. Уг ажлын хүрээнд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, Засгийн газраар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн барилаа.

Зонхилон тохиолдох халдварт ба халдварт бус өвчний үзлэг, оношилгоо, шинжилгээний өртгийн судалгаа, тооцоо хийж, нэг удаагийн үзлэг, шинжилгээний тарифыг тогтоож, батлуулаад байна. Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 24-нийн өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлд заасны дагуу Зонхилон тохиолдох халдварт ба халдварт бус өвчний тархалтыг бууруулах ажлын хүрээнд зарцуулагдах 5.310 тэрбум төгрөгийн санхүүжилтийг 2007 оны улсын төсвийн тодотголд тусгуулав. Нийслэл, аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн хуваарийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан хуваарийн дагуу аймаг дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд санхүүжилтийг олгов. Эрүүл монгол хүн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Эрүүл мэндийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэгч байгууллагуудад хүргүүлэв.

Засгийн газрын 2006 оны 118 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тусламж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын дагуу Нийгмийн халамжийн сангаас хөнгөлөлттэй үнээр олгох протез, ортопедийн хэрэгслийн жишиг үнийг шинэчлэн тогтоож, мөрдүүлсэнээр Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу нэг удаагийн болон хөнгөлөлттэй үйлчилгээнд 29933 ахмад хамрагдаж 812.8 сая төгрөг,

6887 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж 267.8 сая төгрөгийн хөнгөлөлт эдэлсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, БСШУЯ-тай хамтран “Эрдэмтэд, эрдэм шинжилгээний ажилтнуудын нийгмийн хамгааллын асуудлууд” хэлэлцүүлгийг энэ сарын 23-нд зохион байгуулав. Хэлэлцүүлгээр шинжлэх ухаан, технологийн салбарын онцлог, улс нийгэмд үзүүлэх үр ашиг, шинжлэх ухаан технологийн санхүүжилт, тэнд ажиллагчдын цалин хөлс, нийгмийн хамгаалал, тулгамдаж буй асуудлын талаар Шинжлэх ухааны академи, НХХЯ, БСШУЯ, Сангийн яамнаас илтгэл мэдээллийг тавьж хэлэлцүүлэв. Хэлэлцүүлэгт төр, төрийн бус, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл 100 гаруй хүн оролцсон бөгөөд цаашид шинжлэх ухаан, технологийн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, нийгмийн хамгааллыг сайжруулах талаар зөвлөмж гаргалаа. Энэ удаагийн хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг бодит ажил хэрэг болгох үүднээс түүний хэрэгжилт, үр дүнг 2008 онд ахин хэлэлцэх юм.

Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг 2007 оны жилийн урьдчилсан мэдээгээр авч үзвэл:

Улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламж Үүнд:

- Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 938926 хүүхдэд 33.4 тэрбум төгрөг,
- Шинээр төрсөн 58258 хүүхдэд 5 тэрбум 825.8 сая төгрөг,
- Шинээр гэр бүл болсон 59774 өрхөд 29 тэрбум 887.0 сая төгрөг,
- Алдар цолтой 6193 ахмадуудад 718.1 сая төгрөг,
- Алдарт эхийн одонтой 130711 эхчүүдэд 8 тэрбум 520.4 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Нөхцөлт мөнгөн тэтгэмж, Үүнд:

- Жирэмсэн болон хөхүүл 65890 эхчүүдэд 12.5 тэрбум төгрөг,
- Ахмад настныг асарч буй 5446 иргэнд 691.8 сая төгрөг
- ХБИ-ийг асарч буй 8245 иргэнд 925.9 сая төгрөг
- Жирэмсэн болон амаржсан 111 эхчүүдэд 2.6 сая төгрөг,
- Хүүхэд асарсны тэтгэмжинд 19732 иргэнд 1.6 тэрбум төгрөг,
- Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжинд 350 иргэнд 57.0 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн хүрээнд 89910 ахмад настанд 2.2 тэрбум төгрөгийн, 19912 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 1.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, тусламж үйлчилгээг үзүүлсэн ба Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалаар хасагдсан, амьдралын боломжгүй ахмадуудыг уг үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авав.

Нийгмийн ажилтны ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолтыг боловсруулах, нийгмийн ажилтанд ноогдох үйлчлүүлэгчийн тоо, норматив, нийгмийн ажилтанд ажил үйлчилгээ явуулах эрх олгох, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, мэргэшлийн зэрэг олгох, нийгмийн ажлын үйлчилгээний магадлан итгэмжлэлийн журам боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан тушаалаар байгуулан ажиллаж байна.

Нийгмийн ажилтны 1 дүгээр шатны сургалтыг 2006 онд бүсчилж зохион байгуулсан бол 2007 оны 10 сарын 6-наас 11 сарын 26-ны өдрүүдэд нийгмийн

ажилтны 2 дугаар шатны сургалтыг зохион байгуулав. Энэ удаагийн сургалт нь нийгмийн ажилтанд *мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх*, хувь хүн, бүлэг, олон нийтийг зохион байгуулалтанд оруулах, оролцооны үнэлгээний аргаар үнэлгээ хийх, төсөл, хөтөлбөр боловсруулах, бүлэг, олон нийттэй ажиллах, олон нийтийн идэвхижүүлэхэд иргэдийг татан оролцуулах арга барил эзэмшүүлэхэд чиглэлээ. Сургалтад Аймаг, дүүргийн ХХҮХ-ийн 257 ажилтан, ЗДТГ-ын нийгмийн бодлогын 30 ажилтан, сум, хорооны 511 нийгмийн ажилтан нийт **798** ажилтан хамрагдаж **63.0** сая төгрөг зарцуулав.

“Нийгмийн халамжийн тухай”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай”, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуулиуд шинэчилсэн найруулгаар батлагдан мөрдөгдөж байгаатай холбогдон уг хуулиудын хүрээнд мөрдөгдөх нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний стандартуудыг боловсруулан батлуулах зорилгоор Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандарт, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах дүрэм, журмуудыг боловсруулан батлуулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 32 дугаар тушаалаар байгуулан ажиллав. Ажлын хэсгээс “Ахмад настны асрамжийн газрын үйлчилгээний стандарт”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн газрын үйлчилгээний стандарт”, “Асрамжийн газрыг магадлан итгэмжлэх, ажил үйлчилгээ явуулах эрх олгох журам”, “Асрамжийн газрын төсвийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Асрамжийн газарт үйлчлүүлэгчийг хүлээн авах, гаргах, шилжүүлэх үйл явцыг зохион байгуулах журам”, Асрамжийн газрын асруулагчид ногдох хоол, хувцас, эм, ариун цэвэр, хичээлийн хэрэглэлийн зардлын норматив”-ын төслийг боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Ахмад настны асрамжийн газрын үйлчилгээний стандарт”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн газрын үйлчилгээний стандарт”-уудын төслүүдийг Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвд батлуулахаар хүргүүлэв.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандартын төсөлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, Стандартчилал хэмжил зүйн үндэсний зөвлөлд хэлэлцүүлэх үүрэг бүхий Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний стандартын техникийн дэд хороог СХЗҮТ-ийн даргын 2006 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн тушаалаар байгуулан ажиллав.

Монголын залуучуудын холбоотой хамтран сонсголын бэрхшээлтэй залуучуудын урлан бүтээсэн гар урлалын бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан нь авъяас, гарын дүйтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, төсөл хөтөлбөрт хамруулах боломжийг нэмэгдүүлэх, тэдний үйл ажиллагааг бусдад сурталчлахад ач холбогдолтой болов.

Өрх иргэдийн амьжиргааны түвшин тогтоох аргачлалыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар байгуулан ажиллав. “Өрх, иргэдийн амьжиргааны түвшин тогтоох аргачлал”-ын үзүүлэлтийн нөлөөллийг судлан, хэрэглэж ирсэн туршлага сургамждаа үндэслэн зарим нөлөө үзүүлж чадахгүй байгаа үзүүлэлтийг аргачлалаас хасах замаар амьжиргааны түвшинг тодорхойлж чадахуйц үзүүлэлтийг оновчтой болгох асуудлаар Нийгмийн хамгаалал, хүний нөөцийн сангаас зөвлөх, зөвлөх үйлчилгээг авч ажиллуулав. Зөвлөх үйлчилгээ нь амьжиргааны түвшингийн үнэлгээний нийт үзүүлэлтийг 7 болгож, Өрхийн амьжиргааны чадавхийн хэмжүүр, Өрхийн эдийн засгийн чадавхийн хэмжүүр, Нийгмийн эмзэг байдлын хэмжүүр гэсэн 3 бүлэгт хуваах санал боловсруулав.

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих Үндэсний хөтөлбөрийн хүрээнд

хэрэгжиж буй “Тогтвортой амьжиргаа” төслийн эхний үе шатны хэрэгжилт дуусч байгаатай холбогдуулан үнэлгээ болон дараагийн шатанд анхаарвал зохих асуудлаар санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлэв. Тогтвортой амьжиргаа төсөл нь Дэлхийн банкны санхүүгийн дэмжлэгтэйгээр 12 жилийн хугацаанд хэрэгжих уян хатан хөтөлбөрийн зээл бөгөөд эхний үе шатны явцад 8 аймагт туршин хэрэгжүүлсэн тогтвортой амьжиргааны стратеги, үйл ажиллагааны ололттой талуудыг цаашид бүх аймагт өргөжүүлэн хэрэгжүүлэх, орон нутгийн чадавхийг бэхжүүлэх зорилготойгоор 2 дугаар шатны төслийг эхлүүлэхээр болсон байна.

2.3. Хүн ам, нийгмийн бүлгүүдийн бодлогын хэрэгжилт, үр дүн:

“Монгол Улсын хүн амын насжилт ба хөгжлийн асуудлууд” үндэсний форумыг НҮБ-ын Хүн амын сангийн санхүү, техникийн дэмжлэгтэйгээр зохион байгуулав. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сайжирч, эмэгтэйчүүдийн боловсролын түвшин дээшлэхийн хирээр Монгол Улсын хүн амын төрөлт 1975-2000 оны хооронд эрчимтэй буурч, төрөлтийн нийлбэр коэффициент ойролцоогоор 7-оос 2.3 болтлоо буурсан байна. Хүн амын хэтийн тооцоогоор 2025 оны эцэс гэхэд 1.85 болох төлөвтэй байна. Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж дээшлэхийн үр дүнд хүн амын дундаж наслалт 56 байснаа 65 болж өссөн. Хүн амын дундаж наслалт дээшилж, 2050 он гэхэд 76 болж нэмэгдэх төлөвтэй байна. Төрөлтийн түвшин буурч, дундаж наслалт өндөржиж байгаа нь Монгол орны хувьд насжилтийн үйл явц явагдаж байгааг харуулж байгаа бөгөөд энэ нь өндөр настай хүмүүсийн буюу 60 ба түүнээс дээш насныхны нийт хүн амд эзлэх хувь нэмэгдэж байна гэсэн үг юм. 2000 оны байдлаар өндөр настай хүмүүс нийт хүн амын 5,8 хувийг эзэлж байна. Энэ хувь 2050 он гэхэд 25.1 болж өсөхөөр байна. Энэ нь дараагийн тавин жилийн дотор Монголын хүн амын дөрвөн хүн тутмын нэг нь 60-аас дээш насныхан байхаар байна. Иймд

- ирээдүйд бий болох хүн амын насжилтын асуудалд анхаарал хандуулж, өнөөгийн байдалд үнэлгээ хийх
- Хүн амын насжилтийн тулгамдсан асуудлаарх шийдвэр гаргагчдын болон олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх
- Монгол улсын нийт хүн амын дотор өндөр настны эзлэх хувь дээшилж байгаатай холбогдон үүсч болох асуудлуудыг шийдвэрлэхэд шаардлагатай стратегийн шинж чанартай бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагааг тодорхойлох

цаашид бий болох хэрэгцээ шаардлага, түүнийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох шаардлагатай байна гэж үзэн энэхүү форумыг зохион байгуулсан юм. Форумд төр, олон улсын, төрийн бус, эрдэм шинжилгээний байгууллагын болон өндөр настны төлөөлөл 70 гаруй хүн оролцсон бөгөөд цаашид дээрх зорилгыг хэрэгжүүлэх асуудлаар зөвлөмж гаргалаа.

Өрх, хүн амын талаарх мэдээллийн сан бүрдүүлэх бүртгэл, ядуурлын туршилтын үзлэгийн үр дүнд үндэслэн санал боловсруулах, үзлэг зохион байгуулах ажлын хүрээнд туршилтын үзлэг зохион байгуулсан газруудаас ажлын тайлан мэдээг авч нэгтгэв.

Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг холбогдох газруудаас авч нэгтгэн, дараагийн шатны бодлого арга хэмжээний талаар саналын хамт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд хүргүүлээд байна. Хөтөлбөрийн хүрээнд “Тэнэмэл амьдралтай иргэдийн түр хоноглох байр”, залуучуудад мэргэжил олгох, дадлагажуулах “Амьдрах ухаан-сургалт үйлдвэрлэлийн тусгай төв”-ийн байрны асуудлыг шийдвэрлэсэн байна. Дээрх

төвүүдийн урсгал зардалд жил бүр тодорхой хөрөнгө мөнгө төсөвлөж байгаа хэдий ч хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаанд хангалтгүйн улмаас хэрэгжилт муу байна.

Түүнчлэн Монголын өрх толгойлсон эмэгтэйчүүдийн “Заюу тайж” нийгэмлэгтэй хамтран тэнэмэл амьдралтай, өөрийн гэсэн гэр оронгүй хэсүүчлэн амьдарч байгаа иргэдийг нийгэмшүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх талаар гэрээ байгуулан хамтран ажиллав. Үүний үр дүнд Барс худалдааны төв дээр хэсүүчлэн амьдарч байсан 4 иргэнд ажлын дадлага олгох сургалтад хамруулж, зохих зөвлөгөө мэдээлэл өгөх замаар хэвийн амьдралдаа эргэн ороход нь дэмжлэг үзүүлсэн байна. Одоо дээрх 4 иргэн Заюу тайж нийгэмлэгийн байранд байрлаж, тэнд хооллож ундалж, эсгийгээр гар урлалын бүтээгдэхүүн хийж ажиллаж байгаа юм. Цаашид үйл ажиллагааг өргөтгөн халуун усны газар, үсчин байгуулж тэнэмэл иргэдэд анхан шатны үйлчилгээ үзүүлж ажиллахаар төлөвлөж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, НҮБ-ын Хүн амын сантай 2007-2011 онд хэрэгжүүлэх 4 дэх хөтөлбөр болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай хамтран хэрэгжүүлэх төслийг эцэслэн боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан ажиллав. Төслийн төлөвлөгөөний дагуу дараахь ажлуудыг зохион байгуулав. Үүнд:

- Дэлхийн хүн амын илтгэлийг түгээх ажлыг зохион байгуулав. Энэхүү илтгэл нь 2007 онд “Хотжилтын нөөц боломжийг ашиглах нь” гэсэн сэдэвтэйгээр хэвлэгдсэн бөгөөд түүнийг олон нийтэд түгээх уулзалтыг 6 дугаар сарын 27-ны өдөр УИХ-ын НББСШУ-ны байнгын хороо, тус яам, НҮБ-ын Хүн амын сан хамтран зохион байгуулав. Түгээх уулзалтын үеэр НХХЯ-наас Монгол Улсын хотжилтын байдал, эрх зүйн орчин, тулгамдаж буй асуудлын талаар, НЗДТГ-аас нийслэл Улаанбаатарт тулгарч буй асуудлууд, шийдвэрлэх арга замын талаар мэдээлэл хийлээ. Энэхүү уулзалтаас цаашид хотжилтын эерэг талыг оновчтой ашиглах, сөрөг талыг бууруулах талаар хэлэлцэн, олон нийтийн анхаарлыг хандуулахад чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг зохион байгууллаа.

- Мэдээлэл, судалгаа, үнэлгээний газартай хамтран “Хяналт-шинжилгээ, үнэлгээ” сэдэвт 2 өдрийн сургалтыг аймаг, нийслэлийн Нийгмийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга нарт зохион байгууллаа. Энэхүү сургалт нь хүн амын асуудлыг хариуцсан орон нутгийн түвшинд ажиллагчдын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хяналт үнэлгээний үр дүнг бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд ашиглах, уялдуулах чадавхийг бэхжүүлэхэд чиглүүлэв. Сургалтад нийт 30 гаруй хүн оролцсон болно.

- “Монголын хүн амын үндсэн үзүүлэлт” мэдээллийн хуудсыг бэлтгэн хэвлүүлэв. Энэхүү мэдээллийн хуудсанд хүн амын тоо, бүтэц, Мянганы хөгжлийн зорилт, хүний хөгжилтэй холбоотой бүхий л үзүүлэлтийг аймаг, дүүрэг, бүсээр тооцож оруулав. Мөн энэ жилийн мэдээллийн хуудсанд Жендэрийн хөгжлийн индексийг шинээр нэмж оруулав. Мэдээллийн хуудас нь мэдээлэл сайтай, хүн амын талаарх бүхий л мэдээллийг нэгтгэн, тайлбартайгаар оруулсан, эх үүсвэр нь тодорхой байгаагаараа ашиглахад хялбар, ач холбогдолтой болсон гэж үзэж болно.

- Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй улс орныг дэмжих 4 дэх хөтөлбөрийн мэдээллийг сайжруулах ажлын хүрээнд ҮСГ-аас зохион байгуулсан “Хүн ам, жендэр, нөхөн үржихүйн талаарх тоо, мэдээлэл, судалгааны үр дүнг бодлого, хөтөлбөрт ашиглах нь” сэдэвт баруун бүсийн зөвлөлдөх

уулзалтад оролцлоо. Тус бүсийн 5 аймгаас зөвлөлдөх уулзалтад оролцсон 48 төлөөлөгчдөөс аймгийн нийгмийн бодлого зохицуулалтын болон хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн ажилтнуудын дунд хүн ам, жендэр, хөдөлмөр, халамжийн чиглэлээр тоо, мэдээлэл, судалгааны хэрэглээ орон нутагт ямар байгаа, цаашид ямар хэрэгцээ байгаа талаар хэлэлцүүлэг зохион байгуулав. Цаашид бүх бүсэд энэхүү уулзалтыг зохион байгуулж тоо, мэдээлэл, судалгааны чанарыг сайжруулах, үр дүнг нь төрийн болон төрийн бус байгууллагууд өргөнөөр ашиглах, бодлого, хөтөлбөртэй уялдуулах чиглэлээр олон улсын байгууллагуудын дэмжлэг тусалцааг авахад чиглүүлж ажиллах болно.

- “Монгол Улсын хүн амын насжилт: Сайн сайхан байдлыг баталгаажуулах нь” товхимлын эхийг бэлтгэн монгол, англи хэлээр хэвлүүлэн түгээв.

Японы Засгийн газрын санхүүжилтээр НҮБ-ын Хүн амын сангаас 2007-2008 онд хэрэгжүүлэх “Гар аргаар алт олборлогч ба шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах төсөл”-ийн үйл ажиллагааг эхлүүллээ. Төслийн зорилго нь үйлчилгээ авч чадахгүй байгаа болон эмзэг бүлгийн хүн амд нийгмийн суурь үйлчилгээ ялангуяа Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламжийг хүртээмжтэй болгосноор тэдний амьдралын чанарыг дээшлүүлж, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм.

Төслийн үйл ажиллагаанд гар аргаар алт олборлогсод олноор ажилладаг Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-Овоо, Галуут сум, Архангай аймгийн Цэнхэр сум, Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан, Уянга сум, Төв аймгийн Борнуур, Сэргэлэн, Сүмбэр, Заамар сум, Сэлэнгэ аймгийн Баянгол, Ерөө, Орхонтуул сум, Дархан-Уул аймгийн Шарын гол сум, шилжин суурьшигчид ихтэй Орхон болон дээрх аймгуудын төв, Нийслэлийн Баянзүрх дүүргийн гэр хорооллын 17 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын 16 дугаар хороо хамрагдаж байна.

Төслийн хүрээнд 2007 онд дараахь ажлыг зохион байгуулав. Үүнд:

- Төслийг салбар, орон нутгийн хэмжээнд уялдуулах, зохицуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Зохицуулах зөвлөлийг, төслийг үйл ажиллагааг нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн тушаалаар тус тус байгуулан ажиллуулав. Зохицуулах зөвлөл нь төв, орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг батлах, хяналт тавих чиглэлээр ажилласан бөгөөд салбарын ажлын хэсэг нь гарын авлага материалын эхийг бэлтгэх, чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах, орон нутаг дахь явуулын үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх зэргээр үйл ажиллагаа явуулав.
- Төсөл хэрэгжүүлэгч, донор, хамтран ажиллах байгууллагын төлөөлөгчдийг оролцуулсан зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж төслийн үйл ажиллагаа, хүрэх үр дүн, хамтын ажиллагаа, төсөл дууссаны дараа үйл ажиллагааг нь тогтвортойгоор үргэлжлүүлэх талаар хэлэлцэв. Энэхүү зөвлөлдөх уулзалтаар ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааг уялдуулах, салбар, төслийн хүрээнд эхэлсэн явуулын үйлчилгээг зохион байгуулахад шаардлагатай хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгаж байх, энэ талаар шийдвэр гаргагчдын дэмжлэгийг авах чиглэлээр ухуулга, нөлөөллийн ажлыг хамтран зохион байгуулж ирлээ. Цаашдаа энэ ажлыг НҮБ-ын Хүн амын сангаас Монгол Улсад хэрэгжүүлж буй 4 дэх хөтөлбөрийн Ухуулга сурталчилгааны стратегид тусгах замаар хөрөнгийн тодорхой хэсгийг шийдвэрлэхээр тогтоод байна.
- Гар аргаар алт олборлогсод болон хотын захын хороололд шилжин суурьшсан бүртгэлгүй, үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдэд нийгмийн суурь тусламж

үйлчилгээг хүргэх зорилгоор эрүүл мэнд, нийгмийн халамж, нийгмийн даатгал, иргэний бүртгэл болон бусад асуудлаар явуулын үйлчилгээ үзүүлэх автомашин, эм хэрэгслийг сонгогдсон аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газарт хүлээлгэн өглөө.

- Төслийг аймаг, дүүрэгт хэрэгжүүлэх ажлын хэсгийн гишүүд, орон нутгийн удирдлагуудад зориулсан чадавх бэхжүүлэх 2 өдрийн сургалтыг сонгогдсон аймаг, дүүрэгт, мөн төв, орон нутгийн түвшинд сургалтын багийг бүрдүүлэх, сургагч багш нарт зориулсан 5 өдрийн сургалтыг 4 удаа зохион байгуулаад байна.
- Эрүүл мэнд, нийгмийн халамж, нийгмийн даатгал, иргэний бүртгэлийн талаар гар аргаар алт олборлогч, шилжин суурьшигчид болон явуулын үйлчилгээ үзүүлэх баг, сургагч багш нарт зориулсан гарын авлага, хялбаршуулсан сурталчилгааны материал бэлтгэн хэвлүүлээд байна.

Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон аймгуудад “Гар аргаар алт олборлогч ба шилжин суурьшигчдын нийгэм, эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах” төслийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг хариуцах удирдлагуудад зориулсан сургалтыг зохион байгуулах, орон нутагт төсөлд хамрагдах зорилтот бүлэгт зориулсан явуулын үйлчилгээг хэрхэн зохион байгуулж байгаа байдалд хяналт тавих ажилд оролцов. Төслийн явуулын үйлчилгээний багийг орон нутагт эрүүл мэнд, нийгмийн халамж, даатгал, иргэний бүртгэлийн ажилтнуудыг оролцуулан зохион байгуулж байгаа бөгөөд эдгээр хүмүүс нь дээрх багц асуудлаар зорилтот бүлгийнхэнд зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх чадвартай болов.

УИХ-аас 2003 онд баталсан Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийг дэмжих талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах Гэр бүлийн хөгжлийг дэмжих Үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулж, түүнийг хэлэлцүүлэх ярилцлагыг 10 дугаар сарын 11-ний өдөр гэр бүлийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагууд, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулав. Оролцогчид гэр бүлийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийн төслийг боловсруулан батлуулах нь зүйтэй гэж үзээд тодорхой саналууд гаргалаа. Энэхүү санал, зөвлөгөөг тусган төслийг боловсронгуй болгосны дараа яамдаас санал авч, НХХ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Төсөлд санал авах зорилгоор Гэр бүлийн радио-104.5-аар “Ултай яриа” шууд нэвтрүүлэгт “Залуу гэр бүлийн бүлийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр оролцож, сонсогч залуучуудын санаа бодлыг авснаас гадна НХХЯ-ны вэб хуудас болон утсаар, захидлаар иргэдийн санал авч тусгалаа.

Хүүхэд бүрийг гэр бүлийн орчинд хүмүүжүүлэх, хамгаалах, хөгжүүлэх бодлогыг боловсронгуй болгох, гэр бүл, эцэг эхийн хүүхдийн төлөө хүлээх үүрэг хариуцлагыг дээшлүүлэх улмаар хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоог хөгжүүлэх асуудалд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилгоор “Монголын үрс-эцэг эхтэйгээ” үндэсний чуулганыг Хүүхдийн төлөө үндэсний газар, Дэлхийн Зөн олон улсын байгууллагатай хамтран Улаанбаатар хот, Баян-Өлгий, Баянхонгор, Хэнтий, Өвөрхангай аймгийн төвд 2007 оны 3 дугаар сарын 08-ны өдөр нэгэн зэрэг зохион байгууллаа. Үндэсний чуулганд Монгол Улсын Ерөнхий сайд, Дэлхийн Зөн олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгч, УИХ, Засгийн газрын гишүүд, төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөгчид, хүүхдийн төлөөлөгчид оролцож, “Монголын үрс-эцэг эхтэйгээ” жилийн аяны удирдамжийн төслийг хэлэлцэж, батлав.

Аяны хүрээнд эцэг эхээсээ ямар нэгэн хэлбэрээр тусгаарлагдсан хүүхдийг гэр бүлд нь буцаах, ингэснээр хүүхдийн гэр бүлийн орчинд, эцэг эхтэйгээ байх үндсэн эрхийг хангах зорилт дэвшүүлсэн. Энэ зорилтыг хангахаар асрамж, халамжийн

байгууллагад байгаа эцэг эхтэй хүүхдийг гэр бүлд нь буцаахад чиглэсэн төслийг хамтран ажилладаг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх эхлэлийг тавиад байна. Анхны туршилтын төслийг Нялхсын клиник сувилал дээр Италийн Амичи Дэй Бамбини ТББ-тай хамран хэрэгжүүлэх төслийн санал, хамтран ажиллах гэрээний төслийг боловсруулан гарын үсэг зурж үйл ажиллагааг эхлэхэд бэлэн болоод байна.

Хүүхдийн баярыг тохиолдуулан 5 дугаар сарын 31-нд УИХ-ын эмэгтэй гишүүдийн санаачилгаар олон хүүхэд төрүүлж өсгөсөн, одонтой 1000 гаруй эхчүүдийг хамруулж “Монголын үрс маш олон болтугай” арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд оролцогчдод эх, хүүхдийн эрхийг хамгаалах болон нийгмийн хамгааллын талаар төр, засгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашдын зорилтын талаар илтгэлүүд тавьж хэлэлцүүлэн эхчүүд болон төр, засгийн төлөөлөгчдийн хооронд ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүллээ. Энэ нь эхчүүдийн саналыг нийгмийн хамгааллын салбарын цаашдын бодлого, хөтөлбөрт тусгах, тэдний эрэлт хэрэгцээг илүү мэдрэх боломж олгосон бөгөөд энэхүү арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр сурталчилсан нь олон нийтэд төр засгийн бодлого шийдвэрийг ойлгон мэдрэх, тэдний дэмжлэгийг авах ач холбогдолтой боллоо.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудад Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн Сайдын 2007 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 69 дүгээр тушаалаар батлагдсан ажлын удирдамжийн дагуу төрийн болон ТББ-ын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, дүнг НХХ-ийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв.

Хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад хийсэн хяналт, шинжилгээгээр халамж, асрамжийн төвд байрлаж байгаа хүүхдийн тоог нэг удаагийн тооллого, хяналт үнэлгээгээр гаргадгаас бус мэдээллийн нэгдсэн тогтолцоо байхгүй, хүүхдийн шилжих хөдөлгөөний мэдээлэл байхгүй, халамж асрамжийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тоо, үйл ажиллагаа иргэдэд нээлттэй бус байгаа нь илэрсэн болно. Тиймээс асрамж, халамжийн төвд байгаа хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад нэгдсэн бүртгэл мэдээллийн тогтолцоо зайлшгүй шаардлагатай байгааг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй халамж, асрамжийн байгууллагад бүртгэлтэй хүүхдийн мэдээллийг санг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлээд байна. Ийм мэдээллийн сантай болсноор хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын үйл ажиллагааг хянах, хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, хүүхдийн хамгааллыг сайжруулах ач холбогдолтой. Мэдээллийн сан нь хүүхдийн тоог төрөл бүрийн ангиллаар /нас, бүтэн өнчин, хагас өнчин, эцэг эхтэй, хөгжлийн бэрхшээлтэй, сургуульд хамрагдалт г.м/ гаргаж авах, хүүхдийн шилжих хөдөлгөөнийг хянаж байх, байгууллагын үйл ажиллагааг /гэрт нь буцаахад чиглэсэн, үрчлүүлэхэд чиглэсэн, нийгэмшүүлэх, хөгжүүлэхэд чиглэсэн/ сайжруулахад ашиглагдах юм.

Хүүхдийн халамж, асрамжийн үйлчилгээний стандарт боловсруулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 38 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, сандартын төслийг боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудтай хамтран сандартын төслийг 2008 онд дахин боловсруулах үүрэг өгсөн болно.

Гадаадын иргэдээс хүүхэд үрчлэн авахаар ирүүлсэн нийт 17 хүсэлт, холбогдох

материалыг хүлээн авч, Үрчлэлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулсны үндсэн дээр 8 хүүхдийн үрчлэн авагч эцэг эхэд танилцуулахаар холбогдох байгууллагад санал хүргүүлсэнээр 2007 онд нийт 8 хүүхэд үрчлэгдээд байна. Улс хоорондын хүүхэд үрчлэлтийн асуудлаар хамтран ажилладаг болон энэ талаар мэдээлэл авахыг хүсэгч байгууллагуудыг Гаагийн конвенцоор хүлээсэн үүргийн дагуу мэдээлэл хүргүүлэх, харилцан мэдээлэл солилцох зэргээр хамтын ажиллагааг тогтмол хангаж байна.

Хүн худалдах, хүүхэд эмэгтэйчүүдийг бэлгийн зорилгоор ашиглахтай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 234 дүгээр тогтоолоор батлагдсан Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангах зорилгоор хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих Зөвлөлийн бүрэлдэхүүн болон зөвлөлийн ажиллах журмын төсөл боловсруулж хүүхдийн эрхийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулдаг ЭКПАТ-ын сүлжээ болон ТББ-тай мэдээлэл солилцох зэргээр хамтран ажиллав. Монгол Улсын 2002 онд нэгдэн орсон Хүүхдийн эрхийн конвенцийн Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг нэмэлт протоколын тайлан илтгэлийг Шадар сайдын 2007 оны 36 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгтэй хамтран боловсруулав.

Охидыг албадлагаар гэрлүүлэхийн эсрэг НҮБ-ын Эмэгтэйчүүдийн аж байдлын комиссын 51/3 тоот тогтоолыг хэрэгжүүлэх талаар Монгол улсын төр, засгаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг боловсруулж, ГХЯ-д хүргүүлэв.

УИХ-аас 2003 онд баталсан “Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль”-иар жил бүрийн 5 дугаар сарын 15-ныг Гэр бүлийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж байхаар шийдвэрлэсний дагуу энэ жил олон нийтийн анхаарлыг гэр бүлийн асуудалд чиглүүлэх, гэр бүлийн нийгмийн хариуцлагыг өндөржүүлэх, тэднийг хөгжилд идэвхтэй оролцуулахад чиглэгдсэн мэдээлэл, сурталчилгааны ажлыг төрийн болон ТББ-ууд хамтран хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөнөөр зохион байгуулсан нь гэр бүлийн хөгжлийн чиг хандлага, төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар иргэд, олон нийтийн ойлголт мэдлэг сайжрахад зохих хувь нэмэр өгсөн байна.

Гэр бүлийн хуулийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн хүрээнд гэр бүлийн талаар баримталж буй бодлого, хууль тогтоомжийг судлах, зарим улсын хууль тогтоомжийг харьцуулах ажлыг гүйцэтгэж, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулав.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 60 дугаар чуулганаас баталсан Хөдөөгийн эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ядуурлыг бууруулах зорилтыг макро эдийн засаг, салбарын бодлоготой уялдуулан үндэсний хэмжээнд тодорхойлон хэрэгжүүлж эмэгтэйчүүдийг хамруулах, хөдөөгийн эмэгтэйчүүдэд бичил зээл олгох, эх, нялхсын эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн хамгаалал, халамжийн үйлчилгээг хүртэх ёстой эзэнд нь ойртуулах, дэмжлэгийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг хөдөөгийн эмэгтэйчүүдийн амьдралд гарч буй өөрчлөлт, тэдний сайн сайхан байдлыг хангах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах талаар төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэж, ГХЯ-д хүргүүлэв.

ХЗДХЯ, Шведийн институттэй хамтран “Тэгш эрхийг хангах цогц бодлого” сэдэвт сургалт-семинарыг 6 дугаар сарын 12, 13-ны өдөр зохион байгуулав. Иргэний

нийгмийн байгууллагын 150 гаруй хүнийг хамруулсан энэхүү сургалт-семинарт жендэрийн тэгш байдлыг хангах эрх зүйн орчинг сайжруулах, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх, тэгш эрхийн бодлогын талаар Шведийн туршлага, хүний эрхийг хангах талаарх олон улсын гэрээ, конвенци, гэр бүлийн харилцаа, боловсролын салбар дахь тэгш байдлын талаар 17 илтгэл, мэдээллийг хэлэлцүүлсэн нь оролцогчдод өргөн хэмжээний мэдээлэл өглөө. Илтгэлээр дамжуулан “Тэгш боломж”, “Эцэг эх болох, эцэг эхийн даатгал Шведэд”, “Ажил дээрх жендэрийн болон бэлгийн хүчирхийлэл”, “Тэгш боломжийн Омбудсман” зэрэг материалыг орчуулан оролцогчдод хүргэсэн нь төрийн болон иргэний нийгмийн байгууллагаас жендэрийн талаарх цаашдын бодлого, үйл ажиллагаанд нь тус нэмэр болохуйц гарын авлага болов.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвтэй хүүхэд, эмэгтэйчүүдийн хамгаалах байранд үйлчилгээ үзүүлэх талаар гэрээ байгуулан 5 сая төгрөгийн санхүүжилт олгон, гэр бүлийн болон бэлгийн дарамтлалд өртсөн 50 орчим эмэгтэйчүүд, тэдний 12 хүртэлх насны хүүхдүүдийг байрлуулж, сэтгэлзүйн болон эрхзүйн зөвлөгөөг ганцаарчилсан болон бүлгээр өгөх, бичиг баримтгүй үйлчлүүлэгчдийг бичиг баримттай болоход нь дэмжлэг үзүүлэх, эмнэлэг, эрүүл мэндийн тусламж авахад нь зуучлан тусалцаа үзүүлж байна. Дэмжих бүлгийн сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу харилцааны соёл болон өрхийн орлого нэмэгдүүлэх чиглэлээр явуулж байгаагаас гадна хүүхдийн дэмжих бүлгийг хүүхдийн тусгай хэрэгцээг үндэслэн зохион байгуулж байгаа нь хүүхэд нийгэмших, нийгэм, хамт олонд тулгуурлан өөрсөддөө туслах бүлэгт хамрагдах сайн талтай арга хэмжээ болж байна. Хамгаалах байранд үйлчлүүлэгч эмэгтэйчүүд орлого багатай, эмзэг байдлаасаа болж, гэр бүлийн хүчирхийлэлд өртөмтгий байдаг тул хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байранд зуучлах үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын талаарх мэдээллийг шаардлагатай хүмүүст өгч байна.

Ахмад настны ахуй нөхцөл, нийгмийн хамгааллын арга хэмжээ нь тэдний ядуурлыг бууруулах, амьжиргааны түвшинг дээшлүүлэх бодлоготой уялдаж буй байдал, үр нөлөө, тулгамдсан асуудлыг судлах судалгааны төслийг боловсруулж, 4200 ам.долларын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэв. Уг ажлын хүрээнд судалгааны тендерийг зарлан, Нийгмийн ажлын багш сурагчдын холбоогоор гүйцэтгүүлэх гэрээг байгуулж, судалгааг хийлгэв. Судалгааг Дундговь, Завхан аймаг, Улаанбаатарын Сонгинохайрхан, Багануур дүүрэгт хийж байна. Судалгаанаас Нийгмийн халамж болон Нийгмийн даатгалын салбарын эрх зүйн орчин, төрөөс баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа ахмад настны амьдралд, ялангуяа, ядуурлаас хамгаалах арга хэмжээний үр дүн хэрхэн нөлөөлж байгаа, нийгмийн хамгааллын арга хэмжээний хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах бодлогыг хэрэгжүүлэхэд тэдний өөрсдийн оролцоог хангах, санал бодлыг тусгах арга зам, түүнийг бодлого хөтөлбөрт хэрхэн тусган хэрэгжүүлэх санал, зөвлөмж боловсруулах юм.

**ГУРАВ. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ МАНЛАЙЛАЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ
БОЛОН ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ ТАЛААР АВСАН
АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН**

3.1. Төрийн удирдлагын манлайллыг хангах, үр дүнг дээшлүүлэх талаар:

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр /2005-2008/, эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгавар, яамны төлөвлөгөөт ажлыг хугацаанд нь чанартай ханган биелүүлэхэд газар, хэлтсийн ажлыг нэгдсэн удирдамжаар хангах, ажилтны мэдлэг, боловсрол, мэргэжлийн ур чадвар, бүтээлч, санаачилга, хариуцлагыг дээшлүүлэхэд анхаарч, дэмжлэг, туслалцаа үзүүлж ажиллав.

Яамны аппаратын зөвлөгөөнийг зохион байгуулж, 2006 оны тайланг хэлэлцэн цаашид үйл ажиллагаагаа хэрхэн сайжруулж, үр дүнтэй ажиллах талаар яамны нийт удирдлага, мэргэжилтнүүд санал, бодлоо солилцов. Зөвлөгөөнөөс 2007 онд хийх ажлын чиглэлийг тогтов.

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтын тухай хуулийн дагуу 2007 онд Ерөнхий менежерийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай, нэгжийн менежерүүдийн Ерөнхий менежертэй, төрийн албан хаагчийн нэгжийн менежерүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг 2007 оны 2 сард багтаан зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

УИХ-ын 2007 оны хавар, намрын чуулганаар болон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг газар, хэлтсүүдээс санал авсны үндсэн дээр боловсруулж, УИХ-ын НББСШУБХ болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд сар бүр тодотгол хийж ажиллав.

УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг цаг тухайд нь хэлэлцүүлж байх талаар сар бүр газар, хэлтсийн дарга нар, хариуцсан ажилтнуудад анхааруулж, газар, хэлтсийн дарга нарын шуурхай дээр Дэд сайд, Төрийн нарийн бичгийн даргаар үүрэг өгүүлж ажилласны зэрэгцээ төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээг албан бичгээр болон электрон шуудангаар ЗГХЭГ-т хүргүүлж ажиллав. Тус яам Засгийн газрын хуралдаанаар 2007 онд НХХ-ийн сайдаас санаачилсан, Засгийн газар, УИХ-аас даалгасан нийт 25 асуудал хэлэлцүүлэхээс 14 асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн, 2 асуудлыг СЗХ-аар хэлэлцүүлэн Засгийн газарт оруулж, 2 асуудлыг боловсруулан холбогдох газруудын санал авч, төлөвлөгөөний биелэлт 68.8 хувьтай байна. Засгийн газар, УИХ-аас даалгасан үүрэг даалгаврын хэрэгжилтэд цаашид нийт газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

Үндэсний эв нэгдлийн Засгийн газар байгуулагдсан нэг жилийн болон ажилласан хугацаанд нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр авч хэрэгжүүлсэн бодлого, арга хэмжээний талаарх товч тайлан, Монгол Улсын Ерөнхий сайдын 2007 оны ажлын төлөвлөгөөнд тусгах санал болон Ерөнхий сайдын биечлэн оролцох арга хэмжээний жагсаалтыг тус тус гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын удирдах ажилтны зөвлөлдөх уулзалтыг 2007 оны 2 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулав. Зөвлөлдөх уулзалтад аймаг, нийслэлийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга, яам, харьяа агентлаг, байгууллагын газрын дарга нар оролцож, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын 2006 оны үр дүн, хэрэгжилт, цаашдын зорилтын талаар хэлэлцэн санал бодлоо солилцов.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөг яамны газар, хэлтэс, агентлагуудаас санал авсны үндсэн дээр боловсруулж, НХХ-ийн сайдаар батлуулан ажиллав. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хуралдааныг бэлтгэл хангасны үндсэн дээр 8 удаа зохион байгуулж, төлөвлөгөөт 22 асуудлыг бүрэн хэлэлцүүлж, шаардлагатай асуудлыг Засгийн газарт өргөн мэдүүлж, зарим асуудлаар санал зөвлөмж гаргаж, холбогдох асуудлаар яамны газар, хэлтсийн болон агентлагийн дарга нарт үүрэг даалгавар өгч ажиллав.

Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүн биелэлтийг дүгнэх, мэдээлэх журам”-ын дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг улирал бүр гарган дүгнэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж ажиллав. Тайлант хугацаанд Засгийн газрын тогтоол 56, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 71, Ерөнхий Сайдын захирамж 14, Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар 5, Ерөнхийлөгчийн зарлиг 113-ыг хүлээн авч бүртгэн удирдлагад танилцуулж, өгсөн үүрэг даалгаврыг холбогдох ажилтнуудад өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.

Тайлант хугацаанд Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн захирамж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл зэрэг 84 шийдвэрийн 116 заалтыг хяналтад авч, биелэлтийн явцын мэдээг яамны газар, хэлтэс, харьяа агентлаг, байгууллагуудаас авч нэгтгэн Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолд заасан журмын дагуу хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгөв. Хяналтад авагдсан тогтоол, шийдвэрийн нийт заалтын 90 буюу 77.5 хувь нь бүрэн буюу 100 хувь биелсэн, 26 буюу 22.4 хувь нь 30.0-90.0 хувийн хэрэгжилттэй байна. Ерөнхий биелэлтийн дүн 92.0 хувьтай байна. Үүнээс хууль тогтоомжийн биелэлт 87.5 хувь, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт 92.2 хувьтай байна.

Улсын Их Хурал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, яам, бусад газруудаас боловсруулж ирүүлсэн хуулийн төсөл 81, УИХ-ын тогтоолын төсөл 24, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зарлиг, Захирамжийн төсөл 19, Засгийн газрын тогтоолын төсөл 258, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн 40, Ерөнхий сайдын захирамжийн 7, ТӨХ-ны болон бусад сайдын тушаалын 19 төсөл, нийтдээ 448 шийдвэрийн төсөлд санал боловсруулан холбогдох газруудад хүргүүлж ажилласаны зэрэгцээ яамнаас боловсруулсан УИХ, Засгийн газрын хуралдаанд оруулах материал, тушаал, шийдвэрийн төсөлд санал дүгнэлт өгч, мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллав.

Тайлант хугацаанд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаас 128 батлан гаргасныг бүртгэл хөтөлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. НХХ-ийн сайдын тушаалыг ангилж үзвэл: журам, дүрэм, аргачлал, тариф баталсан, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн зохицуулалттай холбоотой 19; хууль, гэрээ хэлэлцээрийн төсөл

боловсруулах болон төсөл, хөтөлбөрийг зохицуулах ажлын хэсэг, зөвлөл, комисс байгуулах тухай буюу багаар ажиллахыг зохицуулсан 31; гадаад сургалт, семинар, танилцах аялалд оролцох, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотой 16; шагнаж, урамшуулах, зэрэг дэв зэрэг олгох зэрэг үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой 12; ажилд томилох, чөлөөлөхтэй холбоотой 9; тусгай зөвшөөрөл олгох, сунгах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхтэй холбоотой 27; хөрөнгө мөнгөний зохицуулалттай холбоотой 13 тушаал гарсан байна. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 92 тушаалын 119 заалтыг хяналтад авснаас 100 нь 100 хувь бүрэн биелсэн байна. 15 нь 70.0-90.0 хувийн хэрэгжилттэй, 2 нь 30.0-50.0 хувийн хэрэгжилттэй, хэрэгжих хугацаа нь болоогүй 2 заалт байна. Тушаалын биелэлтийн ерөнхий хувь 96,3 байна.

Төрийн нарийн бичгийн даргаас 114 тушаал батлан гаргасныг бүртгэл хөтөлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг ангилж үзвэл: журам, дүрэм баталсан эрх зүйн зохицуулалттай холбоотой 3, хууль, гэрээ хэлэлцээрийн төсөл боловсруулах болон төсөл, хөтөлбөрийг зохицуулах ажлын хэсэг, зөвлөл, комисс байгуулах тухай буюу багаар ажиллахыг зохицуулсан 16; гадаад сургалт, семинар, танилцах аялалд оролцохтой холбоотой 26; цалин шинэчлэн тогтоох, мөнгөн урамшил олгох, түр чөлөө олгох зэрэг үйл ажиллагааны зохицуулалттай холбоотой 27; ажилд томилох, чөлөөлөхтэй холбоотой 14; буцалтгүй тусламж олгох, хөрөнгө мөнгөний зохицуулалттай холбоотой 28 тушаал гарсан байна. Төрийн нарийн бичгийн даргын 13 тушаалын 14 заалтыг хяналтад авснаас 12 нь 100 хувь бүрэн биелсэн, 90.0 хувийн биелэлттэй 1, 30.0 хувийн биелэлттэй 1, биелэлтийн ерөнхий дүн 94.2 хувь байна.

НХХЯ-ны 2007 оны үйл ажиллагаа /бүтээгдэхүүн нийлүүлэлтийн/-ны төлөвлөгөөний төсөл боловсруулж, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдаар батлуулан хэрэгжилтийг хангуулж ажиллав. Төлөвлөгөөний дагуу тус яам нь 2007 онд 7 ангийн 24 бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд оролцвол зохих 164, дотоодын бүтээгдэхүүний ангийн хүрээнд 7 ажил үйлчилгээ хэрэгжүүлэхээс урьдчилсан гүйцэтгэлээр 164 ажил, үйлчилгээний 131 нь чанар, тоо хэмжээ, шалгуур үзүүлэлтээр тавьсан зорилтдоо бүрэн хүрч 100 хувь биелэв. Газар, хэлтсийн дүнгээр 15 ажлын гүйцэтгэл 70-90 хувьтай байна. Харин 15 ажил үйлчилгээний биелэлт 30-50 хувь, 3 ажил тасарч төлөвлөгөөний ерөнхий биелэлтийн хувь 90.6 байна

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд судалгаа, хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байгаатай холбогдуулан Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамнаас хүн ам, хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр боловсруулж шийдвэрлүүлсэн бодлого, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх сүүлийн гурван жилийн тайлан болон бусад холбогдох судалгааг гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

УИХ-аас 2006 оны 7 дугаар сарын 6-ны өдөр батлагдаж, 2007 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн Авлигын эсрэг хууль, түүнтэй холбогдох журам, дүрмийг яам, салбарын хэмжээнд мөрдүүлэх арга хэмжээ авч, дараахь ажлуудыг гүйцэтгэв. Тухайлбал,

Авлигын эсрэг хууль, УИХ-ын 2007 оны 9 дүгээр тогтоолоор баталсан “Албан тушаалтны хөрөнгө, оруулгын мэдүүлгийг бүртгэх, хадгалах журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор Авилгалтай тэмцэх газрын ажилтнаар яамны ажилтнуудад зориулж мэдээлэл хийлгэж, шинээр батлагдсан хуулийг танилцуулж, Хөрөнгө оруулгын мэдүүлгийг хэрхэн гаргах болон анхаарах асуудлын талаар дэлгэрэнгүй мэдээлэл

өгөв. Түүнчлэн АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийг ажилтнуудад танилцуулж, хууль тогтоомжийн дагуу яамны төрийн захиргааны байнга болон түр томилогдсон албан тушаалтнуудаас 2006 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулах ажлыг зохион байгуулав.

Авлигын эсрэг хуулийн 4.1.1, 10.4, 11.2 дахь заалтын дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны байнгын болон түр томилогдсон төрийн захиргааны болон улс төрийн албан хаагчдын хөрөнгө оруулгын мэдүүлгийг 2006 оны байдлаар гаргуулан авч, ХОМ-1, ХОМ-2, ХОМ-3, ХОМ-4 маягтын дагуу тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. Тус яаманд хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгвөл зохих 44 албан тушаалтнаас 40 нь хуульд заасан хугацаанд нь гаргаж өгсөн байна.

Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн албан бичгийн дагуу нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагуудын талаарх холбогдох мэдээлэл, материалыг бэлтгэн хүргүүлэв.

Төрийн байгууллагын хүнд суртлыг багасгах, төрийн үйлчилгээг ил тод, хөнгөн шуурхай болгох, үйлчлүүлэгчид хүрч үйлчлэх зорилгоор мэдээллийг хүртээмжтэй байлгах, үйл ажиллагааг нээлттэй болгох, иргэдийн оролцоог хангах талаар Авлигатай тэмцэх газраас гаргасан 18 заалт бүхий зөвлөмжийг харьяа газруудад хүргүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгов.

Түүнчлэн “Хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны улирлын мэдээ”-г ХОМ-5 маягтын дагуу улирал бүр гаргаж, Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын томилогдсон ажлын хэсэг 2007 оны 10 дугаар сарын 8-12-ны өдрүүдэд тус яаманд ажиллав. Яамнаас авлигатай тэмцэх, хүнд суртлыг халах, ажлын байр шинээр бий болгох талаар зохиож байгаа ажил, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал, байгууллагаас ирүүлсэн албан бичгийн шийдвэрлэлтийн байдал болон Ерөнхийлөгчийн зарлиг, захирамжийн хэрэгжилтийн талаар танилцуулж, холбогдох мэдээ, тайланг гаргаж, ажлын хэсэгт хүргүүлэв.

3.2. Хүний нөөцийн хөгжил, чадавхийг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар гарсан үр дүн:

Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдааныг тухай бүр зохион байгуулж, төрийн албан хаагчийг ажилд сонгон шалгаруулж авах, зэрэг дэв олгох, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах болон төрийн албан хаагчтай холбогдсон маргаан гомдол, санал хүсэлтийг хэлэлцэж, холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажиллав. Тухайлбал,

Яамны сул чөлөөтэй ажлын байранд шинэ ажилтан авах, ажилтнуудыг ажлын хэрэгцээ, дадлага туршлагыг үндэслэн хүний нөөцийг зохистой байршуулж ажиллах талаар тухай бүр Төрийн нарийн бичгийн даргын шийдвэр гаргуулж ажиллав. Төрийн албаны тухай хуулийн Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах тухай 17 дугаар зүйл, Төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөх тухай 24 дүгээр зүйлийн холбогдох заалтуудыг 2007 онд 24 хүнийг ажилд томилох, 15 хүнийг ажлаас чөлөөлөх тушаал гаргасан байна. Түүнчлэн ажлын шаардлагаар 5 хүнийг эрхэлж байсан албан тушаалаас нь чөлөөлж,

өөр нэгжийн албан тушаалд шилжүүлэн томилсон байна.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлт зэргийг үндэслэн түр ажиллаж байсан 12 ажилтныг төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлж, төрийн жинхэнэ албан хаагчаар томилон ажиллуулав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээ болон ажлын хэрэгцээ шаардлагыг үндэслэн сул ажлын байр, албан тушаалыг нөхөх захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, тус яамнаас шалгалтад хамрагдах ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Архангай, Увс, Баян-Өлгий аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс гаргасан орон нутаг дахь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга болон зарим албан тушаалтнуудын томилгооны асуудалтай холбогдсон гомдлыг хэлэлцэж, яамны салбарын зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлж ажиллав.

УИХ-ын 2003 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн байгууллага болон төрийн жинхэнэ албан хаагч, түүнд нэр дэвшигчдийн хооронд төрийн албатай холбогдсон асуудлаар гарсан маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэх журам”-ын дагуу холбогдох мэдээг гаргаж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв. Мөн Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн маягтын дагуу Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, түүний харьяа агентлаг, байгууллагын Ерөнхий менежерүүдийн товч судалгааг гаргаж, хүргүүлэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн албан бичгийн дагуу 2000-2006 онд томилогдсон, чөлөөлөгдсөн ажилтнуудын судалгааг салбарын хэмжээнд гаргаж, нэгтгэн ЗГХЭГ-т хүргүүлэв.

Төрийн албаны нэгдсэн сүлжээ ашиглах болсонтой холбогдуулан төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний 2006 оны тайланг аппарат, харьяа агентлаг, газруудаас гаргуулан авч, нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн ажилтнуудын хувийн хэргийг цэгцлэх арга хэмжээ авлаа. Төрийн албаны зөвлөлөөс улсын хэмжээнд 2007 онд явуулсан “Төрийн албан хаагчийн бүртгэл тооллого”-ын бэлтгэл ажлыг хангаж, 10 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд зохион байгуулав. Тооллогын үеэр яамны нийт төрийн албан хаагчдаас тусгай маягт, асуулгын дагуу бүртгэл, тооллогыг хийж, дүнг Төрийн албаны зөвлөлд хүргүүлэв.

Төрийн албаны салбар зөвлөлөөс Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын хүний нөөцийн талаар авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаатай танилцаж, зарим зөвлөмж чиглэл өгөв. УНДЕГ-аар 2007 оны 12 дугаар 1-ний байдлаар 77 орон тоотой ажиллаж байгаагаас дарга, хоёр дэд дарга нь төрийн захиргааны албан тушаалд хамрагдаж байна. УНДЕГ-т Төрийн албаны тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу төрийн үйлчилгээний албан тушаалаас төрийн захиргааны албан тушаалд шилжих шаардлагатай 52 албан хаагч байна. УНДЕГ нь 2005 оноос хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтантай болсон, хүний нөөцийн бүртгэл хөтлөлт, хөдөлгөөний мэдээллийг сүлжээнд оруулсан, салбарын ажилтнуудын сургалтыг сайн зохион байгуулж байгаа зэрэг сайшаалтай зүйл байв. Гэвч төрийн албаны холбогдолтой мэдээ, мэдээллийг шуурхай гаргаж өгч байх, нийгмийн даатгалын газрын эрх зүйн асуудлыг тодорхой болгох, төрийн захиргааны албан тушаалын статуст шилжих

асуудлыг цаг алдахгүй хийж хэрэгжүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлт өгөв.

Яамны аппаратын ажилтнуудын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшний үнэлгээ, зэрэг дэвийн судалгааг аппаратын хэмжээгээр нэгтгэн гаргаж, дүгнэлт хийсний үндсэн дээр зарим ажилтнуудад зэрэг дэв олгох асуудлаар санал боловсруулж, Төрийн албаны салбар зөвлөлөөр хэлэлцүүлэхэд бэлэн болгоод байна.

Төрийн албан хаагчийн мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх талаар:

Өндөр хөгжилтэй орны их, дээд сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журмын дагуу яамны суралцах хүмүүсийн мэргэжлийн чиглэлийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар тогтоож, хэвлэл мэдээллээр зарлан сонгон шалгаруулалтыг зохион байгуулав. Яамнаас зарласан захиалгын дагуу суралцуулахаар 2 хүний нэрийг дэвшүүлж, БСШУЯ-нд холбогдох материалыг хүргүүлж, шийдвэрлүүлэв.

Удирдлагын академийн Төрийн удирдлагын сургуулийн менежерийн ангид 2, магистрийн ангид 1 мэргэжилтэнг хамруулав. Яамны аппаратын албан хаагчдын хүүхдүүдээс их, дээд сургуульд суралцагсдын судалгаа гаргаж, 6 төрийн албан хаагчийн хүүхдийн сургалтын төлбөрийг 2007 онд төрөөс хариуцан санхүүжүүлэх гэрээг Төрийн сургалтын сантай байгуулж, ажиллав. Яамны төрийн албан хаагч бүр мэдлэг мэргэшлээ дээшлүүлэх асуудлыг үйл ажиллагааныхаа жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллав. Түүнчлэн долоо хоног бүрийн Мягмар гарагт “Мэдээллийн цаг” хийж хэвшүүлэв.

Монгол Улсын Засгийн газар, Австралийн Засгийн газар хооронд хэрэгжүүлж буй “Чадавхийг бэхжүүлэх, жижиг үйл ажиллагааг дэмжих зорилтот хөтөлбөр”-ийн газраас төрийн албан хаагчдын урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, гүйцэтгэлийн менежментийн тогтолцоог сайжруулах, хяналт шинжилгээ, үнэлгээ ба төлөвлөлт зэрэг асуудлаар зохион байгуулсан туршлага солилцох уулзалт семинарт яамны холбогдох ажилтнуудыг оролцуулж, мэдээлэл солилцов.

Дээрх хөтөлбөрийн хүрээнд магистрийн зэрэг олгох сургалтанд тус яамнаас баримтлах тэргүүлэх чиглэлийг баталж, 2009 онд сургалтанд хамрагдахаар өргөдөл гаргасан ажилтнуудын материалыг хөтөлбөрийн газар хүргүүлж, сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулав. Сонгон шалгаруулалтын дагуу Хүн амын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын нэг мэргэжилтэн англи хэлний сургалтанд хамрагдав.

Яамны харьяа агентлагууд Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь салбарынхаа ажилтнуудыг мэргэшүүлэх сургалтыг 3, 7, 14 хоногоор жилийн график гарган зохион байгуулж, байцаагч нарын, санхүүгийн ажилтнуудын гэх зэргээр төрөлжүүлэн хийж хэвшиж, 2007 онд нийт ажилтнуудынхаа 70-80 хувийг сургалтанд хамруулж, мэргэшүүлсэн байна.

Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах талаар:

Яамны аппаратын төрийн албан хаагчдын цалинг 2007 онд 2 удаа нэмэгдүүлэх арга хэмжээ авсан байна. Тухайлбал,

“Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 13 дугаар тогтоолын дагуу яамны төрийн албан хаагчдын албан тушаалын сарын цалин, нэмэгдлийн хэмжээг Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 11 дүгээр тушаалаар шинэчлэн

тогтоож, 2007 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлэв.

Монгол Улсын 2007 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад төрийн албан хаагчдын дундаж цалинг 2007 оны 10 дугаар сарын 1-нээс 250 мянган төгрөг болгохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан Засгийн газраас баталсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 237 дугаар тогтоол, “Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 236 дугаар тогтоолыг тус тус үндэслэн яамны төрийн албан хаагчдын албан тушаалын сарын цалин, нэмэгдлийн хэмжээг Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 117 дугаар шинэчлэн тогтоож, 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдүүлэв.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3., Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар бүлгийн 67.5 дахь хэсгийг үндэслэн “Төрийн албан хаагчид үзүүлэх нийгмийн хамгааллын зарим арга хэмжээ”-ний талаар санал боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 116 дугаар тушаалаар батлуулав. Уг тушаалаар эдийн засгийн өсөлт, инфляцын болон амьжиргааны түвшингийн өөрчлөлттэй уялдуулан яамны аппаратын албан хаагчдад өдөрт олгох хоолны үнийн хөнгөлөлтийг 2000 төгрөгөөр, мөн өдөрт төрийн албан хаагчийн ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлыг 600 төгрөгөөр тус тус шинэчлэн тогтоож, 2007 оны 11 дүгээр сарын 1-ний өдрөөс тооцон олгов.

Төрийн нарийн бичгийн даргаас өгсөн үүргийн дагуу яамны газар, хэлтсийн төлөөлөл бүхий ажлын хэсэг байгуулан ажиллаж, “Нийгмийн хамгаалал-хөгжил” хөтөлбөрийн төсөл боловсруулж, нийт газар, хэлтсийн ажилтнуудад танилцуулж, сайдаар батлуулахад бэлэн болгов. Хөтөлбөр батлагдсанаар Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны төрийн албан хаагчдын мэдлэг мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, тасралтгүй хөгжих таатай орчинг бүрдүүлж, тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллах нөхцөл боломж бүрдэх юм.

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, орон сууцтай болох, нөхцлийг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор яамны 7 ажилтанд тус бүр 7 сая төгрөг, нийт 49 сая төгрөг олгосон байна.

Яамны аппаратын албан хаагчдын ар гэрийн гачигдалтай байдал, тавьсан хүсэлтийг харгалзан 10 ажилтанд ажлын чөлөө олгож, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу төрийн албан хаагч өвчний улмаас мэс засал хийлгэж, удаан хугацаагаар эмчлүүлсэн, төрсөн аав ээж, ах дүү нь нас барсан зэрэг ар гэрт нь гачигдэл тохиолдсон 14 ажилтанд 1.4 сая төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн байна.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2007 оны 137 дугаар тушаалаар яамны ахмадуудад зориулсан тусгай сан байгуулав. Түүнчлэн тус яамнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг Цагаан сарын шинийн нэгэн болон 2007 оны шинэ жилийн ойн баярыг тохиолдуулан 4 удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлсний зэрэгцээ 10 дугаар сарын 1-ний өдөр буюу ахмадын өдрийг тохиолдуулан Сонгино амралтанд 5 хоног амруулав. 2007 онд амьдралын гачигдалтай байдлыг харгалзан 6 ахмадад 490.0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх арга хэмжээ авав.

Газар, хэлтсийн удирдлага, ажилтнуудын саналыг авсны үндсэн дээр аппаратын ажилтнуудын 2007 оны ээлжийн амралтын хуваарийг гаргаж, Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 69 дүгээр тушаалаар батлуулж, ээжлийн амралтыг биеэр эдлүүлэхэд анхаарч ажиллав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын ажилтны өдөр болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын ой, тэмдэглэлт өдрийг тохиолдуулан нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн амжилт гаргасан 210 хүнийг “Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр, 151 хүнийг яамны “Хүндэт жуух” бичгээр шагнаж урамшуулах асуудлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар шийдвэрлүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа яам, харьяа байгууллагын ажилтнуудаас төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах асуудлаар санал боловсруулж, яамны удирдлагад танилцуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өргөн мэдүүлэв. НХХ-ийн салбарт олон жил үр бүтээлтэй, идэвх зүтгэлтэй ажиллаж байгаа 1 хүнийг “Хөдөлмөрийн гавьяаны одон”, 2 хүнийг “Алтангадас одон”, 6 хүнийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар шагнуулах санал, тодорхойлолтыг хамт олны хурлаас гаргаснаас 3 ажилтан “Хөдөлмөрийн хүндэт” медалиар шагнуулсан байна. Түүнчлэн Мэдээлэл, судалгаа, үнэлгээний газрын дарга “Засгийн газрын хүндэт өргөмжлөл”-өөр шагнуулав.

Монгол Улсын хөдөлмөр нийгмийн хамгааллын албыг үүсгэн байгуулж хөгжүүлэх, үндэсний боловсон хүчнийг сургаж бэлтгэхэд өөрийн хүч мэдлэгийг зориулж жинтэй хувь нэмэр оруулж, төрийн сайдаар 20 жил идэвхи зүтгэл үр бүтээлтэй ажилласан М.Лхамсүрэнг Монгол улсын “Гавъяат эдийн засагч” цолоор шагнуулах санал боловсруулж, холбогдох материалын хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт өргөн мэдүүлэв.

Цаг хугацааны нөөц ашиглалт, гадаад дотоод томилолт, үр дүн, :

Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийг сурталчлах, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын хэмжээнд шинээр гарсан хууль тогтоомж, журам дүрмийг таниулах, иргэд хөдөлмөрчдийн санал бодлыг судлах, тэдэнд тайлбар, хариулт өгөх, салбарын байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлаар хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ажилтнууд Булган, Төв, Сэлэнгэ, Хэнтий, Баян-Өлгий, Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл, Говьсүмбэр, Дархан-Уул, Завхан, Орхон, Дундговь, Баянхонгор, Ховд, Өмнөговь, Увс, Дорноговь, Говь-Алтай, Дорнод, Архангай аймгууд, нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт ажиллаж, сумдын ажил байдалтай танилцан, иргэд хөдөлмөрчидтэй уулзаж, төрөөс явуулж буй хөдөлмөр, нийгмийн халамж, даатгал, тэтгэвэр, тэтгэмжийн нэмэгдэл, болон холбогдох хууль тогтоомжийн шинэчлэлттэй холбогдсон асуултад хариулт өгч, салбарын хуулиудыг сурталчлан, заавар зөвлөгөө өгч ажиллав.

Тайлант хугацаанд хөдөө орон нутагт нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын чиглэлээрх хууль тогтоомжийг сурталчлах, бодлогын удирдамжаар хангах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор давхардсан тоогоор 25 ажилтан 21 аймагт 219 хоног албан томилолтоор ажилласан байна.

“Нийгмийн хамгаалал, салбарын хөгжлийн хөтөлбөр” төслийн 2007 оны төлөвлөгөө, олон улсын байгууллагын урилга, яамны зардлаар 33 ажилтан АНУ, БНСУ, Япон, Малайз, БНХАУ зэрэг 23 оронд 3-45 хоногийн хурал, зөвлөгөөн, сургалт

семинар, танилцах аялалд 43 удаа оролцож, мэдлэг чадвар, ажлын туршлагаа дээшлүүлсний зэрэгцээ өөрсдийн хамрагдсан сургалт семинар, танилцсан туршлагын талаар “Мэдээллийн цаг”-аар нийт ажилтнуудад танилцуулж, мэдээлэл хийж хэвшив.

Аппаратын ажилтнуудын цаг ашиглалт, ирцийн бүртгэлд хяналт тавьж ажиллав. 2007 онд 48 ажилтан 254 өдөр буюу 97536 цаг ажиллахаас 5 ажилтан 80 өдөр буюу 640 хүн/цагийн чөлөө авч, 6 ажилтан 51 өдөр буюу 408 хүн/цаг өвчтэй, 1 ажилтан 16 өдөр буюу 128 хүн/цагийн ажил тасалсан байна.

ДӨРӨВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЯВЦ, ҮР ДҮНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ, МЭДЭЭЛЛИЙГ ТАЙЛАГНАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

4.1. Бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх зорилтын хүрээнд:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Сэргээн засалтын үндэсний төвийн 2006 оны үйл ажиллагааны үр дүн, сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн үнэлгээ өгч, дүнг НХХ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Хуралдаанаас агентлагуудын 2006 оны үйл ажиллагааг “ХАНГАЛТТАЙ” гэж үнэлсэн бөгөөд СЗҮТөв 90.0 хувь буюу 4.5 оноо, ХХҮГазар 88.0 хувь буюу 4.4 оноо, УНДЕГазар 81.7 хувь буюу 4.1 онооны биелэлттэй гарлаа.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн НХХЯ-ны Ерөнхий менежер Төрийн нарийн бичгийн даргатай 2006 онд байгуулсан Үр дүнгийн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, хийн үнэлгээ өгч 2007 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн биелэлтийг 84.5 хувь буюу “сайн” гэж үнэлэв. Хуралдаанаас Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2007 онд Ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээг боловсруулахдаа хяналт шинжилгээний дүгнэлтийг тусгахыг Төрийн нарийн бичгийн даргад зөвлөмж болгов.

Төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэхээр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчтай Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн Үндэсний холбоо, Монголын ахмадын холбоо, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ерөнхий менежерүүдийн 2006 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний биелэлтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг НХХ-ийн сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. СЗХуралдаанаас гарсан зөвлөмжийг дээрх байгууллагуудад хүргүүлэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээр Монголын ахмадын холбооны ерөнхий менежер 10 бүтээгдэхүүн нийлүүлэхээр үүрэг авснаас Монголын ахмадын холбооны ерөнхий менежерийн бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ ерөнхий дүнгээрээ 98 хувийн биелэлттэй, 4.9 оноотой гарсан байна. Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны ерөнхий менежер 6 бүтээгдэхүүн нийлүүлэхээр үүрэг авснаас бүтээгдэхүүн нийлүүлэлт ерөнхий дүнгээрээ 83,3 хувийн биелэлттэй, 4,2 оноотой “Сайн” гэсэн үнэлгээтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ерөнхий менежер 5 бүтээгдэхүүн нийлүүлэхээр үүрэг авснаас Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн ерөнхий менежерийн бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээ ерөнхий дүнгээрээ 100 хувийн биелэлттэй, 5 оноотой байв. Төсвийн ерөнхийлөн захирагч ерөнхий менежерийн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь зориулж төсвийн багцаасаа 3 сая төгрөгийн санхүүжилт хийснийг бүрэн зарцуулсан байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагч 2006 онд өөрийн эрхлэх ажлын хүрээнд 21 аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээний дүнг Сайдын зөвлөлийн хуралд танилцуулав. Аймаг, нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн нийтлэг гэрээнд 5 ангийн 24-28 бүтээгдэхүүн тусгагджээ. Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2006 онд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээгээ 12 аймгийн Засаг дарга 90 хувиас дээш хувиар биелүүлж 4,545-4,815 оноо, 9 аймгийн Засаг дарга 83.4-89,8 хувиар биелүүлж 4.170-4,490 оноо, Нийслэлийн Засаг дарга 73.1 хувиар биелүүлж, 3.655 гэсэн оноотой үнэлгээ авлаа. Ийнхүү Нийгмийн хамгаалал, хөдөлмөр, хүн амын хөгжлийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчтай 2006 онд байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүх аймаг, нийслэлийн Засаг дарга нар зохих түвшинд биелүүлсэн байна гэж СЗХуралдаанаас тэмдэглэв.

Говьсүмбэр, Дорноговь аймаг, нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт хүн амын хөгжил, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлтийн талаарх бодлогын зорилт, хэрэгжилтийг хангаж буй байдалд хяналт шинжилгээ хийж, дүнг НХХ-ийн сайдын зөвлөлийн хуралд танилцуулав. Сайдын зөвлөлийн хуралдаанаас эдгээр аймагт хүн амын хөгжлийг дэмжих, иргэдэд хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлэх ажлыг холбогдох бодлого шийдвэр, хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохих хэмжээнд зохион байгуулж байна гэж үзсэн бөгөөд холбогдох ажилтнуудад үүрэг даалгавар өгөв.

Гадаадад ажиллах хүч, мэргэжилтэн гаргаж буй байдалд анализ шинжилгээ хийх ажлын хэсэг, гадаад улс орнуудын туршлага, олон улсын чиг хандлагын талаар интернетээр судалж, гадаадад ажиллах хүч гаргаж буй зарим байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, зуучлагч байгууллага болон зуучлуулагчдын санал бодлыг асуулгаар судалсан болно. Гадаадад ажиллах хүч гаргаж буй байдалд хийсэн анализ-шинжилгээний тайлангийн эхний хувилбарыг боловсруулж, НХХ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахаар бэлтгээд байна

Монгол Улсад зохистой хөдөлмөрийн үзэл баримтлал хэрэгжих нөхцөл боломжийн талаар урьдчилсан дүгнэлт гаргах, анализ шинжилгээг матрицын аргыг ашиглан, үндсэн 4 зорилгын хүрээнд хийж анализ шинжилгээний эхний тайланг бичив. Анализ шинжилгээний тайлан нь зохистой хөдөлмөрийн үндэсний хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилтийн байдал, хэтийн төлөв, санал зөвлөмж гэсэн хэсгүүдтэй бөгөөд энэхүү тайлан нь зохистой ажлын байр, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрлөх үндсэн эрхүүдийн хэрэгжилт, хөдөлмөрчдийн нийгмийн хамгаалал болон нийгмийн түншлэл, гурван талт харилцааны хүрээнд гарч буй нааштай өөрчлөлтүүд болон цаашид анхаарах асуудлуудыг хөндөж, цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг эрчимжүүлэхэд тус дөхөм болох юм.

Нийгмийн даатгалын үйлчилгээний цар хүрээ, чиг хандлага, төлөв байдалд анализ-шинжилгээ хийж, анализ шинжилгээний дүнг СЗХ-аар хэлэлцүүлж, гарсан

шийдвэрийг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд мэдээлэв. Цаашид нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх, даатгалаас үзүүлэх үйлчилгээг сайжруулах чиглэлээр зарим арга хэмжээ авч хэрэгжүү шаардлагатай гэж үзэж, санал зөвлөмж гаргав.

“Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх салбар дундын ажлын хэсгийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалаар байгуулан ажиллуулж, тайлангийн эхний хувилбарыг гарган ажлын хэсгээр хэлэлцэж дахин боловсрууллаа. Мөн уг хөтөлбөрийн хүрээнд Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Тогтвортой амьжиргаа” төслийн хэрэгжилтийн байдалд салбар дундын ажлын хэсэг хяналт-шинжилгээ хийж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулав. “Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөр” хэрэгжиж дууссантай холбогдуулан хөтөлбөрийн хэрэгжилтэд бүхэлд нь хийсэн хяналт шинжилгээний тайланг эцэслэн боловсруулж, Сайдын зөвлөлийн хуралд оруулахаар бэлтгээд байна. Хяналт-шинжилгээний тайланд уг хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд өгсөн үнэлэлт дүгнэлт, цаашид анхаарах зөвлөмжүүд тусгагдсан болно.

“Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд салбар дундын ажлын хэсэг гаргаж хяналт-шинжилгээ, үнэлгээг 2006 онд хийсэн бөгөөд тайлангийн эхний хувилбарыг гаргалаа. Энэхүү эхний хувилбарыг дахин нягтлаж эцэслэн боловсруулах ажил хийгдэж байна. Мөн Шадар сайдын ажлын алба, Хүүхдийн төлөө үндэсний газраас зохион байгуулсан аймаг, нийслэлийн хяналт шинжилгээний ажилтнуудад хөтөлбөрт хийгдэж буй хяналт шинжилгээний ажлын явц болон зорилтын хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох талаар танилцуулж, санал солилцов.

НХХЯ-нд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг шийдвэрлэсэн байдалд Засгийн газрын 2006 оны 51 дүгээр тогтоолоор батласан журмын дагуу хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ хийж дүнг НХХ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв. 2007 онд иргэдээс нийт 630 өргөдөл, гомдол ирсэн байна. Өргөдөл, гомдлын дотор эхний хагас жил Засгийн газрын 207 дугаар тогтоол буюу тэтгэврийн зөрүүтэй холбоотой асуудлууд зонхилж байсан бол сүүлийн хагас жилд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тооцох цалингийн дээд хязгаар буюу даатгуулагчийн шимтгэл төлөх хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хязгаартай холбоотой өргөдөл, гомдол зонхилох хувийг эзэлж байна. Мөн орон сууц, гэр хүссэн өргөдөл өмнөх оныхоос хоёр дахин ихэссэн байна. Иргэдийн өргөдөл, гомдлыг барагдуулахтай холбогдуулан дараах зөвлөмжийг өглөө.

- Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын зонхилох хувийг тэтгэвэртэй холбоотой асуудал эзлэж байгаа учир тэдгээр асуудлыг нухацтай судлан үзэж, шаардлагатай мэдээллийг иргэдэд хүргэх, шинээр боловсруулах хууль тогтоомжид тусгах,
- Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хариуг хугацаа хожимдуулах тохиолдол гарч байгааг холбогдох мэргэжилтнүүд анхаарах,

Иргэдийн тавьсан асуудалд хариу өгөхдөө холбогдох бүхий л хуулийн заалтыг тайлбарлан өгч ямар асуудлаар хаана, хэнд хандах, тухайн асуудалтай холбоотой өөр ямар боломжтой хувилбар байж болох талаар мэдээлэл өгч байвал иргэдийн болон шат, шатны албан хаагчдын хувьд олон шат дамжлагагүй, ажил хөнгөрөх сайн талтай байна. Иймээс өргөдөл, гомдол, санал хүсэлтэд өгч буй хариуг чанаржуулах, уг хариултыг боловсруулж буй болон хянаж буй хүмүүс хариуцлагатай хандах хэрэгтэй байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2006 оны эцэс, 2007 оны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг ЗГХЭГ-т хүргүүлэв. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхэлсэн асуудлын хүрээнд шууд хамаарах нийт 28 зорилтын хэрэгжилтийн явц дунджаар 2006 оны байдлаар 76.4 хувийн биелэлттэй, 3.82 оноотой, 2007 оны эхний хагас жилийн байдлаар 82.9 хувийн биелэлттэй, 4.1 оноотой байв. Зорилтуудыг бодлогын хүрээгээр нь ангилвал:

Төрийн удирдлага, иргэний оролцооны бодлогын хүрээнд:

“Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, иргэдийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Засгийн газрын түвшинд баталж мөрдөх эрх зүйн баримт бичгүүд, стандартын шаардлагуудыг шинэчлэн, төрийн үйлчилгээг үр дүнтэй хүртээмжтэй болгох” 1 дүгээр үндсэн зорилгыг хангахад чиглэсэн 1 зорилт 100 хувийн хэрэгжилттэй.

Нийгмийн бодлогын хүрээнд:

- “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллыг сайжруулах зорилтуудыг уялдуулан зохицуулж, айл өрхийн амьжиргааг дэмжихэд чиглэсэн нийгэм, эдийн засгийн цогц бодлого хэрэгжүүлэх.” 2 дугаар үндсэн зорилгыг хангахад чиглэгдсэн 5 зорилтын 3 нь 90 хувь, 2 нь 70 хувийн хэрэгжилттэй,
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг улс орон даяар жигд сайжруулж нэр төрлийг нэмэгдүүлэх, иргэд, хамт олны идэвхтэй оролцоонд тулгуурлан хүн амыг эрүүл байлгах, орчин үеийн дэвшилтэт оношлогоо, эмчилгээний аргыг эрчимтэй нэвтрүүлэн эрүүлжүүлэх замаар дундаж наслалтыг уртасгах, хүн амын эрүүл мэндийг сайжруулах, спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх үндсэн зорилгыг хангахад чиглэгдсэн 1 зорилт 90 хувийн хэрэгжилттэй,
- Нийгмийн даатгалын төрөл, сонголтыг нэмэгдүүлэх, нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах баталгааг сайжруулах, эмзэг хэсэгт үзүүлэх халамж, үйлчилгээг чанартай хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурал, ажилгүйдлийг багасгах үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн 21 зорилтоос 100 хувийн биелэлттэй 9, 90 хувийн биелэлттэй 2, 70 хувийн биелэлттэй 8, 50 хувийн биелэлттэй 1, 30 хувийн биелэлттэй 1 байна.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтуудыг 2006 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд НХХ-ийн сайдын хариуцан хэрэгжүүлэх 4 зорилтын хүрээнд 22 арга хэмжээний хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Сангийн яаманд хүргүүлэв. Эдийн засаг, нийгмийг 2006 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлт дундажаар 80,0 хувь үүнээс 100 хувийн биелэлттэй 11, 70 хувийн биелэлттэй 5, 50 хувийн биелэлттэй 5, 30 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд улирал тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Сангийн яаманд хүргүүлсэн болно. 2007 оны үндсэн чиглэлд тусгагдсан НХХ-ийн сайдын хариуцан хэрэгжүүлэх 18 арга хэмжээ хэрэгжилт 2007 оны III дугаар улирлын байдлаар 82.0 хувьтай байв. Үүнээс 100 хувийн биелэлттэй 11, 70 хувийн биелэлттэй 3, 50 хувийн биелэлттэй 3, 10 хувийн биелэлттэй 1 арга хэмжээ байна. Эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн эцсийн дүнг 2008 оны 1 дүгээр улиралд багтаан гаргах болно.

Монгол Улсын Засгийн газраас баталсан Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг 2007 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн Сайдын зөвөлийн хуралдаанаар хэлэлцүүлэв. Хяналт-шинжилгээ, үнэлгээ

хийгдсэн хөтөлбөрүүдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хэрэгжих хугацааны үргэлжлэлээр 95 хувь, 2006 оны хувьд 100 хувийн биелэлттэй, Жендерийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хэрэгжих хугацааны үргэлжлэлээр 57.3 хувь, 2006 оны хувьд 100.0 хувийн биелэлттэй, Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт хэрэгжих хугацааны үргэлжлэлээр 70 хувь, 2006 оны түвшингээр 80 хувийн биелэлттэй, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилт хэрэгжих хугацааны үргэлжлэлээр 86.6 хувь, 2006 оны хувьд 86.6 хувийн биелэлттэй байлаа. Хөтөлбөрүүдийн биелэлтийн дүнг ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын хуралдаанд танилцуулав.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээ эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллагуудад Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн Сайдын 2007 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 69 дүгээр тушаалаар батлагдсан ажлын удирдамжийн дагуу төрийн болон ТББ-ын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, дүнг НХХ-ийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Хяналт үнэлгээгээр хүүхдийг бичиг баримтжуулах, суурь боловсролд хамруулах, хүүхдийн амьдрах, сурах, хөгжих таатай орчинг бүрдүүлэх, шаардлагад нийцсэн хувцас, хоол хүнсээр хангах зэрэг хүүхдийн үндсэн эрхийг хэрэгжүүлэх талаар нааштай олон зүйлс байгаагийн зэрэгцээ дутагдал, бэрхшээл ч байгааг илрүүлсэн. Хүүхдийг гэр орноос нь дайжуулан төвдөө байрлуулах, нийгэм хамт олноос тусгаарлах, эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй орон байр, хоол хүнсээр хангах, хүүхдийг шашны зан үйлд хэт их татан оролцуулах, дотооддоо үрчлүүлсэн хүүхдэд хяналт тавихгүй байх, гадаадын иргэн, гэр бүлийн асрамжлалд зөвшөөрөлгүйгээр шилжүүлэх зэрэг ноцтой дутагдлууд байгаа нь хяналт шинжилгээний явцад илэрсэн байна. Хяналт үнэлгээний дүн болон цаашид авах арга хэмжээний талаар хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагын удирдлага, ажилтнуудад мэдээлэх, санал солилцох уулзалтыг зохион байгуулав. Цаашид хяналт, шинжилгээний явцад тодорхой зөрчил дутагдал илэрч ажил сайжруулах албан даалгавар өгсөн байгууллагууд болон энэхүү хяналт шинжилгээнд хамрагдаагүй байгууллагуудад 2008 оны эхний хагас жилд багтаан дахин хяналт, шинжилгээ хийж, тайланг танилцуулах, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээг стандартжуулах арга хэмжээг 2008 онд үе шаттайгаар хэрэгжүүлэх нь зүйтэй гэж Сайдын зөвлөлийн хурлаас шийдвэрлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны харъяа агентлаг, байгууллагаас иргэдэд үзүүлж буй нийгмийн хамгааллын үйлчилгээнд хэрэглэгчээс үнэлгээ авах аргачилсан журам болон санал асуулгын хуудсыг боловсруулж, НХХЯ-ны веб сайтад тавихаар бэлтгээд байна.

Дэлхийн банкны “Төсвийн зардлыг хянах” туршилтын төслийн хүрээнд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын багцыг хянах ажлын хэсгийг ахлан ажиллаж, сайдын худалдан авах бүтээгдэхүүний төрөл, түүний өртөгийн тооцоог шинэчлэн гаргаж, яамны удирдах ажилтнуудтай зөвлөлдөх уулзалт хийж эцэслэн хянаж дуусгав. Түүнчлэн Дэлхийн банкны “Эдийн засгийн өсөлтийг дэмжих техник туслалцаа, зээлийн төсөл”-ийн хүрээнд хийгдэж буй чиг үүргийн шинжилгээний ажлын хэсгийг ахалж, газар хэлтэс, ажилтнуудын чиг үүргийг шинжлэхэд төслийн олон улсын болон үндэсний зөвлөхтэй хамтран ажиллав.

4.2. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын мэдээллийн сүлжээг хөгжүүлэх, сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилтын хүрээнд:

Монгол Улсын Мянганы хөгжлийн 1.3 ба 1.4 зорилтын шалгуур үзүүлэлт болох 15-24 насны залуучуудын ажилгүйдлын түвшинг хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн тухайн насны ажилгүй хүний тоо болон хүн амын ажил эрхлэлтийн тайлангийн тоо мэдээлэлд үндэслэн өргөтгөсөн байдлаар сүүлийн 3 жилээр тооцож ҮСГ-т хүргүүлсэн болно. Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан зорилт 1.4-ийг “төв суурин газарт албан бусаар оршин сууж байгаа хүний нийт хүн амд эзлэх хувийн жин” гэсэн шалгуураар хэмжих, уг үзүүлэлтийг тодорхой хугацаанд тусгай судалгаагаар гаргаж байхаар холбогдох байгууллагуудтай тохиролцож, Засгийн газрын хуралдаанд оруулав. “Мянганы хөгжлийн зорилтуудын шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн батлах тухай” УИХ-ын тогтоолын төсөл Засгийн газрын хуралдаанаас дэмжигдэн УИХ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэгдэж байна.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт шинээр гарсан хууль эрх зүйн актууд, зохион байгуулж буй ажлуудын талаарх мэдээлэл, түүний үр дүнгийн талаар товхимлыг “Хяналт шинжилгээ, үнэлгээ” сэдвээр гаргаж холбогдох газруудад хүргүүлэв. Түүнчлэн нийгмийн хамгааллын салбарын 2007 оны үйл ажиллагааны гол үр дүнг нэгтгэн товхимол хэлбэрээр хэвлүүлж УИХ, Засгийн газрын гишүүд болон бусад төрийн байгууллагуудад хүргүүллээ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын 2006 оны үйл ажиллагааны тайланг бичиж, англи хэл дээр хөрвүүлж, 1000 хувь хэвлүүлэн яамны ажилтнууд, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, сумдын нийгмийн ажилтнуудад хүргүүлэв.

Яамны вэб хуудсанд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт шинээр батлагдсан хууль тогтоомж болон мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт нь шинэчлэн оруулав. Мөн вэб сайтын зочны буланд ирүүлсэн санал, хүсэлтэнд тухай бүрт нь хариу өгч ажиллав.

Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний шинэ гарын авлагыг хэвлүүлэн гаргав. Уг гарын авлага гарсантай холбогдуулан яамны нийт ажилтнуудад АХБ-ны “Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр” төслийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 2 өдрийн сургалт, НҮБ-ын ХАС-ын санхүүжилтээр орон нутгийн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан ажилтнуудад 2 өдрийн сургалт тус тус зохион байгуулав.

НХХЯ-ны барилгад засвар хийгдсэнтэй холбогдуулан дотоод мэдээллийн сүлжээг бүрэн шинэчилж, стандартын дагуу суурилуулах, нэмэлт тоноглол хийх ажлыг гэрээний үндсэн дээр “Жинэт” ХХК-аар гүйцэтгүүлж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллав. Түүнчлэн интернэтийн үйлчилгээ үзүүлэгч “Жинэт” ХХК-тай хийсэн гэрээнд хяналт тавин ажиллаж, интернэтийн үйлчилгээг зохих түвшинд хүргэж байгаа эсэхийг программ хангамжын тусламжтайгаар хянаж, сүүлийн хагас жилд үйлчилгээний үнийг хямдруулах талаар тохиролцоонд хүрч ажиллав.

“Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын мэдээллийн удирдлагын тогтолцоо” төслийн тайланг төслийн багтай хамтран гаргаж, яамны удирдлагуудад танилцуулсны үндсэн дээр хүлээн авав. Уг төслийн тайланг үндэслэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын “Халамжийн үйлчилгээний программ хангамж”-ийг боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, программ хангамжийг боловсруулах ажил хийгдэж байна. Мөн салбарын мэдээллийн удирдлагыг сайжруулахад шаардагдах тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, тэдгээрийг нийлүүлэх компанийг

сонгон шалгаруулж ажилд нь оруулаад байна. 2008 онд яам, агентлагаас эхлээд сумын нийгмийн ажилтан хүртэл бүх шатанд шаардлагатай программ хангамж бүхий тоног төхөөрөмжийг нийлүүлж, мэдээллийн удирдлагын сүлжээний эхний үе шатыг гүйцэтгэх болно.

Яамны вэб хуудас, Windows, MS Word, MS Excel, MS Powerpoint программууд болон интернэтээс мэдээлэл хайх зэрэг сэдвүүдээр яамны ажилтнуудад зориулан 4 удаа сургалт зохион байгуулав. Эдгээр сургалт нь яамны ажилтнуудад хамгийн өргөн хэрэглэгддэг мэдээллийг хялбар үйлдлээр гүйцэтгэх чадвар эзэмшүүлэх зорилготой бөгөөд тэдний компьютер ашиглах чадварыг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.

Яамны компьютер техник хэрэгсэл болон компьютерийн дотоод сүлжээнд гарсан гэмтлийг тухай бүрт нь засаж, хэвийн ажиллагааг хангаж ажиллав. Ажилтнуудын ашиглаж байгаа компьютер, принтер болон бусад техник хэрэгсэлийг шинэчлэх санал боловсруулж, холбогдох албан тушаалтнаар зөвшөөрүүлэн, техник хэрэгсэлийн үнийн саналыг санхүүгийн хэлтэст хүргүүлэв

ТАВ. ТӨСӨВ, ХӨРӨНГИЙН НӨӨЦИЙН УДИРДЛАГА, ҮР ДҮН:

Тайлангийн хугацаанд Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, Монгол улсын 2007 оны төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжинд нийцүүлэн төсвийн орлого бүрдүүлэлт, санхүүжилтийн хуваарилалт, урсгал зардлуудын гүйцэтгэлийг аймаг, нийслэл болон харъяа салбар төсөвт байгууллагуудаас авч төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаар нэгтгэгдсэн тайланг боловсруулав.

“Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч харьяа газар, агентлагийн төсвийн эрх захирагч нартай 2007 оны үр дүнгийн гэрээ, мөн аймаг, нийслэлийн Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг тус тус байгуулан ажиллалаа. Үр дүнгийн болон бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд харьяа газар, агентлагийн ерөнхий менежер салбарын төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлэх бүтээгдэхүүнүүдийг тодорхойлон тусгаж 2007 онд ямар үр дүнд хүрэх, уг бүтээгдэхүүнийг ямар үнээр нийлүүлэх талаар харилцан тохиролцож гарын үсэг зурлаа. Ийнхүү Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын төсвийн Ерөнхийлөн захирагчийн өмнө бүтээгдэхүүн нийлүүлэх талаар Засаг даргын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож үр дүнг үнэлж дүгнэх нь аймгийн хүн амд үзүүлэх төрийн болон нийгмийн үйлчилгээний хүртээмж чанар, үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой юм.

Санхүүгийн ажилтнуудын мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих, хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх ололт амжилтыг бэхжүүлэх зорилгоор ажлын зөвлөмж гарган харъяа газруудад хүргүүлж хийгдсэн ажил авсан арга хэмжээний талаар улирал бүрийн мэдээг нэгтгэн батлагдсан төсөвт зардлын хэмжээнд гүйлгээг гаргаж ажиллав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харъяа төв орон нутгийн төсөвт байгууллагуудын тусгай сангуудын болон үйл ажиллагааны санхүүжилтийн хуваарийг байгууллага бүрээр зардлын зүйлээр салбар бүрээр хэрэгжүүлэн хөрөнгө оруулалт, их засвар, тоног төхөөрөмжинд зарцуулах хөрөнгийн хуваарийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлэн шийдвэрлүүлж,

батлагдсан төлөвлөгөөний дагуу арга хэмжээнүүдийг санхүүжүүлж ажиллав.

Төсвийн ерөнхийлөн захирагч 2007 онд нийт 438.4 тэрбум төгрөг захиран зарцуулах батлагдсан төсвөөс 249.2 тэрбумыг НДСангаар олгох тэтгэвэр тэтгэмжинд, 120.8 тэрбумыг нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжинд, 805.8 сая төгрөгийг хөнгөлттэй нөхцлөөр тэтгэвэр тогтоолгосон иргэдэд олгох нөхөн олговорт, 11,0 тэрбумыг ХЭДСангаар, 56.6 тэрбум төгрөгийг ерөнхий үйлчилгээний бусад зардалд зарцуулахаар тус тус төсвийг хуваарилан зарцууллаа.

Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, босго үнэ батлах тухай Засгийн газрын тогтоолын дагуу нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 2,9 тэрбум төгрөгийн хөрөнгө тусгагдсанаас 1,6 тэрбумыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын хөрөнгө оруулалтанд, 1,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг шинээр барих барилга байгууламжинд 856,5 сая, их засварт 234,0 сая, тохижилт тоног төхөөрөмжинд 227,5 сая төгрөгийн ажил гүйцэтгэлээ.

Монгол Улсын Засгийн газраас олон улсын хөгжлийн ассоциотай байгуулсан Монгол улсыг хөгжүүлэх хөгжлийн гэрээний дагуу Засгийн газрын санхүүжилт болох өрхийн амжиргааны чадавхийг дэмжих хөтөлбөрийн “Тогтвортой амжиргаа” төслийн үйл ажилгаанд 218,0 сая төгрөг, Хөдөлмөрийн нийгмийн зөвшилийн гурван талт үндэсний хорооны хөтөлбөрөөрт арга хэмжээнд 8,0 сая, Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгэгч Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны хөтөлбөрт арга хэмжээнд 12,0 сая, яамны төвлөрсөн арга хэмжээнд 72,0 сая төгрөг, Эмэгтэйчүүдийн холбоонд 4,8 сая, Хүчирхийлийн эсрэг төвд 5,0 сая, Монголын хөгжлийн бэрэхшээлтэй иргэдийн байгууллагууд болон монголын хараагүйчүүдийн үндэсний холбоодын үйл ажиллагаа, Хөгжлийн бэрхшээлийн нийгмийн хамгааллын хүрээнд 9,4 сая, Тэнэмэл амьдралтай иргэдийн арга хэмжээнд 2,0 сая, НХХЯ, БНСУ-ын хөдөлмөрийн яам хооронд байгуулах хамтын ажиллагаа БНСУ-д ажиллах хүч илгээх тухай хэлцэлт оролцогч төлөөлөгчдийг хүлээн авах арга хэмжээнд 8,5 сая, ОУХБ-ын Женевийн бага хурал болон бусад арга хэмжээнд 22,1 сая төгрөгийг тус тус хуваарилан Сангийн яамнаас баталсан санхүүжилтийн эрхийн баталгааны дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллав.

Тус яамнаас 2007 онд хүн амын хөгжлийг дэмжих, айл өрхийн орлогыг нэмэгдүүлэх, нийгмийн халамжийн үйлчилгээг өргөжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр тэтгэмжийн доод хэмжээг нэмэгдүүлэхэд улсын төсөвт нэмж шаардагдах төсвийн төслийг боловсруулан Засгийн газар, УИХ-аар оруулж хэлэлцүүлснээр төсвийн тодотголоор 39.4 тэрбум төгрөгийг нэмэгдүүлэв.

“Монгол Улсын 2007 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” Сангийн сайдын 2007 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн тушаалын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн 2007 оны төсвийн хуваарийг боловсруулан Сангийн яаманд хүргүүлж, арга хэмжээний санхүүжилтийг цаг хугацаанд нь төлөвлөгөөний дагуу санхүүжүүлэн гүйцэтгэлийн мэдээ тайланг нэгтгэн гаргаж, тайлагнан ажиллав.

Монгол Улсын хөгжлийн дунд хугацаанд хэрэгжүүлэх Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны баримтлах үндсэн чиглэл, төсвийн төслийг боловсруулан Засгийн газарт оруулж 2008 онд хэрэгжүүлэх төсвийн багцын орлого 98.0 тэрбум,

урсгал зардлыг 457.4 тэрбум төгрөгөөр батлагдсаныг салбар нэгж бүрээр сар, улирлын хуваарилалт хийж, Сангийн яаманд хүргүүлэв.

Төв аймаг, Говьсүмбэр аймаг, БЗД-ийн Хөдөлмөр халамжийн хэлтсийн төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилгын ажлын гүйцэтгэлийг газар дээр нь очиж шалган зааварлаж зөвлөгөө өгч ажилсаны үр дүнд хугацаанд нь ашиглалтанд оруулж онд нь багтааж санхүүжилтыг бүрэн олголоо.

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хэрэгжүүлэх зорилгоор яамны ахмад настанд зориулсан тусгай санг НХХ-ийн сайдын тушаалаар байгуулав. Тусгай сантай болсноор яамнаас өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудад тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх боломжтой боллоо.

Яамны эд хөрөнгийн 2006 оны жилийн эцсийн тооллогыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүртгэлийн судалгаа гаргав. Бүртгэлд ороогүй байсан 27.7 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд авав. Түүнчлэн НХХЯ-ны албан хэрэгцээнд зориулан худалдан авсан 24.5 сая төгрөгийн үнэ бүхий 03-258 УБЗ дугаартай Соната НФ маркийн автомашин, 65.5 сая төгрөгийн үнэ бүхий 06-44 УБЗ дугаартай Тоёото Ландкрузер маркийн автомашин, 23.5 сая төгрөгийн үнэ бүхий 05-88 УБЗ дугаартай, Соната НФ маркийн автомашинууд, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн үйл ажиллагаанд ашиглаж байсан 17.0 сая төгрөгийн үнэ бүхий 03-24 дугаартай УБЗ дугаартай Хьюндай Терракан маркийн автомашиныг яамны үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэж, балансанд тусгуулах шийдвэр гаргуулав.

Тус яамны нягтлан бодох бүртгэлийг олон улсын няглан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн Сангийн яамнаас хэрэгжүүлж буй “PLASTIC-7” тайлангийн нэгтгэлийн программ хангамжийг ашиглан хагас жилийн тайланг нэгтгэлд оруулж хэрэгжүүлээд байна. Бүртгэлийн программ хангамжийн шинэчлэлтэй холбогдуулан яам болон агентлагийн нягтлан бодогч нарыг оролцуулсан сургалтыг Сангийн яамтай хамтран зохион байгуулж, бүртгэл санхүүг нэгдсэн нэг стандартын программ хангамжинд оруулах талаар дэлгэрэнгүй мэдээлэл өглөө.

Хэлтсийн ажилтнууд мэргэжил мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр Дэлхийн банк, Монгол Улсын сангийн яамнаас хамтаран зохион байгуулсан “Хөрөнгийн үнэлгээний” сургалт, АХБ-ны “Засаглалын шинэчлэлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-өөс зохион байгуулсан “Бүтээгдэхүүний өртөг тооцолт, бүтээгдэхүүнээр болон аккруал сууриар өртөг тооцож төсөвлөх нь” сургалт, Сангийн яамнаас зохион байгуулсан “Дунд болон богино хугацааны төсвийн төлөвлөлтийг сайжруулах нь” сургалт, Дотоод аудитторын сургалт, “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаандах авилгалаас урьдчилан сэргийлэх тухай” сургалтуудад тус тус хамрагдав.

ЗУРГАА. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт гадаад орон, олон улсын байгууллагатай хэрэгжүүлэх хамтын ажиллагааг яамны болоого, стратегитай уялдуулан хөгжүүлэх, өргөжүүлэх, гадаад харилцааны үр өгөөжийг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа.

Хоёр талт болон олон хамтын ажиллагааны талаар:

“Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” 2007 оны 3 дугаар сараас хэрэгжиж эхэлснээр Солонгост ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн нийгмийн даатгалын асуудлыг шийдвэрлэхэд чухал ахиц гарлаа. Энэ хүрээнд Солонгост ажиллаж байгаа монгол иргэд Солонгост тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөж, Монгол Улсын тэтгэврийн даатгалд хамрагдаж, шимтгэлээ банкаар дамжуулан төлж байна. Мөн Солонгост ажиллаж байх хугацаандаа тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байсан манай 5000 гаруй иргэдийн мөнгийг Солонгосын талаас шилжүүлэн авахаар тохирч, тэдгээр иргэд Улсын нийгмийн даатгалын ерөнхий газраар дамжуулан мөнгөө авч эхлээд байна.

БНСУ-ын Хөдөлмөрийн яамны Гадаадаас ажиллах хүч хүлээн авах албаны төлөөлөгчид болон БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн агентлагийн зөвлөх мэргэжилтнүүдийн Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын ёслолын ажлыг гүйцэтгэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын урилгаар БНТУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга ноён Энис Еэтэрийн 2007 оны 4 дүгээр сарын 4-7-нд Монгол Улсад хийсэн айлчлалыг амжилттай зохион байгуулав. Айлчлалын үеэр Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Дэд сайд С. Чинзориг хамтын ажиллагааны талаар тодорхой санал дэвшүүлж, Туркийн тал шинээр байгуулах Хөдөлмөрийн биржид ажиллах боловсон хүчнийг бэлтгэх, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар, Стамбул хотын Нийгмийн даатгалын газрын хамтын ажиллагааг эхлүүлэх, барилгын мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн багш, сургагч нарыг бэлтгэх чиглэлээр хамтран ажиллах талаар харилцан тохиролцоонд хүрэв.

Дээрх тохиролцооны дагуу БНТУ-ын Хөдөлмөрийн яамны харъяа Хөдөлмөрийн байгууллагаас Анкара хотноо 2007 оны 5 дугаар сарын 28-наас 6 дугаар сарын 3-ны өдрүүдэд зохион байгуулсан “Гадаад, дотоод хөдөлмөр зуучлал” сэдэвт сургалтанд яам болон төв, орон нутгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн 10 ажилтныг оролцуулав.

ОХУ-тай явуулах харилцаа, хамтын ажиллагаанд ихээхэн ахиц дэвшил гарлаа. ОХУ-ын Эрүүл мэнд, нийгмийн хөгжлийн яам (ЭМНХЯ)-тай ажлын шууд хэлхээ холбоо тогтоож, хоёр яамны хооронд хамтран ажиллах тухай санамж бичгийн төслийг харилцан тохиров. ОХУ-ын ЭМНХ-ын сайдын орлогч В.И.Стародубов тэргүүтэй төлөөлөгчид 2007 оны 12 дугаар сарын 4-нөөс 7-нд Монголд Эрүүл мэндийн сайд Д.Туяагийн урилгаар айлчлав. Айлчлалын үеэр оросын төлөөлөгчдийг НХХ-ийн дэд сайд С.Чинзориг хүлээн авч уулзан, хоёр талын салбарын мэдээлэл солилцож, харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар ярилцан санамж бичигт гарын үсэг зурсан нь яам хоорондын хамтын ажиллагаанд чухал алхам боллоо. Санамж бичигт талууд нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудлаар харилцан мэдээлэл, туршлага солилцох, уулзалт зөвлөлгөөн, сургалт зохион байгуулах зэргээр идэвхтэй хамтран ажиллах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасан. Хоёр тал жил бүрийн 12 дугаар сард багтааж дараа онд хэрэгжүүлэх хамтын ажиллагааны арга хэмжээний төлөвлөгөөг тохирч байхаар болов.

Оросын тал хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт өөрчлөлт шинэчлэлтийн олон арга хэмжээ хэрэгжүүлж, арвин туршлага хуримтлуулсан, туршлагаасаа

хуваалцах, мөн түүнчлэн тодорхой асуудлаар ажлын хэсгүүд байгуулж ажиллах санал дэвшүүлснийг анхааралдаа авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Олон жилийн туршид зогсонги байдалтай явж ирсэн хоёр орны хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хамтын ажиллагаа сэргэж, хөгжих сайхан боломж нээгдэж байна.

Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын 7 дугаар хуралдаанд оруулах санал болон 6 дугаар хуралдааны шийдвэрийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлэл бэлтгэж, ГХЯ-нд хүргүүлэв. Түүнчлэн Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн талаар хамтран ажиллах Монгол, Болгарын Засгийн газар хоорондын комиссын 4 дүгээр хуралдаанд оруулах санал болон 3 дугаар хуралдааны шийдвэрийн мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний биелэлтийн талаар ГХЯ-нд мэдээлэв.

Улаанбаатар хотноо 11 дүгээр сард зохион байгуулсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Хөрөнгө оруулалтыг зохицуулах, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих ажлын хэсгийн хуралдаанд яамны төлөөллийг оролцуулж, ОХУ-д жижиг, дунд бизнесийг хэрхэн дэмжиж байгаа байдал, энэ талаар явуулж байгаа бодлого, арга хэмжээний талаар оросын талаас мэдээлэл авч, чанартай ажлын байр бий болгох талаар оросын талтай хамтран ажиллах, хөрөнгө оруулах боломжийг ярилцсан нь манай яамны хувьд чухал ач холбогдолтой боллоо.

Монгол, Унгарын Засгийн газар хоорондын хамтарсан комисс (ЗГХХК)-ийн 2 дугаар хуралдааныг Будапешт хотноо 2007 оны 11 дүгээр сарын 27-ноос 30-нд зохион байгуулах ажилд тус яам голлох үүрэгтэй ажиллав. Хамтарсан комиссын хуралд монголын талаас Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Дэд сайд, Монгол, Унгарын ЗГХХК-ын монголын хэсгийн дарга С.Чинзориг тэргүүтэй төлөөлөгчид оролцов. Энэхүү комиссын хурлын үеэр НХХ-ийн Дэд сайд С.Чинзориг Унгарын НХХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Др.Тарчи Дьюлатай уулзаж, Унгарын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд хатагтай Моника Лампертийг Монголд айлчлахыг урьсан НХХ-ийн сайд Д.Дэмбэрэлийн урилгыг гардуулж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцон ярилцав. Унгарын тал манай талтай яамд хоорондын харилцаа, хамтын ажиллагааг идэвхжүүлэх, яамд хоорондын хамтын ажиллагааны баримт бичиг байгуулах, улмаар Унгарт ажиллаж байгаа монгол иргэдийн нийгмийн даатгалын асуудлыг зохицуулах Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах чиглэлээр ажиллах, Монголоос Унгарт ажиллах хүч авах асуудлыг дэмжиж ажиллахаа илэрхийлэв. ЗГХХК-ын 2 дугаар хуралдааны протоколд хөдөлмөрийн яамд хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, монгол иргэдийн даатгалын асуудлаар хэлэлцээр байгуулах асуудлыг тусгалаа. Мөн комиссын хуралдааны үеэр Монгол, Унгарын Бизнес форум зохион байгуулж, 80 гаруй бизнесийн төлөөлөгч хоёр талаас оролцсон нь чухал ач холбогдолтой арга хэмжээ болов. Хурлын протоколд заасан арга хэмжээг 2008 онд хэрэгжүүлж ажиллах нь чухал зорилт болно.

БНУУ-ын Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын үндэсний газрын Ерөнхий захирал Пириши Карой тэргүүтэй төлөөлөгчид 2007 оны 11 дүгээр сарын 22-27-нд Монгол улсад манай урилгаар айлчилж, манай Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтын ажиллагааны протоколоо шинэчлэн байгуулав. Хамтын ажиллагааны протоколд хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл солилцох, мэргэжилтнүүд харилцан солилцож туршлага судлах, хамтран сургалт зохион байгуулах зэргээр хамтран ажиллахаар тохиролцсон нь хамтын ажиллагаагаа эрчимжүүлж, өргөжүүлэхэд чухал

ач холбогдолтой боллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын Арабын Нэгдсэн Эмират Улсад 2007 оны 11 дүгээр сарын 24-26-нд хийсэн айлчлалын үеэр хоёр тал “Ажиллах хүчний салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулж гарын үсэг зурсан нь чухал арга хэмжээ болов. Энэхүү санамж бичгийг байгуулснаар Монгол улс АНЭУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах ажилчид илгээх боломжтой болж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 4 дүгээр сард Их Британид хийх албан ёсны айлчлалтай холбогдуулан нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт хамтран ажиллах чиглэлээр санал боловсруулж, ГХЯ-нд хүргүүлэв. Тухайлбал, Монгол Улсад иргэний нийгмийн хамгааллын дугаар нэвтрүүлж сүлжээ мэдээллийн тогтолцоо бий болгох зорилгоор туршлага судлах, сургалт зохион байгуулах, зөвлөх урьж ажиллуулах; Нийгмийн үйлчилгээний стандарт боловсруулах, нийгмийн үйлчилгээ эрхэлдэг төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагад мониторинг хийх аргагүйг боловсронгуй болгох чиглэлээр дэмжлэг авах; Их Британийн нийгмийн хамгаалал, хүн амын хөгжил болон хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлийг санал болгов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын БНКазУ, БНКиУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлын хүрээнд Монгол, Казахстаны холбогдох яамдын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнтэй хоёр талын хамтарсан ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж, Казахстаны Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай шууд харилцаа, холбоо тогтоох, цаашдын хамтын ажиллагааны чиглэлийг тодорхойлох талаар санал солилцох, “Нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг эрчимжүүлэх талаар саналаа ГХЯ-аар дамжуулан тавив.

БНКазУлсын Астана хотноо болсон Монгол-Казахстаны Засгийн газар хоорондын комиссын үндэсний хэсгийн дарга нарын зөвлөлдөх уулзалтын бэлтгэл ажлыг хангаж, Монголын талын төлөөлөгчдийг оролцуулав.

БНБУ-ын Хөдөлмөр, нийгмийн бодлогын яамтай 2007 онд хамтран ажиллах чиглэлээр санал хүргүүлэв. Тухайлбал, хамтарсан сургалт, семинар, танилцах аялал зохион байгуулах; ажилгүй иргэдийг ажилд зуучлах, ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн давтан сургалт, ур чадвар олгох сургалтанд хамруулах талаарх бодлого үйл ажиллагаатай танилцах, туршлага, мэдээлэл солилцох зэрэг саналыг төсөлд тусгав.

Кувейт Улсын Эмир Шейх Сабах Ал-Ахмад Ал-Сабах 2007 оны 7 дугаар сарын 30-31-нд Монгол Улсад хийх албан ёсны айлчлалтай холбогдуулан Кувейт Улсад ажиллах хүч гаргах боломж, хүлээн авах бодлого, журмыг судлах; шинээр байгуулагдаж буй Хөдөлмөрийн биржид техникийн туслалцаа үзүүлэх төсөл хамтран хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцээрийн үеэр санал болгов.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2006 онд Япон улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулав. Монгол-Японы Иж бүрэн түншлэлийн хамтын ажиллагааны Мөрийн хөтөлбөрт Японы ЭМНХЯ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулах; Японд монгол дадлагажигчдыг гаргах болон Японоос өндөр мэргэжлийн, тэтгэвэртээ гарсан сайн дурын ажилтнуудыг урьж ажиллуулах боломжийг судлах; Нийгмийн

хамгааллын мастер төлөвлөгөөг нарийвчлан боловсруулахад дэмжлэг авах; ТББ-уудын хооронд холбоо тогтооход дэмжлэг үзүүлэх; ЭМНХЯ, JITCO, JICWELS, JICA, хөдөлмөрийн бодлого сургалтын институт зэрэг байгууллагуудтай тогтмол харилцаа холбоог өрнүүлэх зэрэг асуудлыг тусгуулахаар санал хүргүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Японы жижиг, дунд үйлдвэрийг дэмжих холбоо /ЖИТКО/-ны төлөөлөгчидтэй хийсэн уулзаж Япон улсад үйлдвэрлэлийн дадлагажигч илгээхтэй холбогдон гарч буй бэрхшээл, хүндрэл, тэдгээрийг хэрхэн шийдвэрлэх талаар болон цаашдын хамтын ажиллагааныхаа талаар санал солилцов.

ОХУ-ын Буриад улсын Нийгмийн хамгааллын яамтай хамтран ажиллах талаар санал боловсруулж хүргүүлэв. Хамтран ажиллах санамж бичгийн төсөлд мэргэжилтэн солилцох, сургалт семинар зохион байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тусгай рашаан сувилалын эмчилгээ сувилгаанд хамруулах, нийгмийн солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг асуудлыг тусгаад байна.

Монгол Улс, АНУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 25 жилийн ойг тохиолдуулан хийж буй хэлэлцээний болон хамтран ажиллах баримт бичгийг боловсруулан хүргүүлэв. Хамтын ажиллагааны төслийн баримт бичигт нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарын ажилчдыг богино хугацааны сургалтад хамруулах, нийгмийн үйлчилгээний стандарт боловсруулах, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох, нийгмийн ажилтныг бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг саналыг тусгав.

Тайлангийн хугацаанд дээр дурдсан айлчлалуудаас гадна Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Д.Дэмбэрэлийн Олон улсын байгууллага, Элчин сайдын яамдын төлөөлөгчидтэй хийсэн уулзалтуудын бэлтгэл болон зохион байгуулалтын ажлыг хангаж ажиллав. Эдгээр нь олон талт болон хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд тулгамдаж буй асуудлуудаар санал солилцох, нэгдсэн ойлголтод хүрэх, цаашдын чиглэлийг тохирох талаар тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ байлаа.

Олон улсын байгууллагатай хамтран ажиллах талаар:

НХХ-ийн сайд Д. Дэмбэрэл тэргүүтэй Монгол Улсын Засгийн газар, МҮЭ-үүдийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны төлөөлөгчид 2007 оны 6 дугаар сард Швейцарийн Женев хотноо хуралдсан Олон улсын хөдөлмөрийн бага хурлын 96 дугаар чуулганд оролцох ажлыг зохион байгуулав.

Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 9 конвенцийн тайланг ирэх оны 1 дүгээр улиралд багтаан ОУХБ-д хүргүүлэх шаардлагатай байна. Уг ажлын хүрээнд ОУХБ-ын Олон улсын хөдөлмөрийн стандарт, хөдөлмөрийн хуулийн мэргэжилтэн Тим де Майертай уулзаж, эдгээр илтгэлүүдэд анхаарах, эхний ээлжинд Албадан хөдөлмөрийн тухай 29 ба 105 дугаар конвенцийн хэрэгжилтийн талаархи илтгэлийг бэлтгэх, дараа нь 138, 182, 123 зэрэг конвенцийн талаар мэдээлэл бэлтгэж хүргүүлэх хуваарийг тохиров.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагыг төлөөлж Бээжин дэх салбарын захирал хатагтай Констанс Томас, Засгийн газрыг төлөөлж НХХ-ийн дэд сайд С.Чинзориг, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоог төлөөлж Ерөнхийлөгч Л.Нямсамбуу, Үйлдвэрчний эвлэлүүдийн холбоог төлөөлж дэд ерөнхийлөгч н.Чимэддорж нар

“Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх 2006-2010 оны Орны хөтөлбөр”-т гарын үсэг зурлаа.

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Дүрэмд “ач холбогдолгүй болж хуучирсан олон улсын хөдөлмөрийн зарим конвенцийг ОУХБ-ын гишүүдийн гуравны хоёрын саналаар хүчингүй болгож байх” тухай нэмэлт, өөрчлөлт оруулсан шийдвэрийг манай Засгийн газраас хүлээн зөвшөөрөх тухай асуудлыг боловсруулж, Засгийн газрын 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанд танилцуулав. Хуралдаанаас уг асуудлаг дэмжээд энэ талаар УИХ-ын холбогдох байнгын хороотой зөвшилцөхөөр тогтсоны дагуу УИХ-ын Байнгын хороонд оруулж, зөвшөөрөл гаргуулсан ба дээрх нэмэлт өөрчлөлтийг манай Засгийн газар хүлээн зөвшөөрсөн тухай батламж бичгийг зохих журмын дагуу бэлтгэж, ГХЯ-аар дамжуулан ОУХБ-д хүргүүлэв.

НХХЯ-ны шугамаар “Монгол улсад нийгмийн эрүүл мэндийн даатгалыг сайжруулах талаар салбар хоорондын хамтын ажиллагаа, чадавхийг дээшлүүлэх” төсөл (Project on Scaling Up Capacity and Multi-sector Collaboration to Improve Social Health Insurance in Mongolia)-ийг Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг, ОУХБ, ДЭМБ-ын хамтарсан консорциумтай хамтран хэрэгжүүлэх ажлыг эхлээд байна. Энэ төсөл дээр ажиллах олон улсын зөвлөхөөр ноён Аксел Вэберийн нэрийг дэвшүүлсэн болон түүний ажлын удирдамжийн талаархи ОУХБ-ын саналд дэмжсэн хариу бэлтгэж хүргүүлэв.

ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

7.1.Нээлттэй байдал, мэдээлэл сурталчилгааны талаар:

Монгол Улсын Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт дэвшүүлсэн зорилтуудыг биелүүлэх талаар яам, харьяа газар, агентлагуудаас салбарын хэмжээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зохион байгуулсан олон талт үйл ажиллагаа, тэдгээрийн үр дүнгийн талаар болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хийсэн ажлыг бодитой, үнэн зөв эх сурвалж, тоо баримтад түшиглэн мэдээлж сурталчлах ажлыг зохион байгууллаа.

“Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 97 дугаар зарлиг, Засгийн газрын 2007 оны 190 дүгээр тогтоолоор баталсан журмыг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж, салбарын хэмжээнд хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллав. Энэ удаагийн “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулахдаа **нэгд**, зөвхөн нэг өдрийн арга хэмжээ биш, нэг сарын арга хэмжээ болгон зохион байгуулах, **хоёрт**, энэ үеэр зохиогдох арга хэмжээг хөдөө орон нутагт чиглүүлэхэд ихээхэн анхаарав. Нээлттэй хаалганы өдрийн арга хэмжээг 10 дугаар сарын 1-ээс 20-ны өдрүүдэд зохион байгуулав. Тухайлбал, Дорноговь, Дархан-Уул, Орхон аймагт хамтран зохион байгуулж, орон нутгийн иргэдийн санаа бодлыг сонсох, санал хүсэлтийг шийдвэрлэх арга хэмжээ авав. Түүнчлэн нийгмийн даатгалын болон халамжийн хууль тогтоомжийг сурталчлах, нийгмийн хамгааллын арга хэмжээг иргэдэд ойр хүргэх, санал, хүсэлтийг сонсох, шийдвэрлэх зорилгоор 2007 оны 10

дугаар сарын 10-ны өдөр нийслэлийн Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 9,14 дүгээр хороо, Баянгол дүүргийн 9,10 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 11,13 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 6, Чингэлтэй дүүргийн 18, 16 дугаар хороодод холбогдох мэргэжилтнүүд ажиллаж, иргэдийн санал хүсэлтийг сонсож, сонирхсон асуултад хариулт өгөв. Яамны хэмжээнд нээлттэй хаалганы өдрөөр (1/Х-20/Х хүртэлх хугацаанд) иргэдээс 38 хүсэлт санал хүлээн авч шийдвэрлэсэн байна. 2007.10.20-ны өдөр 22 иргэнийг хүлээн авч уулзан санал хүсэлтийг сонсов. Нээлттэй хаалганы өдрийн хүрээнд хийсэн ажлын тайлан, дүн мэдээг салбарын хэмжээнд нэгтгэн гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн Дэд сайд С.Чинзориг МҮОНТВ-ийн Долоо хоногийн тойм хөтөлбөр, ТВ-9 телевизийн “Энэ өдөр” мэдээллийн хөтөлбөрийн “Ярилцах цаг” булангаар “Цалин, хөлсний системийг боловсронгуй болгох” асуудлаар ярилцлага өгсөн байна. Монголын Үндэсний Радиогийн Хурд агентлагийн шууд нэвтрүүлэг болон Гэр бүлийн радио 104.5-д Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын газрын цалингийн асуудал хариуцсан мэргэжилтэн оролцож цалин, хөлсний системийн шинэчлэлийн асуудлаар мэдээлэл өгч, иргэд, олон нийтийн сонирхсон асуултанд хариуллаа.

“Монгол дахь албан бус хөдөлмөрийн хамрах хүрээ, өнөөгийн байдал”, “Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт” сэдвүүдээр Өглөөний сонин, Зууны мэдээ сонинуудад тус бүр 2 удаагийн цуврал мэдээлэл нийтлүүлэв.

Монгол Улсын Засгийн газраас 2007 оныг “Их бүтээн байгуулалт-Шинэ ажлын байр нэмэгдүүлэх жил” болгон зарласан билээ. Жилийн ажлын нээлтийн ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлахад анхаарч нийт 30-аад хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчдөд зар хүргэж, үндэсний болон чөлөөт радио, телевиз, сонингийн сурвалжлагч нарыг урьж оролцуулан өргөнөөр сурталчлах ажлыг зохион байгуулав. Мөн нээлтийн ажиллагааг Олон нийтийн Үндэсний телевизээр шууд нэвтрүүлэх арга хэмжээ авав. Жилийн турш МҮОН-ийн радиогоор Их бүтээн байгуулалт-шинэ ажлын байр нэмэгдүүлэх жилийн ажлын талаар цуврал нэвтрүүлгүүд байнга хийгдлээ.

7.2. Албан бичиг шийдвэрлэлтийн талаар:

Яамны албан хэрэг хөтлөлтийн ажлыг тусгай программын дагуу явууллаа. Тус яаманд 2007 онд удирдах дээд болон бусад байгууллагуудаас 2217 албан бичиг, эрхийн акт, иргэдийн захидал, хүсэлт хүлээн авч бүртгэж, удирдлагуудад танилцуулж, холбогдох газар, хэлтэст шилжүүлэн шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллав. Тайлант хугацаанд 1402 албан бичигт бүртгэл хяналтын карт нээж, 815 албан бичгийг холбогдох газар, хэлсүүдэд шууд шилжүүлсэн байна.

Хяналтын карт нээсэн албан бичгээс 1390 бичгийн хариуг шийдсэн буюу 99.1 хувийн биелэлттэй байна. Үүнээс 21 бичгийн хугацааг сунгуулж, 316 хугацаа хэтэрч шийдвэрлэсэн байна. Хугацаа нь болоогүй 2, хугацаа хэтэрсэн 10 бичиг, нийт үлдэгдэл 12 байна. Тайлант хугацаанд яамнаас 2282 албан бичгийг бүрдлийг хангаж, холбогдох газруудад хүргүүлсэн байна.

Яамны архивын баримтын нийт хэмжээг гаргах, улсын нэгдсэн тоо бүртгэлд

хамруулах зорилгоор тооллого явуулах ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2007 оны 108 дугаар тушаалаар байгуулан ажиллаж, тооллогын дүнгийн талаар мэдээлэл бэлтгэж, Үндэсний архивын газар хүргүүлэв.

Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр төслийн санүүжилтээр номын сан, архивын өрөөнд шинээр зориулалтын тавилга хийлгэж, номыг төрөлжүүлэн баяжуулж, архивын баримтуудыг он оноор нь цэгцлэх арга хэмжээ авав.

Албан бичгийн шийдвэрлэлтийн байдал

№	Газар, хэлтэс	Хариутай бичгийн тоо	Хугацаан даа хариу өгсөн	Хугацаа болоогүй /үлдэгдэл /	Хугацаа хэтэрч шийдвэр лэсэн	Биелэлтийн хувь
1	Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын газар	375	281	2	92	99.4
2	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын газар	315	250	-	65	100
3	Төрийн захиргааны удирдлагын газар	450	334	3	113	99.3
4	Мэдээлэл, судалгаа үнэлгээний газар	23	18	1	4	95.6
5	Санхүү, эдийн засгийн хэлтэс	125	94	5	26	96.0
6	Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	114	97	1	16	99.1
	Дүн	1402	1073	12	316	99.1

7.3. Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал:

Тайлант хугацаанд яаманд УИХ, ЗГХЭГ, төв, орон нутгийн иргэдээс 653 өргөдөл хүлээн авч, хяналтын карт нээж, шийдвэрлэлтэнд хяналт тавьж ажиллав. Нийт өргөдлийн 430 буюу 65.9 хувьд яамнаас албан бичгээр хариу өгч, 220 буюу 33.7 хувийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагуудад уламжилсан байна. Шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл 3 буюу 0.4 хувь байна.

Иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдлыг ангилвал: 1.4 /9/ хувь нь санал, 1.8 /13/ хувь нь гомдол, 1.7 /11/ хувь нь лавлагаа, 94.9 /620/ хувь нь хүсэлт байна. Иргэдээс тавьсан санал хүсэлт, өргөдөл гомдлын дотор тэтгэвэр, тэтгэмж, нөхөн олговортой холбоотой асуудал 34.6 /226/ хувийг; цалин хөлстэй холбоотой асуудал 4.1 /15/ хувийг; гадаадад ажиллах, суралцах санал хүсэлт 18.0 /118/ хувийг; ахмад дайчин, ахмад настан, ХБИ-ийн нийгмийн хамгааллын асуудал 7.4 /48/ хувийг; орон сууц, гэр олгохыг хүссэн өргөдөл 10.5 /69/ хувийг; ажилд орох, чөлөөлөгдөх халагдсантай холбоотой асуудал 3.4/22/ хувийг; нэг удаагийн буцалтгүй тусламж болон дэмжлэг хүссэн өргөдөл 9.3 /35/хувийг, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, зэрэг нийгмийн бүлгүүдтэй холбоотой асуудал 2.9/19/ хувийг; ҮОМШӨ-ний нөхөн төлбөртэй холбоотой хүсэлт 7.9/52/ хувийг; эм тариа болон эмчилгээний зардалтай холбоотой асуудал 2.2 /14/ хувийг; хууль тогтоомжийн заалтын талаарх лавлагаа болон санал 2.9 /19/ хувийг; хувиараа жижиг, дунд үйлдвэр эрхлэхэд зориулж зээл хүссэн өргөдөл 1.6 /10/ хувийг; төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудал 1.0 /6/ хувийг

эзэлж байна.

Тайлангийн хугацаанд яаманд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газраас 4, Үндсэн хуулийн цэцээс 3, УИХ-ын Тамгын газраас 91, ЗГХЭГ-аас 66, бүгд 164 өргөдөл ирүүлснийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж, дүнг улирал бүр гаргаж, холбогдох газруудад хүргүүлж ажиллав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд 2007 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдалд Мэдээлэл, судалгаа, үнэлгээний газраар анализ-шинжилгээ хийлгүүлж, дүнг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулав.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд 75, Дэд сайд 63 иргэнтэй биечлэн уулзаж, санал хүсэлтийг нь сонсож, шийдвэрлэх арга хэмжээ авав. Иргэд амаар тавьсан хүсэлтдээ ихэвчлэн хүүхдээ буюу өөрсдөө гадаадад ажиллахыг хүссэн, зээл тусламж олгуулах, ажилд орох, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх хүсэлтийг гаргасан байна.

НХХЯ-ны газар, хэлтсүүд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн байдал

№	Газрын нэр	Өргөдөл гомдлын тоо	Ирүүлсэн хэлбэр		Шийдвэрлэлт					Тайлбар
			Амаар	Бичгээр	Шийдвэрлэж хариу өгсөн	Шийдвэрлүүлэх эр бусад байгууллагад	Хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн	Хуульд заасан хугацааг хэтрүүлж шийдвэрлэсэн	Шийдвэрлэх хугацаа болоогүй	
1	Хөдөлмөрийн бодлого, зохицуулалтын газар	182	10	172	42	128	170	-	-	-
2	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын бодлого, зохицуулалтын газар	400	9	391	286	81	367	-	3	-
3	Төрийн захиргааны удирдлагын газар	122	32	90	102	11	113	-	-	-
4	Мэдээлэл, судалгааны үнэлгээний газар	-	-	-	-	-	-	-	-	-
5	Санхүү, эдийн засгийн хэлтэс	-	-	-	-	-	-	-	-	-
6	Гадаад хамтын ажиллагааны хэлтэс	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүн	704	51	653	430	220	650	-	3	-

----- ий -----